



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-62
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	63-171
<hr/>	
1.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	65-72
2.“Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	72
3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	72-75
4.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	75-99
5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай	100-102
Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.	102-119
6.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	119-130
7.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	130-152
8.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	152-155
9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	155-156
10.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	156-157
11.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	157-159
12.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	159-160
13.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	160-171

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Х.Баделхан, Э.Бат-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Д.Ганбат, Г.Ганболд, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Г.Занданшатар, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Г.Мөнхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Цэрэнпунцаг;

Хоцорсон: С.Амарсайхан -05 минут, С.Батболд -35 минут, Ж.Батсуурь -37 минут, Э.Батишугар -55 минут, С.Ганбаатар -03 минут, Ц.Сэргэлэн -12 минут, Ч.Ундрэм -50 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Нэг.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Далай ашиглалт, усан тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын ахлах шинжээч Л.Булганхүү, Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч Ц.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “төмөр замын тээвэр зуучлалын” гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын” гэснийг “өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын” гэж өөрчлөн, 13.3 дахь хэсгийн “зохион байгуулна.” гэсний өмнө “энэ хуулийн 11.1.25-д заасан журмын дагуу” гэж нэмэн, 13.2.3 дахь заалтын “, тусламж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“14.4.Энэ хуулийн 14.1.2, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын зурвас газарт хамаарна” гэснийг “газрыг төмөр замын зурвас газар гэнэ” гэж өөрчлөн, мөн хэсгийн “шугамын” гэснийг болон 17.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 10
Бүгд: 40
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна.” гэснийг “хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй

байж болно.” гэж өөрчлөн, 18.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 11
Бүгд: 40
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 23.3.2 дахь заалтын дугаарыг сольж, 23.3.2 дахь заалтын “тухайн төмөр замын суурь бүтэц” гэснийг болон 23.4.10 дахь заалтын “эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 11
Бүгд: 40
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.2.Улсын хилийн боомт чиглэсэн, хил дамнасан төмөр зам нь нийтийн төмөр замд хамаарах бөгөөд энэ төмөр замын өмчлөгч нь нэг хуулийн этгээд байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгах бөгөөд түншлэлийн хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид галт тэрэг харилцан чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байх;” гэж, 26.1.3 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь энэ хуулийн 25.1-д заасан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гэрээ байгуулсан байх;” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 11
Бүгд: 40
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “өөрчлөхгүй байх зарчим баримтална.” гэснийг “өөрчлөхгүй байна.” гэж өөрчлөн, 31.2 дахь хэсгийн “бусад дэд бүтэцтэй” гэснийг өмнө “энэ хуулийн 31.1-д зааснаас” гэж нэмэн, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг болон Тайлбар тус тус нэмэх:

“31.4.Төмөр замын суурь бүтэцтэй огтлолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

Тайлбар: Энэ хуулийн 31.1-д заасан “бусад төрлийн суурь бүтэц” гэж метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 10
Бүгд: 40
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн гарчгийн “зам” гэснийг “замын үйлчилгээ” гэж, 32.2 дахь хэсгийн “замтай” гэснийг “замын үйлчилгээтэй” гэж, 32.3 дахь хэсгийн “замын холболтын цэгийг” гэснийг “замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан” гэж тус тус өөрчлөн, 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.Салбар замын үйлчилгээнд ачаа ачих, буулгах, сэлгээний хөдөлгөөн хийх, ачаа хүлээн авах, олгох, хадгалах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн “бүрэлдэхүүнд тавигдах” гэснийг “бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлахад тавих” гэж өөрчлөн, 30 дугаар зүйлийн гарчиг, 30.1 дэх хэсгийн “хөдлөх бүрэлдэхүүн,” гэснийг болон “Зөвшөөрлийн тухай хуульд заасан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “газраар” гэснийг дараа “хүн, техник хэрэгсэл” гэж нэмэн, 43.5 дахь хэсгийн “тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах” гэснийг “тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж

хэрэгсэл нь бүртгэл, дугаар, хяналттай байх бөгөөд түүнийг ашиглах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 10
Бүгд: 40
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “тээврийн байгууллага” гэснийг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч” гэж, 44.4 дэх хэсгийн “зорчигч болон ачаа тээврийн тарифыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэснийг “тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 10
Бүгд: 40
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.5, 44.6, 44.7 дахь хэсэг нэмэх:

“44.5.Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд Зөвлөлийн дүрмийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.6.Энэ хуулийн 44.5-д заасан Зөвлөлийн дарга, гишүүнийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

44.7.Зөвлөл нь эдийн засаг, хөгжлийн, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллөөс гадна ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын дугаарыг “26.6” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын дугаарыг “47.2” гэж, 47.1 дэх хэсэг, 47.1.1 дэх заалтын дугаарыг нэгтгэн “47.1” гэж, мөн төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 10
Бүгд: 40
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтыг төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу дэмжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “чиг” гэсний өмнө “суурь бүтцийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “осол” гэсний, 11.1.17 дахь заалтын “салбарын” гэсний, 11.1.10 дахь заалтын болон 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “зориулалттай” гэсний, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2.6 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “аюулгүй байдал” гэсний, 42.2 дахь хэсгийн “дүрэм” гэсний өмнө болон 12 дугаар зүйлийн гарчгийн “Төмөр замын” гэсний дараа “тээврийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.18 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “ажилтан” гэсний, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “ажилтанг” гэсний өмнө “тээврийн байгууллагын” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “хангах” гэсний өмнө “мэдээллээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “сэргийлэх” гэсний өмнө “урьдчилан” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “үйлчилгээ үзүүлэх” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 4.1.19 дэх заалтын “баримт бичгийг” гэснийг “хуваарийг” гэж, 4.1.22 дахь заалтын “сэлгээний ажлыг” гэснийг, “сэлгээний хөдөлгөөнийг” гэж, 4.1.23 дахь заалтын “нэг түвшинд” гэснийг “ижил түвшинд” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “олгох” гэснийг “зэргийг ашиглуулах” гэж, 9.1.5 дахь заалтын “газар олгох, чөлөөлөх” гэснийг “газар эзэмших, ашиглах эрх олгох, газар чөлөөлөх” гэж, 10 дугаар зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.9, 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “ажилтан бэлтгэх, давтан сургах” гэснийг “ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх,” гэж, 10.2.11 дэх заалтын “ажиллагаанд” гэснийг “ажилд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “огтлолцох” гэснийг “нэвтрэх” гэж, 11.1.25 дахь заалтын “техник, технологийн” гэснийг “техникийн” гэж, “хөрөнгийг” гэснийг “эх үүсвэрийг бүрдүүлэх,” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь

хэсгийн “тээврийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан” гэснийг “тээвэрт ашиглагдах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бүсэд хамааруулна” гэснийг “бүс гэнэ” гэж, 16.2 дахь хэсгийн “журмаар тогтоосон дэглэмээс бусад үйл ажиллагаа явуулах, нэвтрэх, объект байруулахыг” гэснийг “журамд тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулахыг” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “сүлжээг хөгжүүлэхэд” гэснийг “сүлжээний төлөвлөлтөд” гэж, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “аливаа этгээдэд” гэснийг “бусдад” гэж, 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийн “журамд” гэснийг “журам, зааварт” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “тээшийг олгох үед” гэснийг “тээшинд” гэж, 36.4.5 дахь заалтын “ачаа” гэснийг “, дутсан ачаа” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн” гэснийг “техник хэрэгсэл, материалын нөөцийн бэлэн байдлыг хангасан” гэж, 42.6.3 дахь заалтын “ачааг” гэснийг “ачаа, тээш, ачаан тээшийг” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Тарифын” гэснийг “Тээврийн тарифын” гэж, “хүчин төгөлдөр болохоос” гэснийг “мөрдөж эхлэхээс” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “дүрэмт” гэснийг “албаны” гэж, 47.1.1 дэх заалтын “олгох;” гэснийг “олгоно.” гэж, 47.1.2 дахь заалтын “тэтгэмж” гэснийг “тусламж” гэж, “зохицуулах;” гэснийг “зохицуулна.” гэж, “дотоод” гэснийг “хөдөлмөрийн дотоод” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь заалтыг, 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “зарим” гэснийг, ТАВДУГААР БҮЛЭГ-ийн нэрийн “ТЭЭВРИЙН” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “төмөр замын суурь бүтцийн” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.3.3, 23.4.1, 23.4.5, 23.4.6, 23.4.7, 23.4.9 дэх заалтын “төмөр замын” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “өмчлөгч,” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “ашиглаагүй үед” гэснийг, 42 дугаар зүйлийн 42.6.3 дахь заалтын “, найдвартай” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “байгууллагын ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана.” гэснийг, 47.1.1 дэх заалтын “төмөр замын тээврийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	9
Бүгд:	40

77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 47 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“47.1.2.үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт ажилтны 1 сарын дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлж олгох.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	15
Бүгд:	40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй буюу зохих ёсоор аваагүй, мэдээлээгүй, ангиллыг буруу тогтоосон, сэргээн босгох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд” гэснийг “алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад болон төмөр замын суурь бүтцийг сэргээн босгох үйл ажиллагаанд” гэж, 2 дахь хэсгийн “талаарх олон улсын гэрээг” гэснийг “дүрэм, журмыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 12
Бүгд: 40
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтын “ердийн хөсөг, тээврийн хэрэгслийг” гэснийг “ердийн хөсгийг” гэж, 4 дэх хэсгийн “Хуулиар хориглосон” гэснийг “Шаардлага хангаагүй” гэж, “хэрэгсэл, технологийг” гэснийг “хэрэгслийг” гэж тус тус өөрчлөн, 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын “байгууламж барьсан,” гэсний дараа “объект байрлуулсан,” гэж, 5 дахь хэсгийн “Суурь бүтцийн” гэсний өмнө “Төмөр замын” гэж, “саад” гэсний өмнө “үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн болон 2, 6 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “ажиллагаа эрхлэхдээ” гэснийг “ажиллагааг” гэж, 7.3 дахь заалтын “шилжүүлсэн” гэснийг “шилжүүлж;” гэж тус тус өөрчлөн, мөн хэсэгт “7.4.бусдын тусгай зөвшөөрлөөр эрхэлсэн” гэсэн агуулгатай заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 29.1.12 дахь заалтын “техник, эдийн засгийн үндэслэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн

“дараах” гэснийг “29.1.12 дахь” гэж, 29.1.12 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “дараах” гэснийг “29.1.1, 29.1.2, 29.1.3 дахь” гэж, мөн зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж, 29.1.2 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөх:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29 дүгээр зүйл” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5, 29.1.6, 29.1.7, 29.1.8, 29.1.9, 29.1.10, 29.1.11 дэх заалт” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг

“тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 9
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “стандарт,” гэснийг болон 4 дүгээр зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төмөр замын зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ, суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр зохицуулсан Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ болон хамт баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэсний дараа дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Л.Мөнхбаатар: “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:31/

Уг асуудлыг 11 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн тавьсан асуултад Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан хариулж, тайлбар хийв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн

байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 20^{1.1} дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20^{1.3}, 29.6 дахь хэсгийн “20^{1.1} дүгээр зүйлд” гэснийг “20^{1.1}, 20^{1.2}-т” гэж өөрчилж, 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, “төслийн 2 дугаар зүйлийн мөн хэсгийн байгууллагын дарга,” гэсний дараа “тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга,” гэж гэснийг, мөн хэсгийн “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэсний өмнө “тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Баттөмөр, Д.Өнөрболор, Н.Учрал, О.Цогтгэрэл, Х.Булгантуяа, М.Оюунчимэг, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Сонгуулийн ерөнхий

хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагааны цаг болсон тул хуралдаан 13 цаг 12 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 30 минутад эхлэв.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дараах хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /14:30/

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; /14:31/

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /14:31/

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль; /14:31/

5.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол. /14:31/

Улсын Их Хурлын гишүүдээс хууль, тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа.

Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-г заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чөлөөлөх саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:47/

Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн А.Адьяасүрэн, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Г.Ганболд, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гишүүн” гэснийг, 3.1.7 дахь заалтын “биет ба биет бус хөрөнгө,” гэснийг, 3.1.14 дэх заалтын “шууд, эсхүл шууд бус” гэснийг болон 3.1.13 дахь заалтыг тус тус хасаж, 3.1.3 дахь заалтын “сонгогдсон” гэсний дараа “, томилогдсон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20

Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “өдрийг” гэснийг “өдрөөс эхлэх жилийг” гэж өөрчилж, 3.1.6, 3.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.6.“намын санхүүгийн тайлан” гэж тайлант хугацаанд намаас энэ хуульд заасны дагуу гаргасан болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан тайлангийн цахим болон хэвлэмэл мэдээллийн бүрдлийг;

3.1.8.“төрийн санхүүжилт” гэж нам чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж, санхүүжилтийн зохих хэсэгт нь төрөөс мөнгөн хэлбэрээр олгож буй санхүүгийн дэмжлэгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дахь заалтын “ард түмний” гэснийг “иргэдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “болон тухайн намыг” гэснийг хасаж, 5.9 дэх хэсгийн “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” гэсний дараа “болон холбогдох бусад” гэж нэмж, 5.10 дахь хэсгийн “үзэл бодлоор” гэснийг “үзэл бодол, боловсрол зэргээр” гэж, 5.13 дахь хэсгийн “үүсгэн байгуулахад оролцохыг” гэснийг “үүсгэн байгуулах, гишүүнээр элсэхийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “24 жилийн” гэснийг “12 жилийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмэх:

“6.8.Улсын дээд шүүхийн Тамгын газар намын нэрийн санг хөтөлж, лавлагаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход болон төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгогдох, томилогдох нэр дэвшигчийг тодруулахад” гэснийг “байгууллагыг бүрдүүлэхдээ” гэж өөрчилж, 8.2.3 дахь заалтын “аль нэг хүйсийн” гэсний өмнө “нэр дэвшүүлэхдээ” гэж нэмж, 8.8 дахь хэсгийг 8.8, 8.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.8.Жендэрийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 01-ний дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

8.9.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 20

Бүгд: 43

53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана” гэснийг “аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно” гэж, 9.7 дахь хэсгийн “Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын” гэснийг “холбогдох хуульд заасны дагуу” гэж, “хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг мэдээлнэ” гэснийг “энэ хуулийн 43.8-д заасныг баримтална” гэж, 9.9 дэх хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-д” гэж, 9.10 дахь хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1-9.6.12-д” гэж тус тус өөрчилж, 9.4 дэх хэсгийн “Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно.” гэсэн эхний өгүүлбэрийг хасаж, 9.6.9 дэх заалтын “намын” гэсний дараа “болон харьяа байгууллагын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.6.4 дэх заалт нэмэх:

“9.6.4.намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “тусгаар тогтнол,” гэсний дараа “бүрэн эрхт байдал,” гэж, 10.1.3 дахь заалтын “гүйцэлдүүлэх” гэсний дараа “үйл ажиллагаа явуулах” гэж тус тус нэмж, 10.1.3 дахь заалтын “үймээн самуун дэгдээх,” гэснийг хасаж, 10.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.4.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18

Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж, 12.2 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 12.3.5 дахь заалтын “хаягийн нотлох баримт” гэснийг “хаягийн мэдээлэл” гэж тус тус өөрчилж, 12.3.7 дахь заалтын “намын санхүүгийн асуудал” гэсний өмнө “намын дарга,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Энэ хуулийн 12.3.6, 12.3.7, 12.3.8-д заасан мэдээллийн маягтыг Улсын дээд шүүх батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.5 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж, 13.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 13.5, 13.6 дахь хэсэг нэмэх:

“13.5.Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана.

13.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.5-д заасан нэрийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж, 14.4 дэх

хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “намын бүртгэлд” гэж, 14.9 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж, “13.1, 14.1-д” гэснийг “12.1, 13.1, 14.1-д” гэж тус тус өөрчилж, 14.3 дахь хэсгийн “гэрчилгээ” гэсний дараа “, тамга тэмдгийн хяналтын дугаар” гэж, 14.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, “баримт бичиг” гэсний дараа “, лавлагаа,” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын гурван өдрийн дотор өргөдөл гаргагчид бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.7, 14.11 дэх хэсэг тус тус нэмэх:

“14.7.Энэ хуулийн 12.2, 12.3, 12.4, 13.7, 15.3, 21.1, 21.4-т заасан болон бусад мэдээлэл, баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийг холбогдох бусад байгууллагад хүргүүлэх журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, сонгуулийн төв байгууллагын дарга хамтран батална.

14.11.Намыг бүртгэхтэй холбоотой журмыг сонгуулийн төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн Улсын дээд шүүх батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах”

“15.4.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 15.3-т заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж энэ тухай нийтэд мэдээлж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 17.2.2 дахь заалтын “жил тутам” гэснийг “жилийн хугацаанд” гэж, 17.2.2 дахь заалтын “болон” гэснийг

“бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах” гэж тус тус өөрчилж, 17.3 дахь хэсгийн “Намын дүрэмд заасан тохиолдолд” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.4.Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг тус тус нэмэх:

“19.4.Нам бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Энэ хуулийн 19.4-т заасан хороо нь нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-д заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана:

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ

хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.6 дахь хэсэг нэмэх:

“21.6.Энэ зүйлд заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсний дараа “сонгуулийн төв байгууллага” гэж нэмж, 22.2 дахь хэсгийг 22.2, 22.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 23.1, 24.1-д заасан шийдвэрийг хүлээн авснаас, эсхүл 25.3-т заасан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн намыг бүртгэлээс хасаж гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоно.

22.3.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгасан тухай шийдвэр, шаардлагатай бусад мэдээллийг сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдэд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчилж, 24.2 дахь хэсгийг 24.2, 24.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.2.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу шийдвэр гарсан бол татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

24.3.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 24.2-т заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийг иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж өөрчилж, 25.3 дахь хэсгийн “шийдвэр гаргаж,” гэсний дараа “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж нэмж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай үндэслэл бүхий санал гаргаж, холбогдох нотлох баримт, хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “энэ хуулийн 36.3-т заасан” гэснийг “энэ хуулиар зөвшөөрсөн” гэж, 26.4 дэх хэсгийн “үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар” гэснийг “үйл ажиллагаанд” гэж, 26.8 дахь хэсгийн “цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр” гэснийг “цахим мөнгөөр” гэж тус тус өөрчилж, 26.6 дахь хэсгийн “зарцуулсан бол” гэсний дараа “сонгуулийн төв байгууллага” гэж, 26.7 дахь хэсгийн “хүлээн авах бөгөөд өөр” гэсний дараа “харилцах” гэж тус тус нэмж, 26.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “0.5 хувиар” гэснийг “0.7 хувиар” гэж, 27.3 дахь хэсэг, 27.6.1 дэх заалтын “2-оос” гэснийг “нэг ба түүнээс” гэж, 27.6.5 дахь заалтын “50 дахин” гэснийг “25 дахин” гэж, 27.9 дэх хэсгийн “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчилж, 27.11 дэх хэсгийн “Нам тарах,” гэснийг болон мөн зүйлийн 27.8 дахь хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 27.10, 27.12, 27.13 дахь хэсэг нэмэх:

“27.10.Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (C1 х T1) хэсгийг эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, төрийн

санхүүжилтийн (С2 х Т2) хэсгийг тухайн суудалд сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намд олгоно.

27.12.Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна.

27.13.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 16

Бүгд: 42

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 28.1-д заасан” гэснийг “Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ” гэж, “30 хоногийн” гэснийг “долоо хоногийн” гэж, 28.2 дахь хэсгийн “гаргасан” гэснийг “баталсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “2 удаа” гэснийг, 29.5 дахь хэсгийн “суурь” гэснийг, 29.10 дахь хэсгийн “давж” гэснийг тус тус хасаж, 29.4 дэх хэсгийн “нягтлан шалгах ажиллагаа явуулж буй бол уул ажиллагаа дууссаны дараа” гэснийг “хянасны дараа” гэж, 29.5 дахь хэсгийн “төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөс” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилээс” гэж, 29.6 дахь хэсгийн “энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо (С1)-нд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг” гэснийг “энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 х Т1) хэсгийг дараагийн жилд” гэж, 29.7 дахь хэсгийн “Тайлангийн агуулга алдаа, зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа” гэснийг “Санхүүгийн тайлангаа” гэж, “тэмдэглэлийн” гэснийг “дүгнэлтийн” гэж, 29.9 дэх хэсгийн “нийтлэгдсэн” гэснийг “тусгасан” гэж, “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “1 хувиас доошгүй” гэснийг “нэг ба түүнээс дээш хувийн” гэж, 30.1.1 дэх заалтын “зохион байгуулахад” гэснийг “зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор” гэж, 30.1.2 дахь заалтын “телевизээр жилд” гэснийг “телевизээс гаргасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “намын дансаар” гэснийг “зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд” гэж, “тооцооны” гэснийг “харилцах” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийн “үнэлэн бүртгэж” гэснийг болон 33.5 дахь хэсэг, мөн зүйлийн 33.13 дахь хэсгийн “байгууллагад өгөх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 х Т1) хэсгийг дараагийн жилд” гэж өөрчилж, 34.6.5 дахь заалтын “, бусад удирдах албан тушаалтан” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.5.6 дахь заалт, 34.12, 34.13 дахь хэсэг тус тус нэмэх:

“34.5.6.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13. Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

32. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “заасан худалдан борлуулах” гэснийг “заасны дагуу захиран зарцуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

33. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “хөрөнгийн баланс” гэснийг “хөрөнгийн бүртгэл” гэж, 36.3.7 дахь заалтын “арга хэмжээ зохион байгуулах, ном болон нийтлэл хэвлэн борлуулах үйл ажиллагаанаас” гэснийг “намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар” гэж, 36.14 дэх хэсгийн “бодлогын судалгааны байгууллага зэрэг түүний дэргэдэх, харьяа байгууллагын санхүүгийн тайланг” гэснийг “намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг” гэж тус тус өөрчилж, 36.3.5, 36.3.6, 36.4.9 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 36.5, 36.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5. Хөрөнгөд дараах зүйлийг бүртгэнэ:

- 36.5.1. барилга;
- 36.5.2. эзэмшлийн газар;
- 36.5.3. ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл;
- 36.5.4. бэлэн мөнгөний үлдэгдэл;
- 36.5.5. хуримтлал;
- 36.5.6. бусад хөрөнгө.

36.6. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран энэ хуульд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “тайлангаа нэгдсэн байдлаар” гэснийг “нэгтгэсэн тайланг” гэж, 37.6 дахь хэсгийн “бүртгэл болон санхүүгийн” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр, 37.4.1 дэх заалтын “намын гишүүний тоо.” гэснийг, 37.7 дахь хэсгийн “, эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “Тайланг аудитын байгууллагаар” гэснийг “Санхүүгийн тайланг” гэж, 38.2, 38.9 дэх хэсгийн “Аудитор” гэснийг “Аудитын хуулийн этгээд” гэж, 38.2 дахь хэсгийн “баримт материалтай” гэснийг “баримт бичигтэй” гэж, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “аудиторын” гэснийг “аудитын” гэж, 38.5 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг “этгээд” гэж, 38.9 дэх хэсгийн “тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл,” гэснийг “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт,” гэж, 38.10 дахь хэсгийн “баталгаа гарахад хангалттай” гэснийг “баталгаа гаргана” гэж, 38.14 дэх хэсгийн “Шалгалтын тэмдэглэлийг” гэснийг “Аудитын дүгнэлтийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.6, 38.8, 38.13 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.7, 38.12 дахь хэсгийг 38.1, 38.5, 38.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.5.Энэ хуулийн 38.1-д заасан аудитын хяналтыг хийхдээ намын санхүүгийн тайлан болон аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн эрсдэлд үндэслэн орон нутгийн салбар нэгж байгууллагын таваас доошгүй хувийг түүвэрт хамруулна.

38.9.Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох олон улсын стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт, тайлан гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн “тайланг нягтлан шалгах” гэснийг “тайлангийн хяналт” гэж, 39.1 дэх хэсгийн “хэлбэр болон агуулгын хувьд зөв, бодитой эсэх, энэ хуулийн Тавдугаар бүлэгт” гэснийг “энэ хуульд” гэж, “нягтлан шалгах” гэснийг “хянах” гэж, 39.2 дахь хэсгийн “ажлын 15-аас доошгүй хоногийн” гэснийг “ажлын таваас доошгүй өдрийн” гэж, 39.3 дахь хэсгийн “хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн” гэснийг “хүлээн авч хянаад 4 дүгээр сарын 05-ны” гэж, 39.4 дэх хэсгийн “Нягтлан шалгах ажиллагаа” гэснийг “Хяналтын ажиллагаа” гэж, 39.5 дахь хэсгийн “тухайн алдаа, зөрчлийг арилгаж сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу” гэснийг

“аудитын хуулийн этгээдийн тогтоосон хугацаанд тухайн алдаа, зөрчлийг арилгаж,” гэж, 39.7 дахь хэсгийн “Тайланг нягтлан шалгах ажиллагааны” гэснийг “Санхүүгийн тайланг хянах” гэж тус тус өөрчилж, 39.4.3, 39.4.4, 39.6 дахь хэсгийг болон мөн зүйлийн 39.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.5 дахь хэсэг нэмэх:

“39.5.Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “мэдүүлэх” гэснийг “мэдэгдэх” гэж, 40.2 дахь хэсгийн “нягтлан шалгах ажиллагааны явцад” гэснийг “хянах явцад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн гарчгийн “Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх” гэснийг “Аудитын дүгнэлтээр тогтоосон алдаа, зөрчлийн үр дагавар” гэж өөрчилж, 41.2, 41.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (C1 х T1) хэсгийг дараагийн жилд олгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг тус тус хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3, 34.5.4-д заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандивыг гурав дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “5 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2.2 дахь заалтын “болон тарсан” гэснийг хасаж, мөн зүйлийг 7 дугаар зүйлд нэгтгэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын “нийгмийн” гэсний дараа “сонирхлын” гэж тус тус, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “албан тушаалтны зүгээс” гэсний дараа “заналхийлэх,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.6 дахь хэсгийн “тайланг” гэсний өмнө “санхүүгийн” гэж, 29.9 дэх хэсгийн “тайланд” гэсний өмнө “санхүүгийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 22

Бүгд: 41

46.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын “нийгмийн” гэсний дараа “сонирхлын” гэж тус тус, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “албан тушаалтны зүгээс” гэсний дараа “заналхийлэх,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.6 дахь хэсгийн “тайланг” гэсний өмнө “санхүүгийн” гэж, 29.9 дэх хэсгийн “тайланд” гэсний өмнө “санхүүгийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “төрийн санхүүжилт авах эрх үүсэх жил” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жил” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “мөшгөн хавчих” гэснийг “мөрдөн мөшгөх” гэж, 5.6 дахь хэсгийн “бичиг баримтад” гэснийг “баримт бичигт” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “хуульд тогтоомжид” гэснийг “хууль тогтоомжид” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “байдлын” гэснийг “байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн “хийж” гэснийг “хийлгэж” гэж, 12 дугаар зүйлийн 12.3.8 дахь заалтын “хөрөнгийн мэдээ” гэснийг “хөрөнгийн мэдээлэл” гэж, 12.4 дэх хэсгийн “хөрөнгийн мэдээнд” гэснийг “хөрөнгийн мэдээлэлд” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтын “гишүүнчлэлээс” гэснийг “гишүүнээс” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “10 хоногийн” гэснийг “10 өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “гишүүдийн” гэснийг “гишүүний” гэж, 25.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийн “тооцон бодоход” гэснийг “тооцоолоход” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийн “баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “зорилго, бодлогыг тодорхойлсон” гэсний дараах “үндсэн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “хэдийд ч” гэсний дараах “намаас” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “нам” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтын “буюу” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.3 дахь хэсгийн “үндэсний” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “энэ хуульд нийцүүлэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалт нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хэрэгжинэ.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хоёр.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10-г заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг буцаах саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:50/

Гурав.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Улс төрийн нам, шашны байгууллагыг” гэснийг “Шашны байгууллагыг” гэж, 15.2.3, 15.2.4, 15.2.5 дахь заалтын дугаарыг “15.2.1, 15.2.2, 15.2.3” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг, эсхүл мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээг зах зээлийн дундаж ханшаар үнэлсэн дүнг нэг аравны тав дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол арван мянган нэгжтэй” гэснийг “банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн хандивын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд,

эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Долоо.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй.

“85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

25.8.8.Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1.Улс төрийн намын тухай хуулийн 9.10-т заасан мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;

7.6.2.төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягтыг батлах;

7.6.3.намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;

7.6.4.хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай санал гаргах;

7.6.5.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох;

7.6.6.намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;

7.6.7.Улс төрийн намын тухай хуулийн 8.9, 10.3-т заасны дагуу хяналт хэрэгжүүлэх;

7.6.8.Улс төрийн намын тухай хуулийн 26.6-д заасны дагуу шийдвэр гаргах;

7.6.9.улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих;

7.6.10.Улс төрийн намын тухай хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“**2 дугаар зүйл.**Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ажлын албанд” гэснийг “Тамгын газарт” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “ажлын алба” гэснийг “Тамгын газар” гэж, 15.1 дэх хэсгийн “ажлын албатай” гэснийг “Тамгын газартай” гэж, мөн хэсгийн “Хороо батална.” гэснийг “Хороо батална. Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно.” гэж, 15.2 дахь хэсгийн “ажлын албаны” гэснийг “Тамгын газрын” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн “нарийвчилсан журам, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/,” гэснийг “журам батлах, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын дээд шүүх /Д.Ганзориг/,” гэж өөрчлөх гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ тогтоолыг Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	15
Бүгд:	41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, С.Одонтуяа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.1.“Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	23
Бүгд:	41

43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	19
Бүгд:	41

53.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.1.“Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	20
Бүгд:	41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.5.“агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах төхөөрөмжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
-------------	----

Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.8.“аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тоногдсон газар, талбай, усан гадаргууг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.14.“нисэхийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах нисэхийн бусад үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хадгалах тогтолцоог;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.17.“иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбоотой цогц ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.12 дахь заалтын “болон түүнд хамаарах бусад” гэснийг түүнд шууд дэмжлэг үзүүлэх бусад” гэж, “гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг” гэснийг “гүйцэтгэхийг” гэж, 5.1.15 дахь заалтын “хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар” гэснийг “иргэний нисэхийг” гэж, 5.1.16 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “тэрчилгээжсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “шаардлагатай гэж үзвэл гадаад улсын” гэснийг хасаж, “тухайн” гэснийг “гадаад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалтын “навигацийн” гэсний дараа “болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “стандарт, журмын” гэснийг “стандартын” гэж, 9.2.5 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчилж, 9.2.5 дахь заалтын “зөвшөөрөл,” гэсний дараа “агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “тухайн салбарт 15-аас доошгүй жил ажилласан” гэснийг, “Монгол Улсын иргэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу” гэж өөрчилж, 10.2 дахь хэсгийн “дараах” гэсний өмнө “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна” гэж, 10.2.5 дахь заалтын “мэдээлэх” гэсний өмнө “холбогдох этгээдэд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “Конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг, 12.1.11 дэх заалтын “том, дунд, жижиг оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон” гэснийг хасах гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.19 дэх заалт, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтын “аргачлал” гэснийг хасаж, 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг эдийн засгийн зохицуулалтын дүрмээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Энэ хуулийн 14.1, 15.2 дахь хэсэгт хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Томилогдсон гадаадын” гэснийг “Гадаад улсын эрх бүхий байгууллагаас томилогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмэх:

“19 дүгээр зүйл.Иргэний агаарын хөлгийн баг

19.1.Иргэний агаарын хөлгийн баг нь нисгэгч болон багийн бусад гишүүдээс бүрдэнэ.

19.2.Нислэгийн үед нислэгтэй холбогдох үйл ажиллагаа явуулах нисгэгчээс бусад ажилтнууд агаарын хөлгийн багийн бусад гишүүнд хамаарна.

19.3.Монгол Улсын иргэний агаарын хөлгийн багийн бүрэлдэхүүнд гадаад улсын иргэн байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 17 дугаар зүйл болгох.

“17 дугаар зүйл.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа

17.1.Ерөнхий зориулалтын нислэгт хувийн болон чөлөөт, хөнгөн, хэт хөнгөн, хүнгүй агаарын хөлгөөр гүйцэтгэх, хэт хөнгөн агаарын хөлгөөр гүйцэтгэх сонирхогчийн нислэг болон тэдгээрт хамаарах бусад нислэг багтана.

17.2.Ерөнхий зориулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч хариуцна.

17.3.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

17.4.Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсгийн “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, 22.1.7 дахь заалтын “агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисгэх багийн” гэснийг “нисгэгчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Чикагогийн конвенцын 25 дугаар зүйлийн дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар хэсэг нэмэх.

“Тайлбар: Энэ зүйлд заасан “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуулийн 4.1.1-д заасныг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “стандарт, журмын” гэснийг, “стандартын” гэж өөрчилж, 27.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.3.Конвенцын хавсралтад заасан стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглан хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “төрийн өмчит” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмэх:

“33.3.Олон улсын нисэх буудал дахь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “аэродромд нисгэх” гэснийг “аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн” гэж өөрчилж, 34.1.2 дахь заалтын “өндөржүүлсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “хяналтын” гэснийг “хяналт тавих мэргэжлийн” гэж, “7-гоос” гэснийг “таваас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “анхан шатны мэдээллийг нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх, дэлгэрэнгүй мэдээллийг” гэснийг “анхан шатны болон дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний өмнө “өмчлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “шалгагч шинжлэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“51.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3 дахь заалтын “, эсхүл” гэснийг “болон” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “төрийн бодлого” гэснийг “талаар төрөөс баримтлах бодлого” гэж, 8.1.9, 8.1.10 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Конвенц, түүний” гэснийг “Конвенцын” гэж, 9.2.2 дахь заалтын “тохилогч” гэснийг “тохиролцогч” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсгийн “нөлөөлөхүйц” гэснийг “нөлөөлж болзошгүй” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “үзлэг” гэснийг “хяналт” гэж, “иргэний нисэхийн мэргэшсэн” гэснийг “нисэхийн гэрчилгээжсэн” гэж, 11.3 дахь хэсгийн “шилжүүлэн гүйцэтгүүлэх” гэснийг “шилжүүлэх” гэж, 12.1.8 дахь заалтын “эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.9 дэх заалтын “хамгаалалтын хөтөлбөр” гэснийг “хамгаалалт” гэж, 12.1.12 дахь заалтын “ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.13 дахь заалтын “болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “, аэродромыг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.10, 12.1.14, 12.1.15, 12.1.16, 12.1.18 дахь заалтын “байгууллагын гэрчилгээжүүлэлт” гэснийг “байгууллагыг гэрчилгээжүүлэх” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “үр шим” гэснийг “үр ашиг” гэж, 16.1.2 дахь заалтын “ажил гэдэгт” гэснийг “ажилд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь” гэснийг “Агаарын тээвэрлэгч” гэж, “гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий” гэснийг “гүйцэтгэх шаардлага хангасан” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.7, 22.1.8 дахь заалтын “нисгэх” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 19.3.2 дахь заалтын “өөрөөр шийдвэрлэх” гэснийг “нислэгийг хэвийн үргэлжлүүлэх” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “зорчигчийг аюулгүй болгох” гэснийг “зорчигчид шаардлага тавьж, аюулгүй байдлыг хангах” гэж, 21.4 дэх хэсгийн “учруулахуйц” гэснийг “учруулж болзошгүй,” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтын “зөрчсөн” гэснийг “зөрчиж” гэж, 22.1.6 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “нэвтрэн өнгөрөх” гэснийг “нэвтрэх” гэж, 23.2 дахь хэсгийн “Нислэгийн хөдөлгөөний” гэснийг “Агаарын навигацийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт” гэснийг “нутаг дэвсгэр, агаарын зайд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “зайн” гэснийг “зайд” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж, 29.3 дахь хэсгийн “аэродром нь” гэснийг “аэродромын үйл ажиллагаа эрхлэгч” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “хууль, дүрмийг” гэснийг “хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрмийг” гэж, 33.4 дэх хэсгийн “хураан авах, эсхүл саатуулна” гэснийг “хураан авна” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, “гэрчилгээжүүлэлт” гэснийг “гэрчилгээ” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.3 дахь заалтын “үзлэг” гэснийг “хяналт” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “нислэг техникийн” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 42 дугаар зүйлийн 42.4.6 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дахь хэсгийн “алба” гэснийг “байгууллага” гэж тус тус, “төрийн захиргааны байгууллага” гэснийг “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тохиолдол бүрд өөрчилж, 3 дугаар

зүйлийн 3.1.4 дэх заалтын “үйлдэж байгаа” гэсний дараах “улсын агаарын хөлгийн” гэснийг мөн заалтын “бусад” гэсний дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “, тэдгээрийг багтаасан” гэснийг, 5.1.7 дахь заалтын “эсхүл” гэснийг, 5.1.10 дахь заалтын түүний” гэснийг, 5.1.13 дахь заалтын “төлөв” гэснийг, 5.1.18 дахь заалтын “Чикагогийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “үйл” гэснийг, 9.2.5 дахь заалтын “иргэний” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “эсхүл” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “агаарын хөлөг үйлдвэрлэгчийн” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нислэгийн үйл ажиллагаанд” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “агаарын хөлөг” гэснийг, 23.2 дахь хэсгийн “нисгэх” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “зориулсан” гэсний дараах “аэродромын” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “дарга, нисгэх” гэснийг, 43 дугаар зүйлийн 43.2.1, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “ямар ч үед” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “хэлэлцэн” гэсний өмнө “Конвенцын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “Дарга” гэсний дараа “энэ хуулийн 11.1-д заасан” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “зохицуулалт” гэсний дараа “хийх” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “гэрчилгээ” гэсний өмнө “агаарын тээвэрлэгчийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “Нислэгийн” гэсний дараа “үед” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний дараа “цаашид “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэх/” гэж, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хамгаалалтын” гэсний дараа “үйлчилгээний” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “нислэгт” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 33
Бүгд: 38
13.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “4 дүгээр зүйлийн” гэсний дараа “4.1.1 дэх заалтын “дээших хийн мандлын агаарын давхаргын” гэснийг “дээших агаар мандлын” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, мөн хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Ц.Идэрбат, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хөтөлбөр хэрэгжүүлэх” гэсний дараах “хувийн нэмэлт тэтгэврийн” гэснийг хасаж, “талуудын” гэсний өмнө “оролцогч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “даатгалд хамрагдсан” гэснийг “даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “31.1.3-т заасан урт хугацааны даатгал эрхэлж буй этгээдийг” гэснийг “4.1.2-т заасан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан урт хугацааны даатгал эрхэлж байгаа компанийг” гэж, 5.1.10 дахь заалтын “хөрөнгө эзэмших” гэснийг “хөрөнгө өмчлөх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 5.1.16 дахь заалтын “бүрэн” гэснийг болон 5.1.17, 5.1.18 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, 5.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.21.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “түүнийг” гэж, 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагааг” гэснийг “хөтөлбөрийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хүртэл хувь хүний” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “тогтоолгохоор хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох” гэснийг “тогтоолгох” гэж өөрчилж, “хүртэл ажил олгогчийн” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мөнгөн дүн ба төлөх” гэсний дараах “давтамж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “шимтгэл төлөх” гэснийг дараах “давтамж,” гэснийг хасаж, 10.4 дэх хэсгийн “хамрагдсан ажилтны” гэсний дараа “сард” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 11
Бүгд: 38
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсгийн “сар бүр тооцож,” гэсний дараа “хагас жил тутамд” гэж, 11.7 дахь хэсгийн “Баталгаат өгөөжийн” гэсний дараа “жилийн” гэж нэмж, “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/-ны” гэж /цаашид тохиолдол бүрд/ өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18

Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13.1-д” гэсний өмнө “эрх залгамжлагч, өвлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж, 14.3 дахь хэсгийн “санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг” гэснийг “санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг” гэж тус тус өөрчилж, 14.7.5 дахь заалтын “зүйл” гэснийг болон 14.7.2 дахь заалтыг тус тус хасаж, 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.6 дахь заалт нэмэх:

“14.2.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “сангийн удирдах зөвлөл” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл, бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.6 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага, холбогдох этгээд” гэснийг “бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.9.7 дахь заалтын “үйл ажиллагааг эрхлэх” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараах “, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн гарчгийн “зөвшөөрөл олгох үйл ажиллагаа” гэснийг “зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэж,

17.3 дахь хэсгийн “45 хоногийн” гэснийг “21 өдрийн” гэж, 17.4 дэх хэсгийн “баримт бичиг, мэдээллийг” гэснийг “мэдээлэл, баримт бичиг, тодруулга, тайлбар” гэж, “60 хоногийн” гэснийг “45 өдрийн” гэж тус тус өөрчилж, 17.5.4 дэх заалтыг “худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан.” гэж өөрчлөн найруулж, 17.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 17.1.7 дахь заалтыг хасаж, 17.3 дахь хэсгийн “ирүүлэхийг шаардах,” гэсний дараа “тодруулга, тайлбар авах” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “хүсэлт гаргагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.8, 17.9, 17.10, 17.11, 17.12, 17.13, 17.14, 17.15 дахь хэсэг тус тус нэмэх:

“17.8.Хороо дараах тохиолдолд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

17.8.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

17.8.2.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

17.8.3.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

17.8.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

17.9.энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

17.10.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 17.9-д заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

17.11.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын таван өдрийн дотор хувийн тэтгэврийн санд хүргүүлнэ.

17.12.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

17.13.Энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

17.14.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

17.14.1.хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дуусгавар болгохоос ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар мэдэгдсэн;

17.14.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

17.14.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

17.14.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

17.14.5.Зөвшөөрлийн тухай хуульд заасан бусад.

17.15.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Н.Учрал нар үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 18.1.3 дахь заалтын “гэрээний санал” гэснийг “гэрээ” гэж, 18.2 дахь хэсгийн “30 хоногийн” гэснийг “20 өдрийн” гэж тус тус өөрчилж, 18.1.4 дэх заалтын “, бусад баримт бичгийн загвар” гэснийг болон 18.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Н.Учрал, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн гарчиг болон 19.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж өөрчилж, 19.2 дахь хэсгийн “, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах

20.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

20.1.1. баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

20.1.2. энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан маркетинг болон зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн;

20.1.3. нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

20.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 20.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

20.4. Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын таван өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

20.5. Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг нэг сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

20.6. Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хүсэлтийг үндэслэн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

20.7. Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд залруулаагүй тохиолдолд Хороо хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

20.8. Энэ хуулийн 17.12-т заасан шийдвэр гарсан бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

20.9. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ц.Туваан, Н.Учрал, Ж.Батжаргал, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	21
Бүгд:	39

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	18
Бүгд:	39

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан,

урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 20

Бүгд: 39

48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 20

Бүгд: 39

48.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан,

урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг түр хойшлуулав. /18:37/

Найм.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно:

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны зөвлөх Д.Лхагвасүрэн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ц.Сандаг-Очир, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуульа.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Парламентын номын сангийн урилгаар Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн холбооны болон аймаг, нийслэлийн “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 13 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 46 минут үргэлжилж, 73 гишүүнээс 45 гишүүн хүрэлцэн ирж, 61.6 хувийн ирцтэйгээр 19 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 43 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Өнөөдөр 19 асуудлыг хэлэлцэнэ. 1.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг явагдана. 2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, 2 дээр нь болохоороо Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Дараа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. 3, 4-д нь Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг хийнэ. 5-д нь Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Анхны хэлэлцүүлэг. 6-д нь Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг. 7-д нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг хийнэ. 8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг. 9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг. 10.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг хийнэ. 11-д БНМАУ-ын тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг. 12.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн нарын 20 гишүүн өргөн барьсан, хэлэлцэх эсэхийг нь шийднэ. 13.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үүний хэлэлцэх эсэхийг нь шийднэ. 14.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. 15-д Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ, эцсийн хэлэлцүүлэг. 16-д Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Чинбүрэн гишүүн нарын 28 гишүүн өргөн мэдүүлсэн төсөл байна. 17.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, эцсийн хэлэлцүүлэг хийнэ. 18.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон

Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг. 19-д Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техник боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлгийг хийнэ. Ийм 19 асуудлыг хэлэлцэнэ.

Өнөөдөр бас нэлээн ачаалалтай ажиллана. Нийтдээ 19 асуудал хэлэлцэнэ. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүд ирцдээ орж, хариуцлагатай хандахыг та бүгдэд бас анхааруулж байна. Санал хураалт явагдах үед ирц хэрвээ хүрэхгүй бол тухайн сонгогдсон тойргийн иргэдэд нь хандаж, Улсын Их Хурлын гишүүдийг чуулгандаа суухыг шаардах болно гэдгийг бас гишүүдэд анхааруулан хэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.14-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанд хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад өмнөх өдрийнх 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Ингээд Норовын Алтанхуяг гишүүнийг үг хэлэхийг урьж байна.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Би энэ хэлэлцээж байгаа асуудалтай холбогдуулаад Улс төрийн намуудын тухай хууль дээрээ анхаарал тавиарай гэж хэлэх гэсэн юм. Ажлын хэсэг гараад ажиллаад, энийг уул нь их сайжруулж л батлах ёстой хууль байгаа юм. Муужирчих вий дээ. Миний их санааг

зовоодог энэ олон жил санаа зовоож байгаа юм бол энэ намууд өмч хөрөнгөтэй байх явдал бол манай нийгмийн ялзралын эх үндэс байгаад байгаа юм. Уг нь энийгээ л өөрчилчихгүй бол энэ хууль батлахын ч хэрэг алга.

Сая Үндсэн хуулиа баталчихсан юм байна. Гишүүдийнхээ тоог нэмчихсэн юм байна. Би тэр холимог тогтолцоо бол ер нь жинхэнэ ёсоороо тэр олон нам мамыг дэмжих зөв тогтолцоо гэж боддог. Танай намын дарга Баяр би АН-ын дарга байх үед бид нар хамтраад 12 онд холимог тогтолцоог анх босгосон юм. Тэгэхдээ 76 суудал дотроо 28, 48-аар анх ингэж хийсэн юм. Энэ бол уг нь Монголд хэрэгтэй юм. Дараа нь нэг МАН, АН хэдэн амьтан нийлж байгаад энэнийг жижиг 76 болгож улсаа хорлон сүйтгэсэн. Энэ жижиг 76 бол Монгол Улсыг хэзээ ч хөгжүүлэхгүй гэсэн ийм хорлон сүйтгэх үйл ажиллагаа юм байгаа юм. Тэгээд би энэтэй холбогдуулаад бас юу хэлэх гэж байна вэ гэхээр тэр ямар юм болгочоод байгаа билээ, 78 дээр нэмэх нь 48 уу? 78, 48 болчоод байгаа юм. Одоо та нар манай 60 хэдээ энэ улс орноо боддог юм бол тэр 70 хэд чинь том тойргоос гарах ёстой шүү. Энэ улс орныхоо байж байгаа царайг хар. Их Хурлын гишүүд тойрог услахаас өөр хүмүүст мөнгө тендер авч өгөхөөс өөр юу хийж байгаа юм бэ? Юмны үнэ өсчихсөн байгааг хар. Энийгээ буулгахгүй юм уу. Одоо тэр цалин хөлсийг чинь нэг амсахын төдий нэмлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй шүү дээ. Тэгээд 1 жаахан суурьтай юм хийхгүй юм уу? Одоо ингэсээр байтал чинь энэ бид нарын 4 жилийн хугацаа дууслаа.

Байгалийн баялгийн эзэд Монголчууд байгалийн баялгийнхаа эзэн болно гэсэн тэр чинь бас явахгүй юм. Тэгээд өнөөдөр энэ Их Хурал дээр бас ярих юм байна. Авлигын, Авлигын үндэсний хөтөлбөр. Хөөш энэ бид нарын баталж байгаа хууль ном яах вэ, тэр хуулийг чинь хийдэг, хэрэгжүүлдэг, гүйцэтгэдэг нөхдүүд чинь хуульгүй амьдарч байна шүү дээ. Монгол Улсад энэ хууль чинь бол

алагчилж үйлчилж байна. АН-ынханд нь бол хатуу чанга үйлчилж байна. Ард иргэдэд бол бүүр хатуу чанга үйлчилж байна. Ардын намын гишүүдэд бол үйлчлэхгүй байна. Тэгэхээр энэ нэг авлигын хөтөлбөр баахан худал үнэн юм цаг барж ингээж байхаар энэ ард түмний ахуй амьжиргааг дээшлүүлэх тал дээр нь анхаарахгүй юм уу? Улс орон даяараа нэг хэдэн дайсан босгож л тэрэнтэй тэмцдэг нэг ийм л дүр зурагтай боллоо шүү дээ. Уг нь тэр хулгайч, дээрэмчдийг бий болгохгүй байх нөхцөлийг нь энэ Улсын Их Хурал хууль журам элдэв юмаараа хийх л ийм л үүрэгтэй юм даа. Тэгээд би бас нэг дахиад нэг хэлчихье дээ, энийг хэлэхгүй бол бас болохгүй байна.

Тэгээд ямар их салан задгай болчихсон юм бэ та нар. Одоо ингээд 40 минут өнгөрч байхад Их Хурлын чуулган чинь эхлэхгүй. Яагаад та нар ингээд суларчхаад байгаа юм бэ, юу болчихоод байгаа юм бэ? Тийм учраас энэ иргэдийнхээ ахуй амьжиргаа дээр яахгүй юм уу? Одоо ингээд баяр наадам боллоо. Тэгээд бүгдээрээ л ингээд л айраг цагаа эргүүлээд алга боллоо. Бүтээн байгуулалт чинь юу болж байгаа бол доо. Ийм, ийм юмнуудаа та бүхэн маань 60 хэдэн хүн маань нэг сууж юмаа ярь. Энэ ирэх 7 хоногт нэг ганц хуралдаад дуусах байлгүй дээ. Тэгэхээр энэ нэг юмнуудаа жаахан шуурхай, шуурхай яриад үз. Тэгэхдээ шуурхай гэхдээ энэ Улс төрийн намын хууль энэ тэр дээр би санаа зовоод байна шүү. Ер нь Монголын энэ хямрал бол Ардын намын энэ том байшингаас эхлэлтэй шүү. Яаж нэг нь ийм том байшинтай, ийм мөнгөтэй, ийм олуулаа, ийм байдалтай байхад олон нам Монголд бий болох вэ дээ. Тэгээд байж байгаа нэг муу 10 хэдийгээ бол ээлжилж ингээж олон нийтэд хаяж өгч, арга техник чинь их муу байна, хоцрогдсон байна. Ард түмний төлөө юм хийхгүй байна. 2 сар дуугаа хориулсан учраас би өнөөдөр заавал хэлье. Энэ ард түмнийхээ ахуй амьжиргаа дээр анхаараарай.

Л.Мөнхбаатар: Алтанхуяг гишүүн үг хэллээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэнэ. Санал хураалтаар үргэлжилнэ. 7 дугаар санал хураалтаар үргэлжилнэ. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын хэлтсийн дарга Дагвын Жавхлан, ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Лхамрагчаагийн Булганхүү, ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч Цэрэнгийн Наранчимэг нар оролцож байна.

Санал хураалтаа явуулъя. 7 дугаар санал хураалтын саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт гишүүдээ. 57,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын” гэснийг “өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын” гэж өөрчлөн, 13.3 дахь хэсгийн “зохион байгуулна.” гэсний өмнө “энэ хуулийн 11.1.25-д заасан журмын дагуу” гэж нэмэн, 13.2.3 дахь заалтын “, тусламж” гэснийг хасах; Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

9 дэх санал хураалт. Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“14.4.Энэ хуулийн 14.1.2, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ. Байна уу?

11, 10.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын зурвас газарт хамаарна” гэснийг “газрыг төмөр замын зурвас газар гэнэ” гэж өөрчлөн, мөн хэсгийн “шугамын” гэснийг болон 17.3 дахь хэсгийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна.” гэснийг “хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно.” гэж өөрчлөн, 18.2 дахь хэсгийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 23.3.2 дахь заалтын дугаарыг сольж, 23.3.2 дахь заалтын “тухайн төмөр замын суурь бүтэц” гэснийг болон 23.4.10 дахь заалтын “эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн” гэснийг тус тус хасах. Энэ дугаарыг сольж гэж ингэж томъёолж бичдэг билүү? Санал хураалгасан ажлын хэсэг. Санал хураалт. Энийгээ анхаараарай. Дугаарыг сольж гэсэн ийм томъёоллоор санал хураалгадаггүй байх шүү. 72,5 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.2.Улсын хилийн боомт чиглэсэн, хил дамнасан төмөр зам нь нийтийн төмөр замд хамаарах бөгөөд энэ төмөр замын өмчлөгч нь нэг хуулийн

этгээд байна.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 67,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншиллээр барих тохиолдолд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншиллэлийн гэрээнд тусгах бөгөөд түншиллэлийн хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,5 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид галт тэрэг харилцан чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байх;” гэж, 26.1.3 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь энэ хуулийн 25.1-д заасан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гэрээ байгуулсан байх;” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,5 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “өөрчлөхгүй байх зарчим баримтална.” гэснийг “өөрчлөхгүй байна.” гэж өөрчлөн, 31.2 дахь хэсгийн “бусад дэд бүтэцтэй” гэсний өмнө “энэ хуулийн 31.1-д зааснаас” гэж нэмэн, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг болон Тайлбар тус тус нэмэх:

“31.4.Төмөр замын суурь бүтэцтэй огтлолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

Төрийн захиргааны байгууллага гэдэг чинь ямар байгаа байгууллыг хэлж байна вэ? Төрийн захиргааны байгууллага гэдэг чинь энэ агентлагуудыг хэлж байгаа

биз дээ тийм ээ? Тэгээд танайх чинь тийм агентлаг байгаа юм уу? Байгуулагдана гэж үзээд урьдчилаад хийж байгаа юм уу? Зөвшилцөнө.

Тайлбар: Энэ хуулийн 31.1-д заасан “бусад төрлийн суурь бүтэц” гэж метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 32 дугаар зүйлийн гарчгийн “зам” гэснийг “замын үйлчилгээ” гэж, 32.2 дахь хэсгийн “замтай” гэснийг “замын үйлчилгээтэй” гэж, 32.3 дахь хэсгийн “замын холболтын цэгийг” гэснийг “замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан” гэж тус тус өөрчлөн, 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.Салбар замын үйлчилгээнд ачаа ачих, буулгах, сэлгээний хөдөлгөөн хийх, ачаа хүлээн авах, олгох, хадгалах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,5 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн “бүрэлдэхүүнд тавигдах” гэснийг “бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлахад тавих” гэж өөрчлөн, 30 дугаар зүйлийн гарчиг, 30.1 дэх хэсгийн “хөдлөх бүрэлдэхүүн,” гэснийг болон “Зөвшөөрлийн тухай хуульд заасан” гэснийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “газраар” гэсний дараа “хүн, техник хэрэгсэл” гэж нэмэн, 43.5 дахь хэсгийн “тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах” гэснийг “тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж хэрэгсэл нь бүртгэл, дугаар,

хяналттай байх бөгөөд түүнийг ашиглах” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “тээврийн байгууллага” гэснийг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч” гэж, 44.4 дэх хэсгийн “зорчигч болон ачаа тээврийн тарифыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэснийг “тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.5, 44.6, 44.7 дахь хэсэг нэмэх:

“44.5.Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд Зөвлөлийн дүрмийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.6.Энэ хуулийн 44.5-д заасан Зөвлөлийн дарга, гишүүнийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

44.7.Зөвлөл нь эдийн засаг, хөгжлийн, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллөөс гадна ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй байна.” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт 67,5 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын дугаарыг “26.6” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын дугаарыг “47.2” гэж, 47.1 дэх хэсэг, 47.1.1 дэх заалтын дугаарыг нэгтгэн “47.1” гэж, мөн төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 75 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтыг төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу дэмжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, хэлэлцүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.
1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “чиг” гэсний өмнө “суурь бүтцийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “осол” гэсний, 11.1.17 дахь заалтын “салбарын” гэсний, 11.1.10 дахь заалтын болон 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “зориулалттай” гэсний, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 27 дугаар

зүйлийн 27.2.6 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “аюулгүй байдал” гэсний, 42.2 дахь хэсгийн “дүрэм” гэсний өмнө болон 12 дугаар зүйлийн гарчгийн “Төмөр замын” гэсний дараа “тээврийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.18 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “ажилтан” гэсний, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “ажилтанг” гэсний өмнө “тээврийн байгууллагын” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “хангах” гэсний өмнө “мэдээллээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “сэргийлэх” гэсний өмнө “урьдчилан” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “үйлчилгээ үзүүлэх” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 4.1.19 дэх заалтын “баримт бичгийг” гэснийг “хуваарийг” гэж, 4.1.22 дахь заалтын “сэлгээний ажлыг” гэснийг, “сэлгээний хөдөлгөөнийг” гэж, 4.1.23 дахь заалтын “нэг түвшинд” гэснийг “ижил түвшинд” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “олгох” гэснийг “зэргийг ашиглуулах” гэж, 9.1.5 дахь заалтын “газар олгох, чөлөөлөх” гэснийг “газар эзэмших, ашиглах эрх олгох, газар чөлөөлөх” гэж, 10 дугаар зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.9, 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “ажилтан бэлтгэх, давтан сургах” гэснийг “ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх,” гэж, 10.2.11 дэх заалтын “ажиллагаанд” гэснийг “ажилд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “огтлолцох” гэснийг “нэвтрэх” гэж, 11.1.25 дахь заалтын “техник, технологийн” гэснийг “техникийн” гэж, “хөрөнгийг” гэснийг “эх үүсвэрийг бүрдүүлэх,” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “тээврийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан” гэснийг “тээвэрт ашиглагдах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын түүхий эд “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бүсэд хамааруулна” гэснийг “бүс гэнэ”

гэж, 16.2 дахь хэсгийн “журмаар тогтоосон дэглэмээс бусад үйл ажиллагаа явуулах, нэвтрэх, объект байрлуулахыг” объект байрлуулах гээд энэ үг үсгийн алдаа байна үү, үүнийг засаарай. байрлуулах гэснийг “журамд тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулахыг” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “сүлжээг хөгжүүлэхэд” гэснийг “сүлжээний төлөвлөлтөд” гэж, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “аливаа этгээдэд” гэснийг “бусдад” гэж, 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийн “журамд” гэснийг “журам, зааварт” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “тээшийг олгох үед” гэснийг “тээшинд” гэж, 36.4.5 дахь заалтын “ачаа” гэснийг “, дутсан ачаа” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн” гэснийг “техник хэрэгсэл, материалын нөөцийн бэлэн байдлыг хангасан” гэж, 42.6.3 дахь заалтын “ачааг” гэснийг “ачаа, тээш, ачаан тээшийг” гэж, ачаан тээш гэдэг томъёолол байгаа юм уу? Ачаан тээш гэж. 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Тарифын” гэснийг “Тээврийн тарифын” гэж, “хүчин төгөлдөр болохоос” гэснийг “мөрдөж эхлэхээс” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “дүрэмт” гэснийг “албаны” гэж, 47.1.1 дэх заалтын “олгох;” гэснийг “олгоно.” гэж, 47.1.2 дахь заалтын “тэтгэмж” гэснийг “тусламж” гэж, “зохицуулах;” гэснийг “зохицуулна.” гэж, “дотоод” гэснийг “хөдөлмөрийн дотоод” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь заалтыг, 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “зарим” гэснийг, ТАВДУГААР БҮЛЭГ-ийн нэрийн “ТЭЭВРИЙН” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “төмөр замын суурь бүтцийн” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.3.3, 23.4.1, 23.4.5, 23.4.6, 23.4.7, 23.4.9 дэх заалтын “төмөр замын” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “өмчлөгч,” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “ашиглаагүй үед”

гэснийг, 42 дугаар зүйлийн 42.6.3 дахь заалтын “, найдвартай” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “байгууллагын ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:” гэснийг, 47.1.1 дэх заалтын “төмөр замын тээврийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,5 хувиар санал дэмжигдлээ. Юугаа хийчих, хийчих.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал байна. 1.Төслийн 47 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“47.1.2.үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт ажилтны 1 сарын дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлж олгох.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Санал хураалт. Байнгын хорооны дэмжигдээгүй санал байна. 62,5 хувиар санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Нэг.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй буюу зохих ёсоор аваагүй, мэдээлээгүй, ангиллыг буруу тогтоосон, сэргээн босгох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд” гэснийг “алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад болон төмөр замын суурь бүтцийг сэргээн босгох үйл ажиллагаанд” гэж, 2 дахь хэсгийн “талаарх олон улсын гэрээг” гэснийг “дүрэм, журмыг” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтын “ердийн хөсөг, тээврийн хэрэгслийг” гэснийг “ердийн хөсгийг” гэж, 4 дэх хэсгийн “Хуулиар хориглосон” гэснийг “Шаардлага хангаагүй” гэж, “хэрэгсэл, технологийг” гэснийг “хэрэгслийг” гэж тус тус өөрчлөн, 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын “байгууламж барьсан,” гэсний дараа “объект байрлуулсан,” гэж, 5 дахь хэсгийн “Суурь бүтцийн” гэсний өмнө “Төмөр замын” гэж, “саад” гэсний өмнө “үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн болон 2, 6 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж тус тус нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73,2 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “ажиллагаа эрхлэхдээ” гэснийг “ажиллагааг” гэж, 7.3 дахь заалтын “шилжүүлсэн” гэснийг “шилжүүлж;” гэж тус тус өөрчлөн, мөн хэсэгт “7.4.бусдын тусгай зөвшөөрлөөр эрхэлсэн” гэсэн агуулгатай заалт нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 29.1.12 дахь заалтын “техник, эдийн засгийн үндэслэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн “дараах” гэснийг “29.1.12 дахь” гэж, 29.1.12 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 73,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “дараах” гэснийг “29.1.1, 29.1.2, 29.1.3 дахь” гэж, мөн зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь

заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж, 29.1.2 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя. 3 дахь нь тийм ээ, 3 дахь санал хураалтыг явуулъя. 3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөх:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29 дүгээр зүйл” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5, 29.1.6, 29.1.7, 29.1.8, 29.1.9, 29.1.10, 29.1.11 дэх заалт” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73,8 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг “тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн байна. Энэ дээр нэг тодруулаад орхиё. Засгийн газраас оруулж ирсэн төслөөр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 14.4 дэх хэсэг дээр төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэх гэж тусгаж өргөн мэдүүлсэн байна. Гэтэл одоо энийг

болохоороо Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн сайд нь өөрөө олгоё гэсэн ийм зохицуулалт болгоод сольчихсон байгаад байна шүү дээ. Энэ асуудал дээр тайлбар хэлье. Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ энийгээ тайлбарлах уу? Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ төмөр замын суурь бүтэц барих ажлыг урьд өмнө Засгийн газар тусгай зөвшөөрлөөр Засгийн газар олгож байсан юм. Одоо бол энэ шинэ орж ирж байгаа шинэчилсэн төслөөрөө бол төрийн захиргааны төв байгууллага буюу сайдын хүрээнд яаман дээр нь тусгай зөвшөөрлийг нь олгоё гэдгээр орж ирж байгаа юм. Сая бид нар чинь 800 зуугаад 800 гаруй километр замд барилаа. Энэ төмөр зам барихад бол ААН-үүд дээрээс нь бол бас армийнхан оролцсон. Ер нь бол 800 гаруй километрийг Монголчууд өөрсдөө ингээд барьдаг болчихлоо шүү дээ. Тэгэхээр энийг Засгийн газар дээр олгож байдаг энэ урьд өмнө бол яах вэ төмөр зам гэдгийг бол бид нар нэлээн өндөр түвшинд ярьж байсан. Нэлээн өндөр түвшний технологи гэдэг утгаар нь Засгийн газар дээр тусгай зөвшөөрлийг нь өгөөд ингээд л олгож байсан бол одоо энэ чинь техник технологи хөгжчихлөө, Монголчуудын маань ААН-үүдийн маань чадал чадах өндөр түвшинд оччихлоо. Тийм болохоор энэ бол ерөөсөө барилгын ажил байхгүй юу даа. Барилгын ажил. Энгийн бас тодорхой хэмжээний тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж байдаг. ААН-үүд маань бүрэн өөрсдөө хийх боломж бололцоотой болчихсон ийм барилгын ажил болчихож байгаа юм.

Тийм болохоор энийг тэр өндөр түвшнийх нь Засгийн газар олгодгийг доош нь буулгаад яамных нь хүрээнд олгоод явчхаж байгаа юм. Ер нь бол авто замын асуудал ч тэр байж байна, барилгатай холбоотой асуудлууд ч тэр байж байна, төмөр замтай холбоотой асуудлууд энэ бол ерөнхийдөө бол нэг түвшний хүрээнд технологийн хүрээнд бол ойролцоогоор хийгдэж байгаа ийм

барилгын ажил байгаа юм. Тэр утгаар нь болбол энгийн түвшин рүү нь бас татаад, ерөнхийдөө бол либералчлах тал руу нь оруулж ирээд, яам нь олгохоор төрийн захиргааны төв байгууллага олгохоор оруулж ирж байгаа юм шүү.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч хариулж байна. Энэ төмөр замын суурь дэд бүтэц барих энэ тусгай зөвшөөрлийг Засгийн газар биш яам буюу тухайн асуудлыг эрхэлсэн сайд нь болгохоор ажлын хэсгээс санал оруулсныг Байнгын хороо дэмжсэн байна. Энийг бол протоколд бас тэмдэглэж үлдээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүдээ. 54,8 хувиар санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “стандарт,” гэснийг болон 4 дүгээр зүйлийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 63,4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төмөр замын зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ, суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр зохицуулсан Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ болон хамт баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэсний дараа дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хураалт явж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийнхаа асуудалд оръё. Энийг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. Бат-Эрдэнэ гишүүн даргалж байгаа тийм ээ. Танай Байнгын хороонд шилжүүллээ.

11.29 цаг

Хоёр. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийнхаа асуудалд оръё. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг та бүгдэд танилцуулъя. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нь танилцуулъя та бүгдэд.

Монгол Улсын Их Хурлын тогтоол Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгаланг Улсын Их Хурлын ХЗБХ-ны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг Улсын Их Хурлын ХЗБХ-ны гишүүнээр баталсугай.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулж байна. Байнгын хорооны

бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 65 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.31 цаг

Гурав. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, Засгийн газар, 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Тэгье Одонтуяа дарга тэрийг бичгээ өгчхөөрэй нааш нь. Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адъяаагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн Нийтийн албанд

нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн болно.

ХЗБХ 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ганбат эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан нэг саналт хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүйг нь дэмжсэн болно. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинж шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сүхбаатар сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Цолмон, АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт дүн шинжилгээний албаны дарга Баярсайхан, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Цолмон Ш.Цолмон, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч М.Цолмон нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Сэргэлэн гишүүнээр тасаллаа. Сэргэлэн гишүүн асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би ажлын хэсгээс асуух гэсэн юм. Энэ Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар маш олон зүйлүүдийг хориглосон заалтууд байгаа. Ялангуяа төрийн албан хаагчид, эрх бүхий албан тушаалтнуудад. Энэ хуулиар хориглосон үйл ажиллагааг явуулсан тохиолдолд буюу энэ хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь ямар, ямар хуулиудаар зохицуулж байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл би шуудхан асууя. Энэ хуулиар зохицуулсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх үү? Амьдрал дээр энэ Ашиг

сонирхлын зөрчлийн тухай хуулийг зөрчдөг асар их тохиолдлууд байна. Баримт нотолгоог бол энэ ХМХ-ээр бол байнга л бичиж байна. Тэрэнд давуу эрх олголоо, ингэлээ, тэглээ. Ер нь зөрчлүүд бол байнга л гарч байгаа. Тэгээд энэ дээр ямар хариуцлага ер нь тооцдог юм бэ?

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль батлагдаад олон жил болж байна шүү дээ. Энэ олон жилийн хугацаанд энэ Ашиг сонирхлын зөрчлийн хуулийг зөрчөөд энэ зөрчсөн үйлдэлдээ эрүүгийн хариуцлага бусад хуулийн хариуцлага хүлээсэн энэ тохиолдлууд нь хэр олон байдаг юм бэ ер нь? Тэгээд 1 хууль баталдаг. Болохгүй л гээд байдаг, тэгж ч болохгүй, ингэж ч болохгүй гээд. Энэ бол зөв хориглох нь маш зөв. Ганцхан эргээд зөрчсөн этгээдүүдтэй, субъектүүдтэй ямар хариуцлага тооцдог вэ? Одоо энэ шинэчлэн найруулж орж ирж байгаа энэ хууль дээр энэ хариуцлагын тогтолцоо чангарч орж ирж байгаа юу? Ялангуяа Эрүүгийн хуультайгаа уялдаж орж ирж байгаа юу л гэж би асуух гээд байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цэдэвийн Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу, хэддүгээр микрофон бэ? Баярсайхан уу, 84 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Б.Баярсайхан: АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга Баярсайхан байна. Гишүүний асуултад хариулъя. Сонирхлын зөрчлийн хууль 2012 оноос хойш хэрэгжиж эхэлж байна. Энэ явж байна хэрэгжээд. Энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч болон албан тушаалтан сахилгын болон холбогдох хариуцлагыг ноогдуулдаг байгаа. Яг энэ сонирхлын зөрчлийн хуулиар бол 2022 онд нийтдээ АТГ-т 653 албан тушаалтны асуудалтай холбоотой гомдол мэдээллийг хүлээж аваад, энд 37 албан тушаалтанд

бол хариуцлага яг энэ өргөдөл гомдлын асуудлаар хариуцлага хүлээлгэсэн байна.

Юуны төсөлтэй холбоотой бас хариуцлагын асуудлыг ярьж байх шиг байна. Тэгэхээр энэ төсөл дээр бол бас хариуцлага, хариуцлага хүлээлгэх асуудал нь бол тусгагдсан байгаа. Өөрөөр хэлбэл төслийн 20³ дээр бол тухайн албан тушаалтныг чөлөөлөх, огцруулах, эргүүлэн татах энэ асуудлыг тусгаж өгсөн байгаа. Асуултад хариуллаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрөөтэй нэг санал байна. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу ХЗБХ-ны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20¹.3, 29.6 дахь хэсгийн “20¹.1 дүгээр зүйлд” гэснийг “20¹.1, 20¹.2-т” гэж өөрчилж, 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, “төслийн 2 дугаар зүйлийн мөн хэсгийн байгууллагын дарга,” гэсний дараа “тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга,” гэж гэснийг, мөн хэсгийн “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэсний өмнө “тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга,” гэж өөрчлөх. Санал гаргасан ХЗБХ. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 64,1 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүлээ.

11.41 цаг

Дөрөв. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 99, 102 дугаар захирамжаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Улсын Их Хурлын үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их

Хурлын гишүүн Адъяасүрэн, Батжаргал, С.Ганбаатар, Ганболд, Доржханд, Ц.Мөнхцэцэг, Ц.Мөнх-Оршил, М.Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан, Тэмүүлэн, Цогтгэрэл, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан болно.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ. Ажлын хэсэг Улсын Их Хурлын D-parliament.mn цахим системд иргэдээс ирүүлсэн 52 санал, ажлын хэсгийн гишүүн Улсын Их Хурлын гишүүн Адъяасүрэн, Батжаргал, Доржханд, С.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг нараас ирүүлсэн 63 санал, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс ирүүлсэн саналууд, мөн 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр улс төрийн 30 намын төлөөлөл оролцсон хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг үндэслэн намын бүртгэлтэй холбоотой асуудлыг сонгуулийн төв байгууллага нягтлахаар байсныг Улсын Дээд шүүх бүрэн хариуцах, бүртгэлтэй холбоотой журмыг батлах, намын хатуу шинэчлэлийн асуудлыг сулруулах зорилгоор нам нь гишүүд, дэмжигчтэй байхаар, нам бүх шатын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх, намд олгох төрийн санхүүжилтийг 2 хувийн босгыг 1 хувь болгож бууруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хуультай нэр томъёог нийцүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй 61, найруулгын шинжтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Оюунчимэг нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж хариулт авсан болно. Байнгын

хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн даргад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. СЕХ-ны Ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Буянтогтохын Бундхорол, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор Одонгийн Мөнхсайхан, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор Дагва-Очирын Бумдарь, судлаач, доктор Эрдэнэбилигийн Гэрэлтод, тэгээд урагшаа сууж болно шүү тийшээ. Судлаач Дагвын Энхцэцэг нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Булгантуяа гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Улс төрийн намын тухай хууль ер нь их чухал хууль. Бүх юмны ундарга гэж яривал яг суурь нь улс төрийн нам дээр очиж л зангидагдана. Улс өөдлөхгүй байгаа гэвэл тэр улс төрийн намтай яригдана. Авлига хээл хахуул бугшсан гэж ярьж байгаа бол тэр

улс төрийн намтай очиж яригдана. Тэгэхээр намын шинэчлэлийг хийхгүйгээр бид цаашидаа улс орны хөгжлийн тухай ярих боломжгүй болсон. Надад тараагдсан асуудлаас 3 асуулт байна.

Нэг энэ санал хураалтын 11 дүгээр саналын санал хураалтад байгаа төслийн 13-д Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана гэж байгаа юм. Тэгэхээр Дээд шүүх намын нэрийг олгох юм уу? Болно, болохгүй гэдгийг нь хэлэх үү. Өөрөөр хэлбэл жишээлбэл АН гэдэгтэй адилхан товчлолтой АН гэдэгтэй адилхан хутгасан шинэ АН гэж байгуулъя гэвэл энэ АН-тай давхцаж байна, давхцахгүй байна гэдгийг Дээд шүүх хянаж шийд нэрийг нь өгөх гэж байна уу гэдэг эхний асуулт байна.

2 дахь асуулт. Төслийн 15 дахь санал хураалт. 17.4-д намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн 2/3-оос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно гэсэн заалт байна. Энэ тухайн намын Бага хурлын гишүүдийн 2/3 санаачилж байж л намын дүрэмд өөрчлөлт орох юм уу. Энэ арай өндөр босго биш үү? Тэгвэл намын дүрэм чинь хэзээ ч өөрчлөгдөхгүй шүү дээ. Нөгөө нам чинь дүрмээ шинэчилж, баяжуулж, цаг үетэйгээ нийцүүлж, ашиглагдаж явах ёстой гээд байдаг. Бид ийм хатуу хөдөлгөөнгүй, уян хатан бус хэв шинж рүү намыг хуулиар оруулж болж байгаа юм уу гэсэн 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт санал хураалтын 16-д байгаа. Төслийн 19.4-д оруулах гэж байгаа нам бүх шатын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага түүнийг байгуулах ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8

дугаар зүйл намын дүрэмд нийцүүлнэ гэсэн байна. Намаас хэн нэр дэвшихийг шийддэг нам дотор хороо байх юм уу тусдаа? Бид нар чинь Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад 48 хүнийг намын жагсаалтаар нэр дэвшүүлэхээр болчихсон шүү дээ. Тэгтэл тэр нам нь биш нам дотор байгаа нэг хороо гэдэг нэртэй хуучин шиг удирдах зөвлөлийн 7 хүн энэ Улсын Их Хурлын гишүүнийг намын жагсаалтаар хэнийг нь нэр дэвшүүлэх гэдгийг шийдээд суугаад байх юм уу? Сая манай улсад Унгар Улсын парламентын дарга ирсэн, айлчилсан. Нийтдээ энэ чинь 30 жил парламентын гишүүнээр ажиллаж байгаа хүн юм байна лээ шүү дээ. 90 оноос хойш. 90 оноос хойш бүр. Тэгээд тэр хүн бол өөрөө нөгөө намынхаа нэр дэвшигчийг тодруулдаг хорооны гишүүн нь юм байна лээ шүү дээ өөрөө. Тэгээд энэ хорооны гишүүд бол бараг бүх насаараа л Улсын Их Хурлын гишүүнд жагсаалтаар өөрсдийгөө нэр дэвшүүлээд суугаад байх юм байна л даа. Тэгээд энэ яагаад энэ намыг бүүр нөгөө жагсаалтаар орж ирэх юмыг бүүр ард түмнээс нь хол хөндий болгочхов? Яагаад тэр намын хамт олон өөрөө олуулаа хэлэлцэж, олонхынхоо саналаар шийдэхгүй ийм тусад нь тэр сонгуульд нэр дэвшүүлдэг хороо гэдэг ийм бүтэц хаанаас гаргаад ирэв? Ийм 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Хууль санаачлагчийг төлөөлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Алтангэрэлийн Бямбажаргал мөн оролцож байна. Түүнийг танилцуулъя. Асуултад хэн хариулах вэ? Энхбаяр гишүүний асуултад. Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэн хариулъя. Нэмээд ажлын хэсэг хариулж болно.

Д.Тогтохсүрэн: 1 дүгээр асуултад Мөнхсайхан доктор нэмж хариулна биз. Би 2, 3, хоёр дээр хариулт өгье гэж бодож байна. 15 дахь асуулт. 15 дахь саналтай. Тэгэхээр ийм юм байгаа юм. Одоо өргөн баригдсан Намын хууль дээр намын их

хурал 4 асуудал шийднэ гэж байгаа юм. Намын удирдах байгууллага буюу Их хурал. Тэр нь дүрэм, мөрийн хөтөлбөр, намын дарга, төлөөллийн байгууллага буюу төлөөллийн байгууллагаа сонгох юм уу, батламжлах, хяналтын байгууллагаа сонгох. Намын их хурлын үндсэн үүрэг энэ. Тэгэхээр яах вэ гэхээр намын их хурал 4 жилд нэг л удаа болно. Тэгээд намын дүрэм болон намын дарга 4 жилийн хугацаа дотор өөрчлөх явах шаардлага үүснэ. Тэгэхээр өмнө нь бол Намын хуульд бол энэ намын төлөөллийн байгууллага бол дүрэмд өөрчлөлт оруулах эрхийг олгоогүй байсан юм. Энэ удаа бол олгож байгаа юм. Олгохдоо 2/3-н дэмжлэгээр, 3 нийт дүрмийнхээ 1/3-ээс хэтрэхгүй байна гэж ингэж хязгаарлалт зааж өгч байгаа юм.

Өөрөөр хэлбэл намын Их хурлын бүрэн эрхэд байнга халдаад байлгахгүй үүднээс нь ийм хязгаарлалт тогтоож өгсөн юм. Зүгээр үнэхээр 2/3 өндөр байна гэвэл олонх гэж болно. Энэ бол хэлэлцүүлгийн явцад яриад явж болох асуудал гэж бодож байгаа юм. Гол нь намын Их хурал 4 жилд нэг удаа болдог учраас уян хатан байлгах үүднээс намын төлөөллийн байгууллагад нь дүрэмд өөрчлөлт оруулах эрх олгож байгаа. Тэгэхдээ өндөр квоттой байвал яасан юм бэ гэж ажлын хэсэг ярьж байгаад энийг тавьсан юм.

2 дахь нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хуулийг хэлэлцэх үед манай Их Хурлын гишүүдээс маш олон гарсан санал бол энэ 19 дэх санал байгаа юм. 19 дүгээр зүйлд орсон санал. Энэ нэр дэвшилтийг ил тод, нээлттэй, хариуцлагатай, намын хамт олны санал авдаг, хамт олноороо хэлэлцүүлдэг ийм болгох шаардлага байна гэдэг ийм саналыг маш их ярьсан юм. Мэдээж энэний шийдвэр гаргах субъект нь бол төлөөллийн төв байгууллага байна. Энийг Сонгуулийн хууль дээр заагаад өгчихсөн. Нэр дэвшүүлэх эцсийн шийдвэрийг төлөөллийн төв байгууллага гаргана гээд.

Тэр төлөөллийн төв байгууллага гаргахаас өмнө нэр дэвшигчээ сонгон шалгаруулах, олон нийтээр хэлэлцүүлэх, шат шатын намын хамт олны санал авах энэ бүх ажлыг зохион байгуулах ийм хороотой байж гэж ажлын хэсэг ярилцаж энэ саналыг оруулсан. Тэр хорооны дүрэм, хорооны дүрэм нэр дэвшигчид тавигдах шаардлага, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгахтай холбоотой асуудлыг нь тэр дүрмээр нь зохицуулж өгье гэж байгаа юм.

Тийм учраас 19 дүгээр зүйлийг нь 4, 5, 6 болгож 1 дүгээрт сонгон шалгаруулах хороотой байна. Хорооны бүрэлдэхүүнийг нь төлөөллийн байгууллага нь сонгоно. 2 дахь нь журамтай байна. Журмыг нь төлөөллийн байгууллага нь сонгоно гээд. Тэгэхээр тэр нам бол хороотой л байна. Ямар хороо байх вэ ямар бүрэлдэхүүнтэй байх вэ ямар үе шатаар дамжиж нэр дэвшигчээ сонгон шалгаруулах вэ гэдгийг хийж өгч байгаа юм. Ингэхгүй болохоор яадаг вэ гэхээр манай өмнөх практик чинь намын дарга кармандаа байгаа хүнээ гаргаж ирээд л бараг дэвшүүлчихдэг. Ийм учраас энэ байдлаас зайлсхийж хамт олны оролцоог бий болгох. Харин таны яриад байгаагийн эсрэг хамт олны оролцоог нь бий болгох үүднээс энэ 19 дүгээр зүйлийг зориуд хуульд тусгаж өгөх шаардлагатай байна. Өмнө нь энэ заалт байхгүйгээс болоод нэр дэвшилтүүд дээр янз бүрийн хэл ам их гардаг учраас энийг бид нар гаргахгүйн үүднээс ийм зохицуулалтыг 16 дахь санал буюу 19 дүгээр зүйл дээр оруулж өгсөн юм. Манай ажлын хэсгийнхэн нэмж хариулах байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Мөнхсайхан доктор, хэддүгээр микрофон байна вэ? 80, 81 дүгээр микрофон өгье. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

О.Мөнхсайхан: Энхбаяр гишүүний асуултад нэмэлт хариулт хэлье. 1 дүгээр асуултын хувьд бол энэ улс төрийн намын бүртгэл чиг үүрэг нь хаана байх вэ гэдэг

асуудал бол энэ төслийг хэлэлцэх явцад маш их яригдсан. Тэгээд 33 жилийн уламжлал зэргийг харгалзаад бол Улсын дээд шүүх дээр энэ намын бүртгэлтэй холбоотой бүх чиг үүргийг бүрэн гүйцэд өгөх ийм байдлаар бол төсөл боловсруулагдаж бас энэ чиглэлээр өөрчлөлтүүд орсон. Энэ дээр түрүүн Тогтохсүрэн даргын хэлсэн хэлэлцүүлгүүд дээр улс төрийн намуудаас гарсан санал бол юу байсан бэ гэхээр сонгуулийн төв байгууллага, хуулийн этгээдийн улсын бүртгэл эрхэлсэн байгууллага эд нарын оролцоогүйгээр бүрэн гүйцэд Улсын дээд шүүх энийгээ хариуцах ийм саналууд дээр үндэслэж боловсруулагдаж гарч ирсэн томъёолол байгаа. Яг гишүүний асуусан энэ 13.5-тай холбоотой заалт бол тэр байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол намын нэрийн сан бол Улсын дээд шүүх дээр одоо байгаа тэр нь ингээд баяжаад явна. Энэтэй холбоотой хуулийн этгээдийн нэрийн сан бол хуулийн этгээдийн бүртгэл эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дээр байгаа. Тэгэхээр тэр санг бол ашиглаад 6 дугаар зүйлд заасан давхардал, төөрөгдөл давхардаж байна уу, төөрөгдөл үүсгэж байна уу, үгүй юү гэдгийг нь нягтлах энэ юугаа бол Дээд шүүх өөрөө хийнэ.

Гэхдээ 14 дүгээр зүйлийн 14.14-д төслийн 14.14-д зааснаар сонгуулийн төв байгууллага болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзаад энэ бүртгэлтэй холбоотой журмыг Дээд шүүх батлах юм. Энүүгээрээ бол саяын яг нэрийн асуудал дээр нарийвчилсан энэ 2 байгууллагын хоорондын асуудал бол зохицуулаад явах юм байна лээ. Сүүлийн жилүүдэд бол энэ улсын бүртгэлийн байгууллагын мэргэжилтэн ажлын хэсэгт өгсөн тайлбараар Дээд шүүх бас энэ бүртгэлийн улсын бүртгэлийн байгууллага бол хамтраад бас энэ асуудлаа зохицуулаад явж байгаа юм байна лээ. Тэгэхээр тэр нь илүү албажаад энэ төслийн 14.11-д байгаа журам руу тусаад явна гэж ойлгож байгаа юм.

2 дахь асуудал дээр нэмэхэд бол намын дүрэм батлах гэдэг бол эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийн асуудал, үндсэн бүрэн эрхийн асуудал. Тэгэхдээ бас амьдрал баян учраас зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал байвал дүрмийн 1/3-ээс хэтрүүлэхгүйгээр төлөөллийн төв байгууллага нь байгууллагын гишүүдийн 2/3 нь санал гаргах юм бол бас хэлэлцэх тэр боломжийг нь намуудад бол нээж өгсөн. Ийм зохицуулалт 17.4-д орсон.

Тэр Сонгон шалгаруулах хороотой холбоотой 19.4-өөс 6 дахь зохицуулалт дээр ажиглах юм бол энэ нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа төслийн 8.2.1 төслийн 8.2.2, 8.3-д заасан шаардлагуудыг нэр дэвшигчийг тодруулахдаа баримтална гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол энэ гишүүдийн оролцоог хангана, ил тод байдлыг хангана бас олонхын саналаар шийднэ, нууц санал хураалт явагдана гэх мэтчилэн нөгөө ардчилсан зарчмаар Улсын Их Хурлын болон бусад сонгуульд нэр дэвшигчийг тодруулах шаардлагууд нь бол энэ 19 дүгээр зүйлийн 4-өөс 6-д бол тусчихсан байж байгаа.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Бүх шатын сонгуульд хэнийгээ нэр дэвшүүлэхийг бол намын хамт олон өөрсдөө шийдэх ёстой. Анхан шатаасаа эхлээд, үүрээсээ эхлээд, дунд шатаасаа эхлээд дүүрэг, хороод, нийслэл, төлөөллийн төв байгууллага бүгд хэлэлцэж байж ярих ёстой болохоос энийг хэн нэгэн тусгай эрх эдэлсэн 9 хүн эцсийн шийдвэр гаргадаг байж таарахгүй. Энэ бол зарчимд нийцэхгүй байна. Улс төрийн ажил бол тийм хүнд таалагддаг бас амархан ажил биш. Дандаа дотроо дайсантай байдаг юм шүү дээ. Тэгээд энэ чинь хувь субъектив юм орно шүү дээ. Тэгээд чамайг би дэвшүүлэхийг мэднэ. Чиний хувь дэвшүүлэх үү, дэвшүүлэхгүй юу гэдгийг хэдхэн хүн шийддэг байж огт таарахгүй. Энэ бол ардчилсан бус зарчим. Ялангуяа

жагсаалт орчихсон үед шууд Их Хурлын гишүүн хэн болохыг 7 хүн шийдэх гээд байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Энхбаяр гишүүний яриад байгааг л янзлах гэж энийг хийж байгаа юм. Би нөгөө талаас нь хэлж байгаа юм. Яагаад вэ гэхээр ийм байхгүй юу. Тэр намын дарга ч юм уу эсвэл хэн нэгэн цөөхөн хүний хүрээнд асуудлыг шийдүүлэхгүйн тулд л энэ хороо сонгодог, шалгаруулдаг тэр анхан болон дунд бүх шатаар нь хэлэлцүүлдэг. Тийм ээ. Ийм байгаад тэгээд юу гэдэг юм төлөөллийн байгууллагадаа юм уу, гүйцэтгэх байгууллагадаа санал болгодог. Тэгээд л тэр гүйцэтгэх байгууллага нь төлөөллийн байгууллагадаа санал болгоод, төлөөллийн байгууллага нь эцсийн шийдвэр гаргана шүү дээ энэ чинь. Сонгуулийн хуульд заачихсан төлөөллийн байгууллага нэр дэвшүүлэх эрхтэй. Тэрнээс өөр хэн ч нэр дэвшүүлэхгүй. Энэ хороо чинь бол харин хэлэлцүүлэг эд нар зохион байгуулж, их олон хүнийг хамруулж, аль болохоор ултай суурьтай олон түмний санал бодолд нийцсэн хүмүүсийг нэр дэвшүүлэхэд л чиглэж байгаа ийм байгууллага болохоос биш энэ зүгээр нэг нэр дэвших гэж шийддэг газар биш байхгүй юу. Тийм учраас бол би таны хэлээд байгаа санал зөв. Тэрийг чинь шийдэх гэж ийм юмыг оруулж ирж байгаа юм л гэж хэлж байна. Ийм юм байгаагүйгээс бид нар өнгөрсөн жилүүдэд яаж байсан гэхээр тийм намын дарга ч юм уу.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Үгүй ээ, энэ тэгвэл 19.4 чинь яг ингэж уншигдаад байна шүү дээ. Сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороо гэж байгаа байхгүй юу. Сонгон шалгаруулна гэдэг чинь тэгээд сонгон шалгаруулаад шийднэ гэсэн үг шүү дээ. Энэ хороогоор ороогүй хүн нэр

дэвшихгүй. Энэ эцсийн шийдвэр гаргах юм шиг уншигдаад байна шүү дээ. Энэ бол тэгвэл сонгон шалгаруулах биш ямар хороо юм бэ? Материалыг нь бүрдүүлэх юм уу, зүгээр тэрийг зохион байгуулах хороо байх ёстой болохоос биш энэ сонгон шалгаруулдаг хороо байж болохгүй. Хэнийгээ нэр дэвшүүлэхийг сонгон шалгаруулах гэдэг бол намын хамт олны нийтийн шийдвэр байх ёстой. Энэ хороо шийддэг байж болохгүй. Тэгвэл энэ хорооны нэрийг өөрчлөх хэрэгтэй. Сонгон шалгаруулдаг хороо л лав байж болохгүй энэ. Энэ бол ардчилсан бус байна.

Л.Мөнхбаатар: Зарчмын зөрүүтэй санал хураах үед бас энийгээ тодотгож ярьж болно. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуултаа асууя. Баттөмөр гишүүний дараа нь юм байна. Баттөмөр гишүүн дараа нь юм байна. Өнөрболор гишүүн асуултаа асуучих.

Д.Өнөрболор: Болох юм уу, энэ чинь яасан. Сайн байцаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намуудын тухай хууль үндсэндээ энэ 2 хуулийн хэрэгжилтээр л ер нь Үндсэн хуулийн энэ биелэл олно гэж бол миний хувьд бол ойлгоод байгаа. Тэгээд Үндсэн хуулиар энэ сонгуулийн тогтолцоо ер нь өөрчилснөөр энэ улс төрийн намын нийгэм дэх оролцоо, тэгээд хариуцлага бол нэмэгдэнэ гэж бол ойлгож байгаа. Тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн гол үзэл санаа олон намын тогтолцоог бэхжүүлэх энэ төлөөллийн ардчиллыг боловсронгуй болгох, нэг хэсэг нь ер нь үндсэндээ яг энэ хууль л гэж ойлгоод байгаа юм. Тэгээд энэ хуулиар зохицуулах ёстой хамгийн чухал, чухал асуудлууд ерөөсөө огт орж ирсэнгүй. Нөгөө улс төрийн сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотойгоор зохицуулах нарийвчилсан зохицуулалтууд ч орж ирсэнгүй. Яагаад гэдгийг би асуумаар байна.

Энэ Сонгуулийн хуулийг хэлэлцэх үед бол би маш тодорхой асууж байсан. Тэгээд энэ Улс төрийн намын хуулиараа

энийг зохицуулна гээд үлдээсэн гэж бол би ойлгож байгаа. Тэгээд энэ миний тэр асуугаад байсан зохицуулалтууд ер нь хаана байгаа юм бэ? Нэгд энэ өрсөлдөгч намууд ер нь бодлогоороо өрсөлддөг байх ёстой. Олонх л болсон энэ нам ард түмний өмнө ямар үүрэг юм, цөөнх болсон нам ямар үүрэг хариуцлага хүлээх юм гэдэг талыг гэдэг нарийн зохицуулалтуудыг ч гэсэн энэ хуулиар бол хуульчилсан байх ёстой.

Нөгөөтээгүүр энэ нэр дэвшигчийн ёс зүй, одоо би дахин, дахин л яриад байгаа энэ асуудлыг. Энэ нэр дэвшигчийн ёс зүй, намуудын ёс зүй, тэдний удирдлагуудын ёс зүй, жагсаалтаа худалддаггүй байх, мөнгөний сонгуулиас татгалздаг байх, улс төрийн намын энэ үнэт зүйлс болон улс орны хөгжлийн төлөөх бодлого дэвшүүлдэг байх энэ соёл хандлагыг хуульчлах ёстой. Энийг бол Сонгуулийн хууль руу оруулна, биш ээ юу билээ энэ Улс төрийн намын тухай хууль руу бол оруулна гээд Сонгуулийн хууль дээр ийм тайлбар хийгээд байсан. Тэгээд энийг энэ асуудлуудыг ерөөсөө огт энэ хуулиас бол олж харсангүй.

Дээрээс нь энэ намын бодлогуудыг хэрэгжүүлж чадах чадвар бүхий ёс зүйтэй, чадвартай, хүнийг нэр дэвшүүлдэг энэ байр суурь нөхцөлийг яагаад энэ хуульд ерөөсөө огт оруулахгүй байгаа юм бэ? Тэгээд нөгөө бидний төсөөлж байгаа энэ улс төрийн өндөр соёлтой, улс орноо хөгжүүлэх чадвартай, бодлогын нам төлөвших хөгжих нөхцөл бүрдэхээргүй харагдаж байна одоо яг энэ хуулиас ингээд харах юм бол. Яг ийм байдлаараа Үндсэн хуулийн энэ үзэл санаа энэ хуулиар ер нь хэрэгжихгүй. Хэрэгжүүлэхийг эсвэл хүсэхгүй байгаа юм уу? Наад зах нь энэ жагсаалтын эрэмбэлэхэд нам эвсэлд тавигдах шаардлагыг хатуу хуульчилж оруулъя гээд тэгсэн. Тэгээд энэ бол байхгүй байна. Жагсаалт хариуцлагатай салбар бүрд мэргэшсэн ур чадвартай боловсон хүчнийг оруулдаг байхаар бол хуульчилъя гээд. Энийг бол Улс төрийн намын хуульд

бол бид нар хуульчлаад оруулна. Сонгуулийн хуульд бол энэ бол бас ингээд өөрчлөгддөг учраас ингэж оруулах бол оруулахгүй, энэ бол дараа дараадаа бол ингээд зохицуулагдаад явна гээд тэгсэн. Энэ зохицуулалтуудыг ерөөсөө огт энэ хуулиас ингээд олж харахгүй байна.

Энэ хууль ер нь үндсэндээ нэг бүртгэл, зохион байгуулалт, хяналтын ингээд ийм нүсэр бүтцийн ийм л зохион байгуулалтын асуудлуудыг шийдсэн ийм хууль болж хувирсан гэж л уншигдаж байна. Энэ асууж байгаа асуултууд дээрээ хариултаа авъя.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Бид энэ Өнөрболор гишүүний саналыг авч үзэж л саяын тэр Энхбаяр гишүүний яриад байгаа саналыг оруулсан байхгүй юу. Та бол ямар санал хэлсэн гэхээр ер нь бол энэ нэр дэвшигчийг ил тод, нээлттэй хариуцлагатай байлгах хамгийн том асуудал бол энэ байна. Ийм учраас Сонгуулийн хууль болон Улс төрийн намын тухай хууль дээр энэ нэр дэвшигчийг олон нийтээр хэлэлцүүлдэг, бүүр сонгон шалгаруулдаг, сонгон шалгаруулдаг, тэгээд олон түмний саналыг авдаг, шат шатын хамт олны, намын хамт олны саналыг авдаг ийм байлгах гэж л тэр саяын тэр 19 дүгээр зүйлд оруулж байгаа 3 заалт байгаа юм. Таны яриад байгаа асуудлууд. Энэнээс өөрөөр бид нар томъёолж болохгүй байгаа юм. Энэнээс бусад асуудал нь бол дүрмээрээ зохицуулагдах ёстой, журмаараа зохицуулагдах ёстой юм. Тэгээд энэ 19.4, 5 дээр биччихсэн. Яаж сонгон шалгаруулах вэ, яаж ямар үе шатаар хэлэлцүүлэг нь явах вэ, энийг бүгдийг нь журмаар зохицуулна гээд биччихсэн. Журмыг нь төлөөллийн байгууллага нь батална гээд.

Тийм учраас таны яриад байгаа бусад саналууд бол энэ журамд л очиж орно. Бид Улс төрийн намын хуулиар ерөнхий зохицуулалтыг нь л хийж өгөхөөс биш бусад асуудлыг бол нам өөрөө дүрмээрээ зохицуулах ёстой юм. Тийм учраас 19-ийн саяын Энхбаяр гишүүний яриад байгаа 19.4, 5, 6 гэдэг заалтыг бид нар Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны болон нэгдсэн чуулган дээр Улс төрийн намын хууль болон Үндсэн хуулийг хэлэлцэхэд яриад байсан асуудлуудыг нам бүр дотроо зохицуулдаг болгох гэж л ийм юм оруулж ирсэн.

Одоо улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 38 намаас АН бол яг ийм хороотой юм байна лээ. Одоо яг ийм хороотой газар байна уу гэхээр АН байгаа юм. Тийм учраас бол бид нар ер нь энэ жишигийг авбал яадаг юм бэ гэдэг хэлбэрээр л энэ асуудлыг оруулж ирсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу та? Өнөрболор гишүүн тодруулж асууя.

Д.Өнөрболор: Тэгээд энэ сонгон шалгаруулах хороо гэдэг чинь бол энэ чинь бас тодорхой намын дотор удирдах зөвлөл гээд бас бүтэц ингээд л үйл ажиллагаагаа явуулаад л, сонгон шалгаруулаад л явж байгаа шүү дээ. Энэтэй юугаараа ялгаатай байгаа юм бэ? Ерөөсөө ялгааг нь бол олж харахгүй байгаад байна л даа. Тэгээд өнөөдөр ер нь намын энэ дүрэмд бол бид нар найдаж амьдарч ирсэн. Энийг бол одоо энэ дүрэмд бол найдаж орхиж бол болохгүй гэж болж байна. Өнгөрсөн цаг хугацаанд бол үнэхээр болохгүй юм байна гэдгийг ч гэсэн харуулсан байж байгаа. Тэгээд би энэ хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлд намын дүрэм, энэ бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудал дээр ер нь энэ улс төрийн намын энэ гишүүнчлэлд тавигдах энэ хэм хэмжээ, энэ шаардлага хязгаарыг яагаад хуульчилж болохгүй байгаа юм бэ? Энэ бол маш тодорхой асуудал шүү дээ. Энэ намын өмнөөс улс төрийн томилгоо, улс

төрийн сонгуульд оролцож байгаа энэ нэр дэвшигчдэд тавигдах үндсэн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр ингэж байгаа юм Өнөрболор гишүүнээ. Одоо бид нар чинь ингээд намын хурал хийгээд нэр дэвшилт эхлэхээр чинь юу гэж ярьдаг вэ гэхээр ямар шалгуураар энэ хүнийг гаргаж ирж байгаа юм бэ? Хэн оруулдаг вэ гэхээр намын дарга оруулдаг. Тэгэхээр л бараг л намын даргын танил талын хүн ч юм уу ийм хүн ороод ирлээ, ямар шалгуураар явсан юм бэ, хаана юу хийж байсан юм гээд ингээд эхэлдэг байхгүй юу. Тэгэхээр бид нар энийг бий болгохгүйн тулд л нам нэг жил бай, 2 жилийн ч өмнө хамаагүй энэ хороогоо байгуулаад л, тэр хорооныхоо журмыг гаргаад л, тэр нэр дэвшүүлэгчээ тодруулах журмаа гаргаад л, тэгээд л тэр журмын дагуу тэр хороо нь ажиллаад л, юу гэдэг юм энэ хүн бол ийм, ийм шалгуурыг хангаж, тэгээд биччихсэн байгаа бүр. Ашиг сонирхлын болон ёс зүйн гээд биччихсэн байгаа. Аль алийг нь. Энэ 19 дүгээр зүйл дээр. Ёс зүйн болон ашиг сонирхлын гэж бичсэн байгаа. Энэ шаардлагуудыг хангаж байгаа учраас нэр дэвшүүлж байгаа юм гээд л нөгөө хорооныхон Бага хуралдаа юм уу, Удирдах зөвлөл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах юм бэ, нэмж хариулах юм уу? ТББХ-н дарга Нямаагийн Энхболд нэмж хариулъя.

Н.Энхболд: Намд ямар хүн элсэж болох вэ, элсэж болохгүй вэ, намууд ямар хүнийг авч болох вэ, авч болохгүй вэ гэдэг зүйлийг энэ хуулиар зохицуулж болохгүй, болдоггүй юм. Ямар ч үзэл бодолтой, байр суурьтай хүмүүс өөрсдөө үзэл бодол дээрээ нэгдээд эвлэлдэн нэгдэх эрхийг нь Монгол Улсын Үндсэн хуулиар нээгээд өгчихсөн болохоор, зөвшөөрчихсөн болохоор энэ дээр яг Намуудын тухай хууль дээр ийм хүнийг намын гишүүнд

элсүүлнэ, энийг бол авахгүй шүү энэ тэр гэдэг юмнуудыг зааж ерөөсөө болохгүй юм байгаа юм. Тэгээд бид нар сая ингээд хэлэлцэх явцад бол зөвхөн нэг ажлын хэсгийн нэг хэдэн хүний ярьсан асуудал биш л дээ. Нөгөө 30 хэдэн намын чинь төлөөллүүд бүгд оролцсон. Тэгээд дийлэнх нь ер нь олон асуудлуудыг намууд өөрсдийнхөө дүрмээр, дотоод журмаараа зохицуулах ийм юм байх хэрэгтэй. Түүнээс намын хууль гээд л Намын тухай хууль гээд бид нарын.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Нэг минутад багтаагаад.

Н.Энхболд: Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг намын тухай гэдэг нэртэй хуулиар ямар нэгэн байдлаар хязгаарлаж тавьж болохгүй гэсэн ийм байр суурь дийлэнх олонх нь гарсан учраас ингэж явж байгаа. Ерөнхийлөгч өргөн мэдүүлэхдээ энэ зарчмыг больсон байх гэж бодож байна. Тухайлбал хуульд зааснаас бусад тохиолдолд намын гишүүн байх нь түүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, давуу байдал олох үндэслэл болохгүй гэх мэтчилэн. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй тохирсон хуульд зааснаас өөр хязгаарлалтыг эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон холбогдох бусад үндсэн эрх чөлөөг эдлэхэд тавьж үл болно гээд энэ дээр оруулчихсан байгаа. Тэгэхээр үнэхээр том намууд дээр л маш том хариуцлага ярьж байгаа юм. Ямар хүнийг гишүүнээрээ авах юм. Үгүй ээ авахгүй гэж нэг шалгуур тавина гэхээр бас их сонин болчихоод байгаа юм. Үгүй ээ би ерөнхийдөө танай үзэл баримтлалыг чинь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Монгол Улсын Үндсэн хуульд улс төрийн намуудын үйл

ажиллагаа ил тод байна, санхүүжилт ил тод байна, Монгол улсын хэмжээнд улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэсэн нэг тодорхой заалтууд байдаг л даа. Тэгээд энэ маань хэрэгжилт маань ер нь хэр зэрэг байдаг юм бол одоо? Тааруухан л яваад байгаа юм л даа. Энд улс төрийн нам бол ардчилсан үйл явцын амин чухал сүнс. Тэгээд цаашаага тэр олон ургалч үзэл төлөвшихөд бол маш их чухал ач холбогдолтой гэж ингэж үздэг. Тэгээд ер нь бол одоо энэ өнгөрсөн хугацааны ингээд 30 жилийн хугацаанд бидний энэ ингээд зам ингээд явж ирсэн үр дүнг харахад бол Монгол Улсын хөгжил мухардалд орчихсон л байгаа шүү дээ. Энийг бол бид нууж хаагаад байх юм байхгүй. Олон үзүүлэлтээр бол бүүр 2 мянга тийм 1990 оны түвшинээсээ бол ухарчихсан байж байгаа шүү дээ.

Яах вэ бид нарын ярьдаг барьдаг юм бол сайхан, сайхан юм бол бий л дээ. Яг бодит үр дүн бол буурсан. Тэгээд энэ юутай холбоотой вэ гээд л ингээд үзэхээр зэрэг энэ улс төрийн намуудын төлөвшил, үйл ажиллагаатай л холбоотой байгаа юм л даа. Манай намууд бол улс төрч нарыг хэдэн 10 мянгаар нь бэлдээд гаргажээ. Мундаг, мундаг улс төрч нар бол байна. Энэ улс төрч нар дотроос төрийн зүтгэлтнүүд л гарч байх ёстой юм байгаа юм л даа. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ төрийн зүтгэлтнүүд гарч уу, үгүй юү? Ингээд үзэхээр их учир дутагдалтай л байдаг юм л даа. Тэгээд бид нар бол нийгмийн хямрал, эдийн засгийн хямрал гээд л ингээд л ярьдаг байсан бол одоо сүүлийн үед бол юу гэхээр ардчилал маань хямралд орлоо гэж дэлхий нийтээр ярьж байна шүү дээ. Тэгээд бид бас энэ дээр бодох л ёстой л асуудлууд тулгарч байна л даа.

Тэгээд яах вэ ер нь бол Ерөнхийлөгчөөс өргөн барьсан түвшинд бол энэ хуулийн төслийг бол унисан. Зүгээр ажлын хэсэг дээр ямар, ямар өөрчлөлтүүд гарч ирснийг бол сайн мэдэхгүй байна. Хэд хэдэн асуулт байна. Өнөөдөр Монгол Улсад бүртгэлтэй 40

нам байгаа. 36 нь ямар нэгэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа юм. Тэгээд тэр одоо бид нарын нэг нэгдэн орчихсон зарим конвенцууд энэ нөгөө улс төрийн намыг байгуулах тэр гарын үсэг тэрийг багасгах гэсэн энэ тэр ийм заалтууд байгаад байдаг юм л даа. Тэгээд бид нар бол энэ 36 намыг цаашаа нэмэгдүүлэх биш, энэ нэгдэж нийлэхэд л бодлогоо явуулмаар байгаа юм л даа. Монголчууд ерөөсөө энэ хөгжлийн мухардлын гол нэг шалтгаан бол гол үнэт зүйл дээрээ нэгдэж чаддаггүй, энэтэй л холбоотой юм байгаа юм. Тийм учраас энэ намуудыг нэгдэж нийлэх, төлөвших, үзэл баримтлал нь их тодорхой болох энэ чиглэлд ажлын хэсэг дээр нэмж та нар юу харав гэсэн нэг ийм асуулт байна.

2 дугаарт нь бол юу гэхээр энэ улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой. Ерөөсөө аливаа бүх бид маш их арга хэмжээ авч байгаа. Харамсалтай нь бол нэг эдийн засгаараа баталгаажихгүй байгаад байгаа байхгүй юу. Эдийн засгаар баталгаажсаагүй ямар ч үйл явц амин сүнсгүй. Энийг би маш олон дахин ярьдаг. Энийг ч өнөөдөр ч бас хэлье гэж бодож байгаа. 126 гишүүдэд улсын төсвөөс мөнгө өгөх л юм байна л даа. Тэгээд энэ ямар хэмжээний тооцоо судалгаанууд байдаг юм гэсэн ийм 2 дахь асуудал байна.

3 дахь асуудал бол тэр 12 онд орсон Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагад бид нар элссэн шүү дээ. Тэнд бол тодорхой заалтууд байж байгаа. Нам тэр төр улс төрийн намыг салгая гэсэн ийм заалтууд байгаа юм. Энэ олон улсынхаа энэ нэгдэн орсон.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Бямбажаргал баг эд нар. Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Баттөмөр гишүүний яриад байгаа асуудал бол үнэхээр чухал. Энэ улс

төрийн намуудыг хариуцлагатай болгох, ямар ч хариуцлагагүй намуудыг өндөр хариуцлагатай болгоход чиглэ гэсэн. Энэ хуулийн ерөөсөө 2 л том онцлог байгаа юм. Нэг дэх нь улс төрийн намыг хариуцлагатай болгохтой холбоотой юм байгаа юм Баттөмөр гишүүнээ. Тийм учраас улс төрийн намыг бол бид нар байгуулахад нь тавигдах шаардлага бол хэвээрээ байгаа. Үндсэндээ хэвээрээ байгаа. Нөгөө 801 гэдэг шаардлага бусад шаардлага бол хэвээрээ байгаа. Харин байгуулагдаад үйл ажиллагаа явахад нь тавигддаг шаардлагыг өндөржүүлж өгсөн. 1 дүгээрт улс төрийн намыг идэвхгүй байдалд оруулдаг болж байгаа. Жишээлбэл санхүүгийн тайлангаа өгөөгүй, Улсын Их Хурлын сонгуульд 2 дараалан оролцоогүй, төлөөллийн байгууллага буюу намын удирдах байгууллагуудынхаа хурлыг хийдэггүй, дотоод ардчиллынхаа талаар явуулдаггүй ийм 3 тохиолдолд идэвхгүй болгож байгаа, аудит орж байгаа. Дараа нь намыг тараахаар байгаа. Намын үйл ажиллагааг зогсоохоор байгаа. Таны яриад байгаа шиг намууд хоорондоо нэгдэх нийлэх энийг бол дэмжсэн байгаа. Ингээд өөрөөр хэлбэл намуудыг аль болохоор хариуцлагатай, өдөр тутам улс орон даяар үйл ажиллагаа явуулдаг болгоход чиглэгдсэн ийм өөрчлөлт байгаа.

2 дахь нь санхүү. Намд тодорхой хэмжээгээр улсын төсвөөс санхүүжилт өгөхөөр байгаа. Гэхдээ улсын төсвөөс санхүүжилт өгөх босгыг нийт сонгогчдын нэг хувиас дээш санал авсан тохиолдолд санхүүжилтийн асуудал яригдана. Санхүүжилт нь 2 чиглэлийн санхүүжилт байгаа юм. Нэг нь улс төрийн намууд сонгогчдын санал авсан байдлаараа сонгогчдын саналыг үнэлж нэг санхүүжилт явна. Нөгөөдөх нь Улсын Их Хуралд авсан суудлаараа нэг санхүүжилт явна. Санхүүжилт нь маш их ил тод, нээлттэй, хариуцлагатай байхад чиглэж байгаа. Нэг талаасаа төрөөс өгч байгаа дээрээ төрийн аудитын байгууллага аудит хийнэ. Дээр нь тухайн улс төрийн нам хандив,

татвар, бусад үйл ажиллагааны орлого энэ бүх юм нь бүгд ил тод, нээлттэй байх тийм зохицуулалтыг энэ хуульд хийж өгсөн байгаа. Бусад асуудал дээр нь манайхан нэмж хариулах байх гэж бодож байна. 80 юм уу Бямбажаргал.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэгт нэмж хариулъя. Бямбажаргал дарга уу, зөвлөх үү? 80, ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

А.Бямбажаргал: Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя. Таны хамгийн сүүлд асуусан асуултын хувьд бол мэдээж энэ хууль маань өөрөө бүхэлдээ 19 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд одоогийн намын эрх зүйн орчныг энэ Үндсэн хуульдаа нийцүүлэх хүрээнд бол бүхэлдээ чиглэж байгаа гэдгийг хамгийн түрүүн хэлэхийг хүсэж байна. Тэгээд энэ хүрээнд намын дотоод зохион байгуулалт ардчилсан байх энэ чиглэлээр бол энэ хуульд бүхэлдээ чиглэсэн. Өөрөөр хэлэх юм бол өнгөрсөн 30 жилийн хугацаанд одоо Монгол Улсад албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж байгаа энэ 36 нам маань намын маань маш цөөн тооны нам, бараг ганц нам л хурлаа тогтмол хугацаанд бол хийж ирсэн юм байна лээ. Бусад намууд бол 30 жилийн хугацаанд ч гэсэн удирдах дээд байгууллагаа хуралдуулаагүй ч ийм намууд байх жишээний.

Намын удирдлага, зохион байгуулалтын хувьд дүрмээрээ зохицуулж болохоос бусад нийтлэг харилцааг бол энэ хуулиар бүхэлд нь зохицуулж байгаа. Ингэхдээ тодорхой хугацаанууд тогтоож өгч байгаа маань цаанаа энэ ардчилсан зарчмыг бас хангахад чиглэж байгаа гэдгийг тодруулж хэлье.

Мөн Үндсэн хуульд өөрөө орсон тэр хөрөнгө орлогын эх үүсвэр нийтэд ил тод байх чиглэлээр бол маш тодорхой зохицуулалтууд бүхэл бүтэн бүлэг орж байгаа намын санхүүжилттэй холбоотой. Өөрөөр хэлэх юм бол намын

орлогын эх үүсвэр нь юунаас, яаж бүрдэх юм, ямар хэмжээтэй байх юм, бүр тодруулаад хэлэх юм бол энэ дээд талын хязгааруудыг нь ч гэсэн энэ дээр тогтоож өгч байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ 30 жилийн хугацаанд өөрөө бий болсон асуудлуудыг л шийдвэрлэх зорилгоор энэ маань бол явж байгаа гэдгийг тодруулах гэсэн юм.

Дээр нь бол энэ та бас хэллээ. Төрийн санхүүжилтийн асуудал. Үндсэн хуульд бас орсон. Төрийн санхүүжилтийг олгож болох энэ нөхцөл журмыг бол өөрөө хуулиар тогтооно гэж. Тэгээд энэ хуулиар бол энэ санхүүжилтийг олгох журмыг бол бас нэлээн тодорхой болгож өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл нам өнгөрсөн хугацаанд санхүүжилтийг авч байдаг гол нэг чухал эх үүсвэр бол энэ төрийн санхүүжилт байх юм. Гэхдээ төрийн санхүүжилт аваад авлаа гэдгээрээ бол энэ зүгээр хязгаарлагдах биш, энэнийхээ хүрээнд бол бас хариуцлага олон нийтийн хяналт, хуулиараа бол тодорхой тухайлбал төрийн аудитын хяналт орж болох энэ зохицуулалтуудыг бас нэмж орсон гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Ингээд энэ сонгуулийн эрхийн хязгаарлалт гээд нэг юм байдаг юм шүү дээ, тийм ээ? Тэгээд яах вэ энэ удаагийн улс төрийн сонгуульд бол яах вэ дээ зүгээр гадна, дотноос бодно амьдардаг хүмүүс санал өгдөг л болж байгаа л даа. Тэгэхээр энэ хорих ял эдэлж байгаа ч юм уу, хөгжлийн тодорхой бэрхшээлтэй хүмүүс ч юм уу энэ тэрийг тэр манай нэгдэн орсон конвенцод бол саналыг нь авах ёстой л гэж зааж байгаа шүү дээ. Нэг дэх асуудал.

2 дахь асуудал бол юу гэхээр энэ Монгол Улсад энэ амьдардаг мөртөө иргэнийлээ олж аваагүй хүмүүс зөндөө байдаг юм. Энэ хүмүүс эвлэлдэн нэгдэх барих энэ юмнууд нь бол бас тэр Европын

аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагатай нэгдэн орсон конвенцын хүрээнд бол бас л тодорхой эрх эдлэх ёстой.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

Д.Энхцэцэг: Манай Улс төрийн намын тухай энэ хуулийн хувьд бол ЕАБХАБ Венецийн комисс хамтраад ноднин жил Улсын Их Хурлын даргаас өгсөн хүсэлтийн дагуу бол уншаад бүх хуулийг бүхэлд нь уншаад бол санал зөвлөмж өгсөн. Тэгэхээр энэ санал зөвлөмжийг бол ажлын хэсэг маш анхааралтай хараад, тэгээд Монгол Улсынхаа онцлогийг бас харгалзаж байгаад авах ёстой саналуудаа үндсэндээ аваад тусгасан. Тэгээд ерөнхийд нь дүгнэж хэлэх юм бол энэ хуулийн төслийг бол олон улсын стандартуудад дөхсөн сайн төсөл болжээ гэж сайшааж дүгнэсэн байгаа. Тэгээд энэ баримт бичгийг бол Монгол хэлнээ Венецийн комиссын веб сайт дээр сайт дээр байгаатай та бүхэн бас танилцах боломжтой.

Л.Мөнхбаатар: Сая хэн хариулав? Асуултад хариулж байгаа ажлын хэсгийн гишүүд нэр, албан тушаалаа хэлээд хариулж байгаарай. Яагаад гэвэл энэ өөрөө протоколд үлддэг. Хэний асуултад хэн хариулсан бэ гэдэг нь нэгдсэн протоколд үлддэг журамтай шүү гэдгээ хэлье. Ням-Осорын Учрал гишүүн асуултаа асууя.

Н.Учрал: Энэ Улс төрийн намын хуулийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ би энийг бас 2 талаар нь 1 өнцгөөс л бид их яриад байгаа юм л даа. Энэ Улс төрийн намын хууль бол нөгөө намуудыг хариуцлагажуулахаасаа гадна энэ үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг нь олгож байгаа улс төрийн намуудад тэр улс төрийн боломжийг нь олгох талаас нь бас харах ёстой. Тэгэхгүй болохоор хэтэрхий их намын дүрэм рүү

ороод, тэгээд хэт их намын бүтцийн асуудлыг хуулиар хийгээд эхэлбэл энэ өөрөө нөгөө төрийн дээр нам оршино гээд ингээд буруу зүйл рүү явчихна. Тийм учраас ерөөсөө л энэ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний чинь хамгийн том илэрхийлэл нь өөрөө улс төрийн нам байхгүй юу. Тэгэхээр тэр нэг үндэсний эв нэгдэл бүрэн эрхт байдлыг гээд нэг заалт байна шүү дээ одоо нөгөө намууд дээр. Яг ийм том өргөн агуулгаараа авч үзэх юм бол яг үнэндээ бол нөгөө нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэгдээд 1 нам байгуулах, нөгөө нэг шашны намууд байгуулагдах, тодорхой зорилгоороо эвлэлдэн нэгдэх чинь өөрөө хөндөгдөөд тийм боломжгүй болох ийм эрсдэлтэй байхгүй юу. Тэгээд ер нь бол аль ч сонирхлын бүлгүүд өөрөө нам байгуулаад ингээд дуу хоолойгоо нэгтгээд ажиллах бололцоотой шүү дээ.

Тэгэхээр энэ Улс төрийн намын хууль бол Монгол Улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөө хангагдах тэр суурь боломжийг нь энэ хуулиар нь олгож байж тэр үг хэлэх эрхийг нь улс төрийн намуудад нь тэгээд илэрхийлэх боломжийг нь олгож байж энэ чинь өөрөө цаашидаа ардчилалд маш том хувь нэмрээ оруулах ёстой байхгүй юу. Хэтэрхий намын бүтэц дүрэм рүүгээ орсон ойлголтууд бас харагдаад байгаа юм. Жишээ нь яг ингээд хуулийг уншихад бол жишээ нь тэр үндэсний эв нэгдэл бүрэн эрхт байдалтай нэг заалт байна шүү дээ. Тэрэн дээр бол жишээ нь яг тийм шашны нам байгуулах, тийм хөгжлийн бэрхшээлтэй иргэд нам байгуулах, эсвэл яг эмэгтэйчүүд нэг нам байгуулах эд нарт бол зорилгын хувьд үгүйсгэх вий дээ. Энийг бол илүү нээж, баталгаажуулж өгч чадсан цагт энэ ардчилал эрх, эрх чөлөө чинь бас өнө мөнхөд оршино шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол онцгой анхаармаар байна гэж бас хэлмээр байна.

Тийм учраас тэр түрүүний гишүүдийн хэлээд байгаа тэр нэр дэвшигчдэд тавигдах тэр янз бүрийн ёс зүйн хороо, тэр нэр дэвшигч нарын ёс зүйн

хороо юу, юу билээ хариуцлагын хяналтын тийм нэг хороо байгуулна энэ тэр гээд байгаа чинь. Ер нь бол улс төрийн нам ямар ч бүтэцтэй байж болно. Тэр улс төрийн намын өөрийнх нь онцлог. Улс төрийн нам бол ямар зохион байгуулалт тогтолцоогоор үйл ажиллагаа явуулах нь тухайн улс төрийн намын өөрийнх нь эрх чөлөө байхгүй юу. Тийм. Тэгэхээр тэрийг хэт их хуульчилж болохгүй гээд сая Нямаагийн Энхболд даргын хэлж байгаа бол би 100 хувь санал нэг байна. Тэгээд эхлэх юм бол өөрөө энэ бол ардчиллаас ухарч байгаа л ойлголт болно. Тийм учраас улс төрийн намууд үйл ажиллагаа явуулах бололцоог нь илүү бий болгож өгөх дээр бас анхаараач гэдгийг бас хэлмээр байна.

3-д энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр энэ нөгөө шил ажиллагаа явагдсанаас хойш улс төрийн намууд дээр улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө гээд ингээд байгаа шүү дээ. Түүнд өгсөн хандивын мэдээлэл ил байна гээд заачихсан юм. Үүнээс болоод ерөөсөө одоо нөгөө нэг санхүүжилтийн асуудлуудыг нь буюу төсвийн яг тийм нарийвчилсан бүүр зааж өгмөөр байгаа юм. Тэгээд энэ ил тод байдлыгаа ойлгомжтой болгож, энэ нөгөө авлигын эсрэг конвенцод чинь улс орнууд нэгдээд, нэгд бол улс төрийн намуудынхаа ил тод байдлыг л сайжруулж байна шүү дээ. Гэтэл энэ шил ажиллагааны хүрээнд бол улс төрийн намууд огт мэдээлэл явуулдаггүй л байхгүй юу. Хэн ч ойлгомжгүй нэг файл хийлгээд. Тэгэхээр энийг бүүр ингээд детальчлаад энэ санхүүжилтийг ил болгоод өгчхөөч. Тэр олон бүтэц нэгж юмнуудаа ер нь авчихсан нь дээр юм биш үү л гэдэг ийм л.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулах уу, хэн хариулах юм? бэ Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

А.Бямбажаргал: Учрал гишүүний асуултад хариулъя. Гишүүн бол бас их чухал асуудал яах аргагүй хөндөж байна.

Яагаад вэ гэхээр жишээлбэл би асуултыг бас буруу ойлгоогүй бол шашны, сонирхлын бүлгүүдийн нам байгуулах энэ зүйлийг бол хаачаагүй байгаа даа гэж бас хэллээ гэж ойлголоо. Яг одоогийн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улс төрийн намын хуулиар бол яг энэ асуудал бол бас хориотой байгаа гэдгийг би хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл тодорхой ашиг сонирхлын бүлгүүдээр энийг байгуулахыг бол хязгаарласан зохицуулалт бол бий. Яг энэ концепцын дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийнх нэмэлт, өөрчлөлтийн 19 оны өөрчлөлтийн улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж байсан энэ концепц бол өөрөө бүхэлдээ яг энэ рүү л чиглэж байсан.

Өөрөөр хэлэх юм бол тодорхой сонирхлын бүлгүүдээр дамжиж улс төрийн нам байгуулагдахыг бол Үндсэн хууль өөрөө хязгаарласан байгаа гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм. Яг энэ концепцын дагуу бол энэ хууль өөрөө бичигдсэн. Тухайлбал уг хуулийн маань төсөлд байж байгаа тодорхой чиглэлийн тухайлбал 10 дугаар зүйлийн 2-т шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист түүнчлэн гадаад улсын салбар нэгжийг байгуулахыг хориглож байгаа маань өөрөө бүхэлдээ яг энэ заалтыг бол илүү тодруулах чиглэлээр бас явсан гэдгийг би тодруулж хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл хууль санаачлагчийн хувьд бол Монгол Улсын энэ өнгөрсөн хугацаанд бол гарч байсан бас Дээд шүүх дээр бүртгүүлэхээр очиж байсан намуудын мэдээллүүдийг бол бүгдийг нь судалж үзсэн юм. Тэгээд энэ хүрээнд тухайлбал яг шашны чиглэлийн нам, тодорхой үзэл суртлыг давамгайлсан нам байгуулах ийм чиглэлээр хүсэлтүүд өгч байсныг нь Монгол Улсын дээд шүүх бол татгалзаж байсан юм байна лээ. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн маань үзэл санаанд бол харш юм гэж. Тэгээд энэ дагуу бол бас ингэж өргөн баригдсан гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Тэр намын дотоод зохион байгуулалт үйл ажиллагаа мэдээж хэрэг

энэ ардчилсан зарчимд нийцэх ёстой гэдэг агуулгаараа бол дүрмээр өөрөө зохицуулах нь зөв. Аль болох деталийн харилцаа руу бол угаасаа хууль орох нь өөрөө мэдээж тэрний хуулийн маань зорилго биш байсан. Тэгээд энэ үүднээсээ бол тодорхой зүйлүүдийг тодруулах асуудлуудыг нь тодруулж, бусдыг нь бол намын дүрэмд бол зааж өөрөөр зааж болох гэдэг энэ зүйлүүдийг нь бол нээлттэй үлдээсэн гэдгийг хэлэх гэсэн юм.

3 дугаарт бол яах аргагүй тэр Нийтийн мэдээллийн энэ хуулийн маань хэрэгжилттэй холбоотой асуудлууд байгаа юм билээ. Тэгээд яг энэ зорилгоор бүхэлдээ энэ санхүүжилттэй холбоотой бүлэг, таны сая дурдсанчлан энэ нийтэд ил тод байх, мэдээлэгдэх гэдэг энэ зүйлүүд нь бол тухайлбал аудитын байгууллагаар хянагдах, сонгуулийн төв байгууллага дээр нэгдсэн мэдээллүүд нь байршаад, олон нийтэд мэдээлж байх заавал гэдэг ийм байдлаар бол үүрэг хүлээлгэх хэлбэрээр бол бас орсон. Дагаад бол энэ зүйлүүдийг нь ил болгохгүй бол Зөрчлийн хуульд заасны дагуу бол хариуцлага хүлээх гэдэг ийм байдлаар санкцтай нь бас уяаж өгсөн гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Ажлын хэсэг нэмж хариулах уу? Хэн бэ? Тийм. Тэгэхээр тодорхой асуултууд байна. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн хэд вэ? 85 дугаар микрофон өгье. Гэрэлт-Од юм байна. Асуултад хариулъя.

Э.Гэрэлт-Од: Баярлалаа. Улс төр судлаач Гэрэлт-Од. Ажлын хэсэгт бас энэ санхүүжилттэй холбоотой асуудал дээр бас задаргаа хийж харж байсан. Улс төрийн намын санхүүжилтийн асуудал үнэхээр чухал ялангуяа ил тод байх. Угаасаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ хуулийн нэг концепц нь бол энэ намын санхүүжилт, хөрөнгө, орлого нь ил тод байна. Намууд санхүүгийнхээ тайланг ил тод байлгана, жилд 2 удаа, хагас жилээр, бүтэн жилээр тайлангаа тавина. Гишүүдийн хандив нь ямар байх юм, нам ямар орлого олох юм,

хуулийн этгээдээс ямар түвшинд хандив өгч болох юм, юу нь болохгүй юм, гишүүдийн мэдээлэл нь хүртэл ямар байх юм энэ тэр гээд нэлээн нарийн зохицуулалтууд орсон байгаа. Тийм. Тэгээд тэр ялангуяа тэр сая ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаагаар бол аж ахуйн хуулийн этгээдээс өгч байгаа хандив эрх бүхий хуулийн этгээдийн хандив нь бол заавал татварын дараах орлогоос, тэгээд үндсэн бенефициер гэж хэлдэг тэр ашиг хүртэгчээс нь байна, давхардуулж олгохгүй байна, тийм эцсийн өмчлөгчөөс байна энэ тэр гээд ингээд ийм хуулийн заалтууд бол нэлээн дэлгэрэнгүй туссан байгаа.

Яг энэ хуулийн концепт дээр ахиад нэг өгүүлбэрээр нэмээд хэлэхэд бол энэ улс төрийн намууд бол байгаа энэ оруулж байгаа саналаар бол нийтдээ 8,4 тэрбум төгрөгийг бол жилд хуваарилж авах боломжтой. Тэгээд гишүүдийн саналаар сонгогчдын, сонгогчдын дэмжлэгээр, гишүүдийн суудлаар гэсэн 2 үндсэн үзүүлэлтээр санхүүжилт авна. Аль. Тийм улс төрийн намууд санхүүгийн бүх үйл ажиллагаа нь зөвхөн нэг дансаар явна. Намын дэргэдэх байгууллагууд, намын харьяа байгууллагууд, намын салбар байгууллагууд зөвхөн нэг дансаар санхүүгийнх нь үйл ажиллагаа нь гарч орж, тэгээд тэрнийхээ хүрээнд тайлангууд нь жигдэрч, ерөнхийдөө улс төрийн намын санхүүжилт өнгөрсөн 33 жилийн хугацаанд байсан тийм, болохгүй. Тийм. 33 жилийн хугацаанд байсан муу туршлагыг ингээд ил тод болгож, хариуцлагатай болгоход чиглэсэн гэж хэлэхэд.

Л.Мөнхбаатар: Хэн, тодруулах юм уу та? Ням-Осорын Учрал гишүүн тодруулж асууя.

Н.Учрал: Энэ Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хууль дээр бид хийхдээ нэг алдаа гаргачихсан юм байна лээ. Үнэн зөв бүрэн бүтэн байдлыг нь мэдээллийн үнэн зөв бүрэн бүтэн байдлыг хангуулж илгээхгүй гэж заагаагүйгээс

болоод одоо өөрийнхөө веб хуудсанд мэдээллээ тавь гээд, өөрийнхөө ямар нэгэн ХМХ-ээр зарла гэгчихсэн чинь хэнд ч ойлгомжгүй нэг файл сайт дээр тавьсан болоод бид мэдээллээ нээчихлээ гээд байдаг. Тэгээд өнөөдөр улс төрийн намууд ч гэсэн яг ийм байдалд хүрэхийг болзошгүй байхгүй юу. Тийм учраас үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангуулсан мэдээллийг нээлттэй мэдээллийн системд болон өөрийнхөө мэдээлэл хариуцагчийнхаа зүгээр олон нийтийн хэрэгслээр мэдээлнэ. Тэгээд энэ нь үнэн зөв бүрэн бүтэн байдлыг хангаагүй бол тухайн тэр Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ гэх юм бол аль, аль талдаа хариуцлагатай болно. Ер нь энэ хуулийн хамгийн гол онцлог бол улс төрийн намууд ил тод л байх ёстой гэдэг рүү орох ёстой болохоос биш бүтэц нэгж рүү орохоос илүү үг хэлэх эрх, эрх чөлөөг улс төрийн намдаа өгч, олон нам байх бололцоог нь бүрдүүлэх нь л чухал байгаа юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр 1 зүйлийг тодруулж хэлье Учрал гишүүний асуултад. Бид энэ хуулиар зөвхөн ерөнхий бүтцийг л зааж өгсөн байгаа. Удирдах дээд байгууллагатай байна. Тэрнийх нь эрх хэмжээ ийм байна. Тэгээд төлөөллийн байгууллага байна, тэрний эрх хэмжээ бол дүрмээр явна. Гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээ дүрмээрээ явна. Дэргэдээ ТББ-тай байж болно, тэрийг энүүгээр зохицуулахгүй, дүрмээрээ зохицуулна. Намын дүрэм болон ТББ-ын хууль дүрмээрээ гээд анхан шатын нэгж байх уу, үгүй юү, анхан шатанд нэгж байх уу, дунд шатанд байх уу гэдэг асуудал энэ хуулиар зохицуулагдахгүй. Зөвхөн дүрмээрээ зохицуулагдана гээд ерөнхий нам үүсгэн байгуулах болон намын удирдах байгууллагатай холбоотой бүтцийн зүйлүүдийг л оруулж өгсөн болохоос бусад бүх асуудлыг нам өөрөө дүрмээрээ шийднэ гээд л өгчихсөн байгаа.

Л.Мөнхбаатар: АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Улс төрийн намын тухай хууль хэлэлцэгдэж байна. АН-ын болоод АН-ын бүлгээс саналууд өгөгдөөд бас нэлээн ороод ажлын хэсэгт ороод бас идэвхтэй ойлголцоод ажиллаж байгаа. Энэ дээр нөгөө бас нэг гол 2 зүйлийг бас нэг дахин нэг тодотгож хэлэхийг хүсэж байгаа нь ер нь Монгол Улс өнөөдөр намжсан тогтолцоотой орон болчихлоо гэдгийг тоо баримт ч бүхий л зүйл бас харуулж байгаа юм. Мэдээж яах вэ парламентын засаглалтай улсад нам чадавхтай потенциалтай байх ёстой. Гэхдээ намын гишүүдийн албан болоод албан бус тоонуудыг нэгтгээд үзэхэд өнөөдөр коммунист тогтолцоотой байгаа Хятад улсын Коммунист намын гишүүдийн тооноос ардчилсан Монгол Улсын албан ёсны хатуу гишүүнчлэлтэй намын гишүүдийн тоо илүү гарчихсан ийм намжсан улс руу л явж байгаа. Яг энэ хууль дээр АН-ын өгөх барьж байгаа байр суурь бол энэ хатуу гишүүнчлэлээс бас татгалзъя. Хатуу гишүүнчлэл өөрөө бид нарыг бас тэр намжсан төрийн тухай ойлголт руу хэтэрхий хөтлөөд байна. Энд бас олон нийт болоод нийгмийн хөгжил дэвшил ч бас энэ нь тийм таатай биш байна гэдэг үүднээс хатуу гишүүнчлэлээс татгалзъя гэдэг байр суурийг гаргасан. Тэгээд энэ бас ойлголцол зөвшилцөл ажлын хэсэг дээр бас ингээд дэмжигдээгүй.

Нөгөө талаасаа ингээд улс дамжсан бүтэцтэй, хатуу гишүүнчлэлтэй ийм намууд үүсээд явж байгаа тохиолдолд мэдээж манайх шиг орны хувьд бас санхүүгийн санхүүжилтийн асуудал гарч ирнэ. Гэтэл яг ийм хатуу гишүүнчлэлтэй улсын хэмжээний бүтэцтэй ийм намууд бий болчихоод байхад нөгөө талд нь санхүүжилтийн асуудал бас хэтэрхий тийм нэг хатуу байна уу? Иргэн 6 сая төгрөг, ААН 20-иод сая төгрөг. Гэтэл энэ санхүүжилтийн асуудал илүү жаахан

либерал байх ёстой гэдэг ийм байр суурийг уг нь бид бүгд бас илэрхийлж байгаа. Татвар төлсөн мөнгөнөөсөө төлөөд иргэн, ААН энэ мэдээлэл веб сайт олон зүйл дээр ил тод нээлттэй байгаа тохиолдолд энэ санхүүжилт чинь өөрөө харин тэр дэмжигчдийн, гишүүдийн оролцооны хамгийн дээд хэлбэр биз дээ? Санхүүгээрээ оролцоно.

Гэхдээ энэ нь ил тод байна. Энэ хуулийн дагуу мөнгөөр оролцоно гэдэг энэ концепт бол яг энэ хатуу гишүүнчлэлтэй энэ нам намтай тохиолдолд илүү их тийм. Ер нь тэгээд энэ Америкийн улс төрийн бид нарын даган дуурайдаг ардчиллыг Америкийн улс төрийн тогтолцоо ч гэсэн хэн их санхүү мөнгө босгоно энэ өөрөө бараг улс орон даяарх рейтингийн нэг хэмжээг илэрхийлээд явдаг илүү тийм байдаг шүү дээ. Тэгэхээр санхүүжилтийн тогтолцоо илүү либерал тал руугаа, тэгэхдээ хуулийн хүрээнд нээлттэй ил тод байх гэдэг зарчим руу бол илүү байх ёстой байсан юм гэдэг ийм тодорхой саналууд бас энд гараад бас ингээд үлдээд явж байгаа. Тэгээд бусад зүйлүүдийг энэ ажлын хэсэг дээр яригдсан Улс төрийн намын тухай хуулиуд, хуулийн энэ зүйл заалтуудыг зарчмын хувьд бас АН-ын бүлэг ингээд дэмжээд бас тодорхой зүйл заалтууд суугаад ажиллаж байгаа гэдгийг бас тодотгон хэлье. Асуулт бол байхгүй.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл дарга үг хэллээ. Содномын Чинзориг, Батсуурь гишүүн байхгүй байна. Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Улс төрийн сонгуулийн асуудал ярихаар яг л иргэдээс Улс төрийн намын тухай хуулийг хариуцлагажуулах асуудлыг ярьдаг. Тэгэхдээ давхар энэ улс төрийн нам эвлэлдэн нэгдэх гэдэг нь бас ялангуяа хүний эрхийн хамгийн том үзүүлэлт байдаг. Фрийдом Хаус гээд үүний индексээр бид нар бусад олон индексээр бол харьцангуй гайгүй явдаг. Тэрэн дотроо ялангуяа улс төрийн эрх, хүний

эрх энэ тэр хоёроороо бол харьцангуй гайгүй явдаг. Тэгэхээр 1 хэд хэдэн асуултууд байгаад байгаа нь энэ ингээд хориглоно гэсэн мөртөө түүнийг хэрвээ зөрчих юм бол ямар түүнтэй холбоотой санкц байгаад байгаа юм бэ гэдэг нь бас нэг жоохон тодорхойгүй байгаад байх юм. Жишээлбэл иргэнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр эсвэл албадан намд элсүүлэх эсхүл ийм зорилгоор хууль бус нөлөөлөл шахалт үзүүлэхийг хориглоно гээд хуулийн 5.4-д байна. Хэрвээ ийм тохиолдолд тэгвэл ямар хуулийн хариуцлага хүлээх юм бэ 1 дүгээрт.

2 дугаарт сонгуулийн үеэр гэв гэнэт баахан улс төрийн намууд гараад ирдэг. Одоо ингээд идэвхгүй байдалд оруулах юм байна. Хэрвээ тайлангаа гаргадаггүй, хурлаа хийдэггүй энэ тэр улс төрийн намуудыг. Тэгэхээр энэ идэвхгүй болсон улс төрийн намуудаа дараа нь хэрхэн яаж татан буулгах юм бэ? Нөгөө олон хүмүүсийн гарын үсэг буцаж цуглуулж байж татан буулгана гэх юм бол маш их процесстой болно. Тийм тохиолдолд бас яах юм бэ?

3 дугаарт энэ жишээлбэл эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гээд цөөнхийн төлөөллийг илүү сайн хангах юм бол тухайн улс төрийн намд улс төрийн нам гэдэг бол ард түмэн нийт ард түмний төлөөлөл байдаг учраас бас төрөөс өгч байгаа дэмжлэг нь арай илүү байгаад байдаг ийм хууль эрх зүйн зохицуулалт үүнд орсон болов уу, үгүй болов уу? Ер нь бол яах вэ нэг байж болно гээд ингээд нэг ийм хаячихаар тэр бол хэрэгжихгүй явчихдаг л даа. Тэгэхээр үүн дээр ямар зохицуулалт орсон бэ гэдэг нэг ийм хэдэн асуултыг асууя.

Мөн үүнтэй холбоотойгоор энэ Фрийдом хаусын индекс дээр яах вэ бид нарыг улс төрийн эвлэлдэн нэгдэх эрх үзэл санаагаа илэрхийлэх эрх гээд энэ бүгд дээр харьцангуй гайгүй гэсэн мөртөө сонгуультай холбоотой улс төртэй холбоотой СЕХ-ны хэр их бие дааж ажиллаж байгаа вэ гэдэг байдал дээр нэг

жоохон тааруухан үнэлгээ өгсөн байна. Үүнтэй холбоотой ер нь ямар хуулиар үүнийг хэрхэн яаж сайжруулъя гэж ер нь цаашид бодож байгаа вэ? Сонгуулийн улс төрийн намууд маань сайжраад байдаг. Гэтэл хамгийн чухал үйл ажиллагаа нь сонгуульд орох байдаг. Сонгуульд орохтой холбоотой СЕХ-ны үйл ажиллагаанд хэрвээ улс төрийн намууд нь иргэд нь итгэл муутай байх юм бол бас энэ улс төрийн намууд нь хэдийгээр шударга сайн байлаа гээд ч үр дүн муутай болчих гээд байдаг. Энэ талаар бас цаашид ямар арга хэмжээ авах вэ гэдгийг бас судлаачдаас бас давхар асууя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийг хариулъя, хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 80 дугаар микрофон өгье. Бямбажаргал зөвлөхөөс эхлээд дараа нь хүмүүс хариулах юм байна.

А.Бямбажаргал: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Түрүүн та асуулаа. Ер нь санкцтай холбоотой зүйлүүд ер нь ямар зүйл байна вэ гэж. Тэгээд мэдээжийн хэрэг улс төрийн нам бол өөрөө 1 дүгээрт иргэд сайн дураараа, итгэл үнэмшилээрээ хамгийн гол нь нэгдэж байгаа ийм нэгдэл байгаа. Нөгөө талаасаа бол энэ итгэл үнэмшилээрээ нэгдэж байгаа олон нийтийн бусад байгууллагаас ялгагдаж байгаа гол шинж нь бол төрийн эрх барих энэ үйл ажиллагаанд бол оролцож болох энэ бүтцийг өөрөө бий болгож байдаг. Тийм учраас мэдээж хэрэг энэ тодорхой хэмжээний хариуцлагын асуудал бол энэ дээр яригдах нь дамжиггүй. Одоогийн энэ өргөн барьсан төслийн хүрээнд бол дагаж Зөрчлийн хуульд бол өөрчлөлт оруулах, тэр дотроо Улс төрийн намын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах зөрчил гэдэг ийм тусдаа зүйл нэмэгдэж байгаа. Гэхдээ энд барьсан гол зарчим бол мэдээж тэр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх гэдэг энэ эрх, эрх чөлөөг нь бол өөрөө хязгаарлах гэхээс илүү нам институт болох талаасаа өөрөө бэхжих, тэгж ажиллах энэ чиглэлийнх нь тодорхой

хэмжээний санкцууд бол орсон гэдгийг би энд тодруулж хэлье.

Сая таны яг дурдаж байгаа асуудлаар бол мэдээж хэрэг хориглож байгаа. Хориглосон болгон мэдээж санкц байх уу, үгүй юү гэдэг ийм зүйл байдаг боловчиг энэ бол өөрөө итгэл үнэмшил дээрээ тулгуурлаж нэгдэх эсэх асуудал яригддаг учраас энэ бол өөрөө намаас гарах эрх нь бол илэрхийлснээрээ л өөрөө гарчихдаг ийм зүйл байгаа. Мөн хүчээр бол намд энэ элсүүлэх, нэгтгэх ийм зүйлийг бол хориглосон л ийм агуулгаар бас байгаа гэдгийг тодруулъя.

2 дахь зүйл бол та хэллээ. Энэ бүрдүүлэлт, бүртгүүлэхдээ буюу нам үүсгэн байгуулахтай холбоотой ийм зохицуулалтууд ийм байжээ. Энэ татан буулгахтай холбоотой асуудал нь ийм хэцүү байх юм уу гэж байгаа. Татан буулгах асуудал бол харьцангуй энэ зохицуулалтуудыг бол тодруулж өгсөн. Гэхдээ 2 хуваах ёстой. Өөрөөр хэлбэл нам, нам өөрийнхөө санал санаачилгын үндсэн дээр бол татан буугдах гэдэг хууль зүйн асуудал байдаг. Татан буугдах. Өөрөөр хэлэх юм бол төсөлд тусгагдсанаар бол 22.1-д бол намын дээд байгууллагын шийдвэрээр бол намын нэрийг өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, шаардлагатай бол татан буулгах энэ боломжийг нь бол олгочихсон. Тэгээд энд бол заавал 801 хүн энийг шаардах тийм зохицуулалт байхгүй гэдгийг би тодруулж хэлэх гэсэн юм.

Тараах гэдэг бол энэнээс өөр ойлголт. Хууль зүйн бол өөр үр дагаврууд бол үүсдэг. Өөрөөр хэлэх юм бол өөрийнхөө хүсэл шаардлагаас гадуур асуудал болж хувирна гэсэн үг. Хууль зүйн хариуцлагын асуудал гэсэн үг. Энийг бол энэ хуулиар бол нэлээн тодруулж өгсөн байгаа.

Өөрчлөн байгуулагдах бас л сайн дураараа нам өөрсдөө шийддэг, үзэл бодол дээрээ тулгуурлаж өөрийнхөө үзэл баримтлалыг өөрчлөхөөс авхуулаад бусад намтай нэгдэх гэдэг юм уу, хуулийн

этгээдийнхээ хувьд энэ хэлбэрүүдийг бол хэрэгжүүлээд явах энэ боломжууд бас байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмэх үү? Ажлын хэсгийн, хэн 84 үү? 84 дүгээр микрофон өгье. Баяндүүрэн дарга хариулъя.

Д.Баяндүүрэн: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. СЕХ-ны Ажлын албаны дарга Баяндүүрэн. Энэ Улс төрийн намын тухай хуулиар бол СЕХ-н дээр бол нэлээд хэдэн чиг үүргүүд нэмэгдэж байгаа. Бүрэн эрхүүд нэмэгдэж байгаа. Үүнийгээ дагаад болбол СЕХ-ны бие даасан байдал бол нэмэгдэнэ гэж ингэж үзэж байгаа. Ер нь бол олон улсад олон улсын сонгуулийн байгууллагуудын жишигийг харахад бол улс төрийн намаа бүртгэдэг, улс төрийн намынхаа санхүүжилтэд оролцдог ийм сонгуулийн байгууллагууд бол бий. Жишээ нь бол бид нарын энэ Улс төрийн намын тухай хуулийн төсөлд ороод явж байгаа чиг хандлагыг харахад бол Солонгосын үндэсний сонгуулийн байгууллагын чиг үүрэгтэй бол нэлээд ойролцоо байдлаар ингээд томъёологдож явж байгаа юм.

Үндэсний Солонгосын Үндэсний сонгуулийн хорооны бол үндсэн чиг үүрэг бие даасан байдал энэ тэр бол ер нь нэлээн дэлхийн түвшинд, өндөр түвшинд хангагдсан ийм сонгуулийн хороо байдаг байгаа. Тэгээд энэ чиглэл рүү бол бид нар ингээд ажиллаад явж байна гэж ингэж ойлгож болно. Сонгуулийн төв байгууллагын тухай бие даасан байдлын тухай бол Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд тодорхой заалтууд бол зохицуулагдсан байж байгаа. Мөн энэ хуулийг дагаад нэмэлт, өөрчлөлт орж байгаа хуулиудад бас энэ чиг үүргүүд бас нэмэгдээд явж байгаа гэдгийг танд бас хэлмээр байна.

Мөн СЕХ бол Сонгуулийн Монгол Улс бол ерөнхийдөө ЕАБХАБ-ын гишүүн байгаа. Энэнийхээ чиг үүргийн хүрээнд бол Монгол Улсад явагдаж байгаа бүх

сонгуулиудыг бол ажиглах ийм боломжоор хангах үүрэгтэй. 2016 он оноос эхлээд 20 оны сонгууль, 17 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 21 оны Ерөнхийлөгчийн сонгууль гэх мэтчилэн энэ сонгуулийг бол ЕАБХАБ-ын ажиглагчид урт хугацааны болон ба богино хугацааны ажиглалтыг хийж байгаа. Дээд тал нь бол 400 орчим ажиглагчид ирж манай сонгуульд аудит хийх байдлаар ажиллаж байгаа. Сонгуулийн хороонд өгч байгаа тэдгээр ажиглалт хийснийхээ дараа бол зөвлөмжийг СЕХ-нд өгдөг байгаа.

Сүүлийн үеийн СЕХ-нд ирүүлж байгаа зөвлөмжүүдийнхээ дагуу бол Монголын сонгуулийн зохион байгуулалтын хувьд явагдаж байгаа сонгуулиудын хувьд бол 99 хувийн эерэг гэсэн ийм үнэлгээг бол өгч байгаа. Хууль тогтоомжийн хувьд бол түрүүн яригдсан тодорхой чиглэлүүд дээр бол энийгээ хууль тогтоомжоо боловсронгуй болгох чиглэлийг бол бас өгөөд явж байгаа. Ийм учраас бол гадаад орчиндоо бол сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагааны үнэлгээ бол эерэг байгаа гэдгийг танд хэлмээр байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд хариулъя.

Н.Энхболд: Сая Булгантуяа гишүүн их чухал асуулт хариуллаа, асуулаа л даа. Жишээ нь албадаж намд элсүүлэх эсхүл ийм зорилгоор хууль бус нөлөөлөл шахалт үзүүлэхийг хориглоно гэж байгаа юм. Энэ ямар учиртай, ямар санцитай байх вэ гээд. Жишээлбэл хүнийг нам бус бол чадалтай боловсролтой хүнийг ажилд тавихын тулд чи заавал намд элсэж байж энэ ажилд очно шүү гэж шаардлага тавьж болохгүй л гэсэн үг байхгүй юу. Тэгээд тэгчих үү, тэгээд байвал яах юм бэ гэвэл хүн өөрөө сонгох эрхтэй. Үгүй ээ, тэгэхгүй. Энэ нам намайг хийж чадах ажлаа хий гэхээр заавал намд элсээд дараа нь энэ ажилд оч гэж байна гээд байдаг асуудал тавина гэдэг бол

өөрөө тэр намын хувьд маш хортой үр дагавартай ийм үзэгдэл болох юм байгаа юм.

Ер нь энэ жишээ нь нам өөрөө иргэдийн улс төрийн үзэл хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого явуулдаг, сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргадаг ийм нэгдэл. Тэгэхээр хамгийн том шийтгэл бол ерөөсөө сонгуулиар дүн тавих тухай л асуудал гэж ойлгож байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хууль дотор байгаа намын тодорхойлолт яаж үйл ажиллагаа явуулах юм, болохгүй бол яаж шийтгэл хүлээлгэх юм гэдэг зүйлүүд нь бол бүгдээрээ хоорондоо уялдаа холбоотой зүйлүүд гэж ингэж харах ёстой юм байгаа юм. Хуулиар нам ийм байх ёстой. Гэтэл чадаж байна уу, үгүй юү гэдгийг нь ерөөсөө л сонгуулиар дүн тавих асуудал шүү дээ. Сонгуульд амжилтгүй оролцоод л, нийгэмд дэмжлэггүй болбол тэр нам нөгөө улсын хэмжээний бодлого гаргадаг, үйл ажиллагаа явуулдаг ийм эрхгүй л болно гэсэн үг. Боломжгүй болно гэсэн үг. Тэгэхээр дахиад хэлэхэд хамгийн том шийтгэл эцсийн дүндээ энэ сонгуульд амжилтгүй оролцох, тэгээд дэмжлэггүй болох тухай асуудал гэж ойлгох ёстой. Энэ бол хамгийн хүчтэй зэвсэг. Энэ зэвсэг бол сонгогчдын иргэдийн өөрсдийнх нь гарт байж байгаа.

Л.Мөнхбаатар: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Мэдээж улс төрийн намууд сонгуулиар дүнгээ тавиулах нь бол чухал. Гэхдээ сонгууль хүртэл хохирч иргэд бас үлдэж болохгүй учраас ямар нэгэн улс төрийн дарамт үзүүлэх юм бол үүнтэй холбоотой авдаг арга хэмжээ бас их тодорхой байх ёстой. Ялангуяа сонгуулийн дараагаар ингээд л баахан албан тушаалтан холилоо солилоо гэхэд жишээлбэл хэнд хандах вэ, ямар хуулийн дагуу саяын хориглоно гээд ингээд оруулчихсан байлаа гэхэд энэ ганцхан төрийн албан юунд ч биш байх. Жишээлбэл газар олголтоос авхуулаад л

иргэдэд нам харгалзаж өглөө гэдэг гомдлууд хүртэл гардаг. Тэгэхээр энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ гэдэг нь их тодорхой байх ёстой гэж би зүгээр хувь хүнийхээ хувьд боддог юм. Манай олон хуулиуд нэг иймэрхүү байгаад байдаг.

Дээрээс нь нэмээд энэ Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль дээр бүх шатны сонгуульд улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25-аас доошгүй байна гэж байдаг. Энэ энэ хууль дээрээ энэ органик хууль дээрээ бас давхар орох ёсгүй юм уу? Одоо энэ хууль дээр бол ганцхан нэр дэвшилттэй.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 85 дугаар микрофон өгье.

Э.Гэрэлт-Од: Баярлалаа Булгантуяа гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт энэ хуулийн 8.5 дугаар зүйл дээр нам, оролцоо, төлөөлөл нь хангагдахгүй байгаа бүлэг рүү чиглэсэн үйл ажиллагааг бүүр дотоод ардчиллынхаа хүрээнд зохион байгуулах ёстой гээд ингээд заачихсан. Энэ заалт бол намын бодлого үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл оролцоог хангаж ажиллана гээд. Энэ ажлын хүрээнд бол энэ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагаа бусад олон улсын байгууллагуудын хүрээнд нөгөө жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо энэ тэрээ бусад залуучуудын оролцоог дэмжсэн бусад гэрээ конвенцуудыг дагаж мөрдөх энэ чиглэлээр намууд бодлогоо боловсруулах ийм боломжуудыг бас олгож байгаа гэж хэлж болно. 2 дугаарт намын дотоод бүтцийн байгууллага дээр зөвхөн нэр дэвших биш бас 17.6 дээр намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх байгууллага.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүн байхгүй байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Бид нар бүгдээрээ ярьж байна л даа. Улс төрийн намын гол зорилго бол нэг талаасаа мэдээж улс төрийн намуудыг хариуцлагажуулах. Энэ нь өөрөө хуулиар зохицуулалтыг бий болгоё гэж ярьж байгаа. Нөгөө талаасаа үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх энэ өөрөө бас Улс төрийн намын тухай хуулийн бас нэг зорилго, агуулга гэдгийг бол бүгд бид ярьж байна. Бид манай улс ард иргэдийн хувьд бол үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх тал дээрээ маш энэ эрхээ сайн эдэлдэг. Харин нөгөө яг улс төрийн намын хариуцлага тал дээрээ бол яг үүргээ сайн биелүүлж чадахгүй явж ирж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ удаагийн энэ Улс төрийн намын тухай хуулийн нэг гол зорилго нь бас намыг хариуцлагажуулах асуудлыг бол нэлээд бас шинэчилж оруулж ирж байгааг би бол ажлын хэсгийн гишүүний хувьд бол талархаж байгаа. Жишээлбэл 2 жил дараалаад сонгуульд идэвхгүй оролцсон тохиолдолд татан буулгах, санхүүжилтийг зогсоох, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, улс орны хэмжээний үйл ажиллагаа явуулдаг байх гэх мэтчилэн заалтууд бол энэ шинээр ингээж орж ирж байна. Тэгэхээр бид нар бүгд сая хүртэл ярьж байна. Ингээд сонгууль дөхөхөөр улс төрийн янз янзын намууд амилаад ирдэг бусад үед унтчихдаг. Өнөөдөр гэхэд 36 нам байна гэж байхад институт хэлбэрээр яг л улс орны хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа 2, 3-хан, 1, 2-хон л байна шүү дээ яг үнэнийг хэлэхэд.

Тийм учраас бид нар энэ яагаад ийм олон нам сонгууль болохоор ингээд амилаад бусад үед унтаад л эсвэл жагсаал цуглаан болохоор ирчхээд л иргэдээ талцуулаад л ийм байдал бий болчихсон. Өнөөдөр бид төрийн баяр наадмаа тэмдэглэх, тэмдэглэхдээ хүртэл

улс төржөөд байна шүү дээ. Тэр намын гэр, энэ энэ намын гэр гэдэг юм уу, эсвэл сум тосгон, хороо дүүрэгт ард иргэдээ бүүр ингээд намаар нь талцуулаад. Энэ нь өөрөө улс орны хөгжил энэ тогтвортой байдалд цаашлаад бүүр үндэсний аюулгүй байдалд ч гэсэн сөрөг нөлөөтэй. Жишээ нь би хувьдаа иргэдээ аль нэг намаар нь ялгаварлахыг бол үнэхээр буруу гэж үздэг. Тийм учраас бид энэ удаагийн энэ Улс төрийн намын тухай хууль бас хэт улс төржихгүй байх, хэт намчирхахгүй байх, ялангуяа хүн ам цөөтэй манай улсын хувьд тэр дундаа тэр сумд, тосгон, хороон дээр хэт энэ улс төржилтийг цаашдаа байхгүй болгох тал дээр яг илүү ийм заалт орж, ийм агуулгаар бид нар бас тусгаж өгч байгаа гэдэг дээр бас ажлын хэсгийн ахлагч маань, энэ ажлын хэсгийнхэн маань иргэддээ бас зөв мэдээлэл өгвөл их зүгээр байна. Энэ өөрөө бол их чухал зүйлтэй байгаа. Ер нь цаашдаа ингээд улс төржихгүйгээр явах нь өөрөө энэ улс төрийн нам чинь институт байгаад, улс орны хөгжлийн манлайлж явдаг тэр мотор нь байж болдог тийм л байх зүйл нь чухал болохоос биш бид нар энэ улс төрийн намыг тухайн нэг хүмүүст нам байгуулахад зориулж хууль гаргаагүй. Тийм учраас энэ дээр ямар заалтуудаа бас нэлээд иргэддээ зөв тайлбарлаж ойлгуулах нь зөв болов уу гэсэн бодолтой байна.

Энэ хуульд орсон нэг чухал зүйл байгаа. Түрүүн Энхбаяр гишүүн энийг шүүмжлээд байх юм. Уг нь бол маш зөв заалт гэж би бол харж байгаа. Мэргэжлийн хүмүүсийн зүгээс ч хэлж байгаа энэ 16 дугаар зүйлийн намын бүтэц, зохион байгуулалт дээр хяналтын байгууллагатай байна гэдэг бол зөв гэж бодож байгаа. Яагаад гэвэл одоо ялангуяа жагсаалтаар орж байгаа тохиолдолд тухайн намын даргын эрх мэдэл бол маш хүчтэй болно. Тэгэхээр 1 хүн түүний эргэн тойрны хүрээлж байгаа хүмүүс тэр дэндүү илүү эрх мэдэл эдлэхгүй байх дээр хяналтын байгууллага нь хяналт тавьчихдаг. Энэ болохгүй, энэ шударга байх. Яг энэ шалгуурыг энэ хүн хангаж

чадаж байна уу, үгүй юу, жагсаалтаар орж байгаа хүмүүсийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлээд энэ хүн шалгуурыг хангасан, энэ хүн хангаагүй гэдгийг энэ хяналтын байгууллага нь шударгаар шүүгээд, тухайн намынхаа Удирдах зөвлөл, Үндэсний зөвлөлдөө оруулдаг байх, тэд нар нь шударгаар бас энэ дэвшүүлдэг байх энэ өөрөө саяын бид нарын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гол зорилго байгаа.

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт бодит амьдралд яг ард иргэдийн хүсэн хүлээж байснаар хэрэгжихэд энэ Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль маань гол шалгуур болж өгөх ёстой. Тэгэхээр энэ маань ингээж чадах уу? Үндсэн хуулийн өөрчлөлт энэ Улс төрийн намын тухай хуулиар яг бидний хүсэн хүлээж байсан өөрчлөлтийг авчирч чадах уу гэдэг дээр бас хариулт авахыг хүсэж байна. Энэ өөрөө их чухал.../минут дуусах/

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя, хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулъя. Хэн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга хариулъя, нэмээд ажлын хэсэг хариулаарай.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ хуулийг хууль санаачлагч Ерөнхийлөгч өргөн барихдаа ч гэсэн улс төрийн намуудыг хариуцлагажуулах, санхүүгийн хувьд ил тод нээлттэй байлгах, улс орон даяар байнгын үйл ажиллагаа явуулдаг байх гээд энэ гол гол зүйлүүдийг бий болгох зорилгоор л энэ хуулийг оруулж ирсэн. Бид 2019 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа улс төрийн намуудыг хариуцлагатай, чадавхтай, санхүү нь ил тод нээлттэй байлгах энэ л чиглэлээр бид нар өөрчлөлт хийгдсэн. Энэ өөрчлөлтийг Үндсэн хуулийн өөрчлөлтийг биежүүлж байгаа хууль бол яахын аргагүй Улс төрийн намын хууль байгаа. Улс төрийн намын хуулийн хамгийн гол том 2 юмны нэг нь бол яахын аргагүй улс төрийн намыг хариуцлагатай болгохтой

холбоотой асуудал бий. Идэвхгүй нам болгох, намуудыг үйл ажиллагааг нь зогсоох, намуудыг тараах, намуудыг нэгдэж өөрчлөн байгуулалт хийх гээд энэ чиглэлүүдтэй холбоотой нэлээн зүйлүүдийг тусгаж өгсөн. Санхүүг нь ил тод байх, аудит байнга хийдэг байх, ингээд бас санхүүтэй холбоотой маш том шинэчлэлийн асуудлууд байгаа.

3 дахь нь юу байна вэ гэхээр ер нь энэ бүх үйл ажиллагаанд нөгөө хяналт тавьдаг СЕХ-ны чиг үүргийг өргөтгөж өгсөн байгаа. Улс төрийн намуудын үйл ажиллагаанд байнга хяналт тавьдаг. Ийм чиглэлийн өөрчлөлтүүд хийгдсэн. Энэний үр дүнд бол ямар ч байсан улс төрийн намыг бол бид нар хариуцлагатай, чадавхтай, санхүү нь ил тод тийм намуудтай болж чадна л гэж ингэж ойлгож байгаа.

Л.Мөнхбаатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Миний гол асуугаад байгаа нь хэт намчирхах, иргэдээ талцуулахгүй байх нь өөрөө маш чухал. Энэ нь өөрөө Улс төрийн намын тухай энэ хууль дээр энэ талаараа тодорхой заалт зорилго орсон уу гэдгийг л асуугаад байгаа юм. Харин энэ Ерөнхийлөгчийн санаачилсан энэ Улс төрийн намын тухай хууль дээр нэг шинэ заалт орсон байгаа. 27.7 дээр энэ нөгөө 27.3-д заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жилд зөвхөн нэг удаа олгоно гэхчхэн байгаа юм. Уг нь энийг тогтмолжуулаад жил болгон болгоод явчих нь их чухал байгаа юм. Ингэх бололцоо байгаа болов уу? Энэ өөрөө энэ бусад улс орны хувьд жишиг болчихсон. Жишээ нь яг хөгжлийн

бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн квот илүү дэвшүүлсэн. Энэ нь өөрөө бас жендерийн баланс барих, цаашилаад улс орны хөгжилд ч гэсэн их хэрэгтэй заалт байгаа юм л даа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя, хэн хариулах вэ? Ажлын хэсгээс хариулах уу? Ажлын хэсгийн 85 дугаар микрофон өгье.

Э.Гэрэлт-Од: Тийм өргөн барьсан төсөл дээр 27.7 дээр бол сонгуулийн жилд нэг удаа өргөн урамшуулал улс төрийн намд нь өгнө гэсэн ийм хуулийн томъёолол орсон байгаа. Ер нь бол гаднын улс орнуудын туршилагаас түрүүний миний микрофоны цаг дуусчихсан нөгөө яалт ч үгүй жендерийн тэгш байдлыг хангах, оролцоо, төлөөллийг нь нэмэгдүүлье гэж бодох юм бол бид нар улс төрийн намуудыг нь илүү хариуцлагажуулах үүднээс, дээр нь улс төрийн намуудад нь бас давхар боломж олгох үүднээс иймэрхүү төрлийн зохицуулалтыг хийж болно. Хуулийн төсөл дээр 2 жилийн өмнөөс боловсрогдож байхад бол жил тутам гэсэн хуулийн томъёолол байсан, бас давхар байсан. Таны яг саналаар бол жил, энэ 27.7-г зөвхөн нэг удаа биш жил бүр олгож болох уу гэсэн асуулт асуулаа гэж ойлголоо. Энийг та санал албан ёсоор гаргах юм бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуултаа асууя.

С.Ганбаатар: Намын тухай хууль дээр бас давуу талтай олон зүйлүүд байгаа. Би ажлын хэсэгт байгаа. Тэгэхдээ сүүлийн хэдэн удаа бас Нийгмийн даатгалын хууль яригдаад бас зарим хурлуудад орж амжсангүй. Би анх хэлэлцүүлэг эхэлж байхад асууж байсан нэг хэдэн зүйлийг тодруулж бас ард иргэдэд та нартай хамтарч мэдээлэл өгье гэж бодож байна.

Ер нь Европт төр шашин хамт байсан учраас Загалмайтны аян дайн ингээд хэдэн 100 жил том дайн болсон.

Улс хоорондын дайн болсон, цус урсгасан. Тэгээд төр шашныг салгасан, дайн зүгээр өргөс авсан юм шиг алга болсон. Монголд бол нам мөнгө 2, тендер 2 хамт учраас энэ бол зүгээр л тийм цус урсгасан дайнтай адилхан зовж зүдэрсэн аймшигтай зүйлүүд байгаа. Миний асуулт юу вэ гэвэл нам хэн нь, хэн нь ч бай төрийн эрхэнд гараад, төрийн бүх ресурсаар намаа угждаг, дэмжигчдээ угждаг энэ аймшигтай зүйлүүд зогсох уу? Миний асууж байгаа зүйл гэвэл нам гарч ирээд төрийн өмчийн компаниуд дээр яг намын идэвхтэн, намд идэвхтэй явсан хүмүүсийг тавьдаг энэ тэнэг байдлыг зогсоогоод нөгөө багш, эмч нарыг нэг намын гишүүнчлэлээс татгалзуулсан ч билүү, түдгэлзүүлсэн шиг төрийн өмчийн компанийн захирлуудыг намд явсан хүмүүс биш шинжээч, эксперт туршилагатай тэр салбарын хүмүүсийг тавьдаг байх энэ зохицуулалт байгаа юу? Нам уг нь бол мөнгө олох мөнгөжих хэрэгсэл биш. Үзэл бодлоороо нэгдэх, тэр мөрийн хөтөлбөрөөрөө нэгдэж ард түмнээ аврах л үзэл бодлын нэгдэл болохоос биш, ГОК-т бараа бүтээгдэхүүн шахдаг группүүдийн нэгдэл биш шүү дээ. Энэ 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Намын дарга эзэн байж 30 жил явж ирлээ. Намын эзэн болчихсон. Уг нь бол намын өмчлөгч эзэд бол гишүүд байх ёстой. Гишүүдийг өмчлөгч эзэн байх үндсэн зүйл юу вэ гэвэл гишүүдийн дунд discuss явдаг, гишүүдийн дунд хэлэлцүүлэг шийдвэр гардаг. Гишүүдийн дунд шийдвэр гаргасны дагуу томилгоо хийж, даргаа, үйлчлэгчээ томилоод, тэрэнд хариуцлагаа тооцдог. Болсон, болоогүй гэж тайланг нь авдаг. Энэ яг нарийвчилсан механизмууд орсон уу? Одоо энэ жижиг намууд зүгээр кармандаа тамгатай, өөрийгөө зүгээр эзэн гээд бодчихсон, хувийн компани шиг юмнууд явдаг. Том намууд ч ялгаагүй. Дарга гэдэг улсууд нь шийдвэрээ гаргадаг. Дараа нь хурал дээр очиж тэрийг хэлбэржүүлдэг. Хурал гэдэг бол жүжиг болчихсон. Энэ тэнэглэлүүдийг зогсоох ямар, ямар механизм орсон бэ?

Хэдэн мянга ер нь бол том бай, жижиг бай намын дарга нар биеэ үнэлэгч биш болчихсон. Хэдэн 100 мянган гишүүд тэр дэмжигчдийн сайхан сэтгэл, амь амьдрал, үзэл бодол, мөрөөдлийг нь худалддаг үнэлэгчид болчихсон явж байгаа. Эрх баригч нарт аваачиж худалддаг худалдаачид болчихсон. Ил тод энэ аймшигтай зүйл яаж арилах бол? Ямар, ямар заалтуудаар орсон бол? Ийм л зүйлийг Монголын ард түмэн хүсэж байгаа.

3 дугаарт Фридрих Эберт, Конрад Аденауэр сан эд нар гээд, тэр Америкт бол IRI... гээд байна, Republic institut эд нар гээд. Тийм байгууллагууд шиг яг мөнгөтэй холбогдохоос өөр аргагүй, гишүүдийн сургалт, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх компани ажил янз бүрийн тийм зүйлүүд дээр тийм судалгааны маягтай институтүүд дээр бүх мөнгөө өгөөд тэд нараар хийлгэдэг энэ механизм тогтолцоо олон улсын практик энэ манайд хэрэгжих мөрөөдөл байдаг юм. Зүгээр. Тэгээд асуусны л гарз байх. Энэ юм байгаа юу?

4 дүгээр асуулт. Тэмцээн бол хэн хурдан гүйх вэ гэдгээ л үздэг юм шүү дээ. Сонгууль бол хэн сайн манифестээ дэвшүүлснээ үздэг. Манайд бол хэн хөлийг нь хуга өшиглөж, хэн дэгээдсэний л уралдаан, дэгээддэг уралдаан.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэн.

Д.Тогтохсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ намын хууль бол нөгөө иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангахтай холбоотой хууль байгаа юм. Эвлэлдэн нэгдэх. Эвлэлдэн нэгдсэнийхээ улмаас нөгөө үзэл бодлоо нэгдэж илэрхийлэх ийм л зохицуулалтыг гол нь хийх ийм л асуудал.

Нөгөө талаас нь таны яриад байгаа энэ төрийн намыг нөгөө юманд ордог оролцоог нь багасгахтай холбоотой асуудлууд бол хэд хэдэн заалтууд бий. Зүгээр намын гишүүдийг тэр төрийн болон ТӨК-ийн удирдах алба болон гүйцэтгэх албан тушаалтнуудад томилохтой холбоотой асуудлыг бол бид нар тэр хуулиар нь зохицуулах хэрэгтэй болов уу гэж бодож байна. Бид нар төрийн албан хаагчдыг нам бус болгосныг Төрийн албаны хуулиар зохицуулсан. Яг түүнтэй адилхан төрийн болон орон нутгийн өмчит гүйцэтгэх удирдлагуудыг нөгөө намаас томилж байгаа томилгоонуудыг байхгүй болгох, сонгон шалгаруулалт руу оруулах, нээлттэй болгохтой холбоотой асуудлыг бол би Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Их Хурал дээр явж байгаа. Үгээр зохицуулах байх гэж бодож байна.

Хамгийн чухал юм энэ нөгөө намын эзэн, намын дарга намын эзэн болдог асуудлыг болиулахын тулд хэд хэдэн юм байгаа юм. 1 дүгээрт намын эрх барих дээд байгууллага буюу Их Хурал 4 жилд, 5 жилд хийгээгүй бол төлөөллийн байгууллагын хурлаа хийгээгүй бол тухайн намыг идэвхгүйд тооцно. Идэвхгүйд тооцно. Санхүүгийн тайлангаа тухайн нам сүүлийн 2 жил өгөөгүй бол тэр намыг идэвхгүйд тооцно. Идэвхгүйд тооцно гэдэг нь яадаг юм гэхээр 1 дүгээрт санхүүжилтийг зогсооно. 2 дугаарт бүх шатын улс төрийн сонгуульд орохыг хорино, хоригдчихож байгаа юм. Ийм учраас намд хамгийн том хариуцлага бол энэ. Таны хэлж байгаа үнэн. Манай Монголд сүүлийн 30 нам байгуулаад л тэрнээс хойш дараагийн хурлаа хийж, намын даргаа өөрчлөх, дотоод ардчиллынхаа чиглэлээр юу ч хийгээгүй намууд дүүрэн байгаа. Эдгээрийг цэгцлэх үүднээс бол энэ хуульд энэ идэвхгүй намыг гэдэг зүйлийг бий болгож, улс төрийн намуудыг байгуулагдсанаас нь хойш тавигддаг үйл ажиллагааг нь, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг сайжруулж өгсөн байгаа. Хариуцлагыг нь ерөөсөө түрүүн хэлсэн идэвхгүй нам руу

орно. Тэгээд дараа нь нөгөө татан буулгах, тараах руу явна гэсэн үг.

Таны ярьж байгаа 2 асуудал 2-уулаа хуульд тусгагдсан байгаа 19 дүгээр зүйл дээр. Нам судалгааны байгууллагатай байна гээд. Заавал судалгааны байгууллагатай байхаар орчихсон байгаа. Харин сантай байж болно гэж байгаа юм, сантай байж болно гэж байгаа. Ер нь цаашид нам энэ иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр нэг судалгааны байгууллага, сангаар дамжуулж л үйл ажиллагаа явуулахад чиглэгдэх байх л гэж бодож байна. Тэгээд манай энэ эрдэмтэн судлаачид нэмж хариулт өгөх байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Мөнхсайхан доктор хариулах юм уу, хэн хариулах юм бэ? Бямбажаргал хариулах уу? Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

А.Бямбажаргал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ганбаатар гишүүн бол ажлын хэсэгт маш дэлгэрэнгүй саналууд бол ирүүлсэн, бас ажил хэрэгч, агуулгын хувьд ч тэр, мөн төслийн утга найруулгын хувьд ч тэр эдгээр асуудлууд дээр аль алинд нь анхаарсан санал ирүүлсэн. Уг саналууд бол ажлын хэсгийн хуралдааны үеэр тусгагдаад ингээд явж байгаа. Таны сая нөгөө тодруулж асуусан үндсэн 2 асуултыг л хэрэг дээрээ энэ хууль өөрөө бүхэлдээ тэрний хариултыг олоход л чиглэж энэ хууль өөрөө боловсрогдсон, өргөн баригдсан байж байгаа. Түрүүн та хэллээ. Намын дотоод ардчилалтай холбоотой асуудлууд, бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудлууд гэж. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд энэ 36 намын дотоод зохион байгуулалт үйл ажиллагаатай холбогдох асуудлууд үнэхээр таны хэлж байгаачлан ийм асуудлууд байж ирсэн юм билээ, одоо ч байна. Тэгээд энийг л шийдэхийн тулд энэ хуулиар саяын яриад байгаа энэ дотоод зохион байгуулалт, ардчилсан байх, жинхэнэ гишүүд дэмжигчдийнхээ нам

байх, цаашид нам, бодлогын нам байх гэдэг энэ чиглэл рүү л энэ хуулийг энэ төслийн бол концепц бол боловсрогдсон байгаа.

Тэгээд санхүүжилт бол яг нөгөө талынх нь тулах багана нь байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуульд орсон энэ нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд энэ төрөөс санхүүжилт үзүүлж болох гэдэг энэ үндсийг тавиад, цаад шалтгаан бол өөрөө хэдийгээр бол татвар төлөгчдийн мөнгөнөөс энэ санхүүжүүлж байгаа. Одоо ч гэсэн байгаа боловч энэ дээр тавьдаг хяналт өөрөө сул явж ирсэн юм билээ. Энэ дээр тавьдаг хяналт. Тэгээд энэ хяналтыг бол механизмын үр дүн, тухайлбал төрөөс үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэгийн маань тодорхой эх үүсвэрүүдийг нь зааж өгсөн. Саяын яг таны нөгөө сая хэлж байгаагчлан энэ сангуудаар дамжуулж, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр, мөн төлөөлөл нь хангагдахгүй байгаад байгаа нийгмийн бүлгүүд бүлгүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт хийх, судалгаа сурталчилгаа хийх, хүний эрх, эрх чөлөөг хангахад гэдэг энэ чиглэлээр бол тэр нөгөө төрийн санхүүжилтийн 50 хувийг, тухайлбал 20 хувийг нь тодорхой тэр сан дээр, 15 хувийг нь бол тэр хүний эрх, эрх чөлөөг хангах, олон нийтэд таниулах чиглэлээр, 15 хувийг бол намын хөтөлбөрөө танилцуулах. Хамгийн гол бол зорьж байгаа зүйл бол энэ нам улсын хэмжээний бодлого явуулахдаа бодлогын нам болох ёстой гэдэг энэ чиглэл рүү энэ хөрөнгө мөнгөө зарцуул. Энэ тайланг нь яг энэ байдлаар нь төрийн аудит бол хянах ийм нөхцөл байгаа.

2 дугаарт төрийн төрөөс шууд бус дэмжлэгийн асуудлууд байгаа. Энэ бол өөрөө зөвхөн нөгөө Улсын Их Хуралд суудал бүхий нам биш бусад намуудад өөрөө бас дэмжлэг үзүүлж болох энэ нөхцөлүүд бол бас орж байгаа юм. Дагаад хамгийн гол нь хариуцлагын асуудал үүгээр сайжрах ёстой. Аудит гэдэг бол хуулийн этгээд тусдаа энэ эрх бүхий

этгээд хийхээс гадна төрийн аудит энэ дээр бас хяналт хийж байгаа маань цаашид олон нийтийн хяналт руу бас оруулах, дээр нь веб сайтуудаар нь заавал сонгуулийн төв байгууллагын веб сайтад эдгээр мэдээллүүд байрших зохицуулалтыг оруулчхаж байгаа юм байна. Олон нийт энэ дээр хяналт тавих энэ боломжийг бас нээж өгч байгаа гэдгийг бас нэмж хэлье.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Баяндүүрэн дарга хариулъя.

Д.Баяндүүрэн: Баярлалаа. Түрүүн гишүүдийн асуултын явцад хариултгүй үлдсэн зарим асуудалд хариулт өгье гэж бодож байна. СЕХ-ны Ажлын албаны дарга Баяндүүрэн. Ер нь бол ямар зорилтот бүлгүүдийн ямар, ямар бүлэглэлүүд бүлгийн хүмүүсийг санал өгөх боломжуудыг нь яаж хангаж байна вэ гэдэг асуудлаар бол түрүүн яригдсан байгаа. Манай СЕХ-ны хувьд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэдийн санал өгөх боломжийг нь хангах эрх зүйн боломжуудыг бол бас түрүүн Ковидын тухай хуулийн явцад болон өмнөх явагдсан сонгуулиудын хууль тогтоомжид бол орчихсон энэ зохицуулалтууд бол тодорхой ажлууд бол хийгдээд явж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд бол санал өгөх ямар нэгэн хаалт тийм зүйл бол байхгүй, бүх боломжийг нь хангаж байгаа гэдгийг бол хэлмээр байна.

2 дугаарт нь бол гадаадад байгаа сонгогчдын асуудал байгаа. Өмнөх 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар бол анх удаа Монгол Улс гадаадад байгаа сонгогчдынхоо саналыг авах ажлыг зохион байгуулсан байгаа. Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд бол мөн гадаадад байгаа сонгогчид саналаа өгдөг байгаа. Энэ удаагийн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн нэмэлтийн дагуу бол гадаадад байгаа сонгогчид маань бол саналаа өгөх боломж нь бол

нээгдсэн байгаа гэж гэдгийг бол тэмдэглэж хэлмээр байна.

3 дугаарт нь бол зөвхөн хорих ял эдэлж байгаа хүмүүсээс бусад урьдчилан цагдан хоригдож байгаа хүмүүс бол санал өгөх боломжоор бол Сонгуулийн хууль тогтоомжийн дагуу хангагдсан байгаа гэдгийг бол энд тэмдэглэж хэлмээр байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад тодорхой хариуллаа. ХЗБХ Чингис хаан танхимд хуралдана. ХЗБХ-ны гишүүд хуралдаандаа оролцоорой. Та тодруулах уу, болчихсон уу? 13 цаг болсон байна. Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна. 14 цагаас Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

13.12 цаг

2023 оны 06 дугаар сарын 29, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 30 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсьё. Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хуулийн эцсийн найруулга дээр саналтай

гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу? Байхгүй байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо. Чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлье. Хэн горимын санал гаргах юм уу? ХЗБХ-н дарга Баттөмөрийн Энхбаяр горимын санал гаргая.

Б.Энхбаяр: Өчигдөр Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддоржоос Улсын Их Хуралд хандан үүрэгт ажлаас чөлөөлөх хүсэлт гаргасан байгаа. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд зааснаар энэ асуудлыг ХЗБХ хэлэлцэж чуулган хэлэлцэж, долоо хоногийн дотор шийдвэрлэх дэгтэй. Тийм учраас сая Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс хэлэлцэж шийдвэрлэж, ХЗБХ уг хүсэлтийг хүлээн авсан байгаа. Тэгэхээр хуульд заасан хугацаатай ийм асуудал орж ирсэн учраас хуулийнх нь хугацаанд шийдвэрлэх хууль зүйн ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас энэ асуудлыг одоо чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх горимын санал гаргаж байна. Санал хураалтын өмнө.

Л.Мөнхбаатар: ХЗБХ-ны дарга Баттөмөрийн Энхбаярын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Гишүүдээ санал хураалт. Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулчихъя. Бүртгэлийн санал хураалт. Одоо санал хураалт явагдана. МАН-ын бүлгийн дарга Тогтохсүрэн, дэд дарга Батжаргал, Оюунчимэг нар ирцээ бүрдүүлье. АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл өөрөө орж ирье. Мөн ирцээ бүрдүүлье. Ингээд Улс төрийн намын тухай хууль хэлэлцэж байхад улс төрийн намын үүрэг оролцоо чухал. Тийм учраас намын бүлгүүд ирцээ бүрдүүлнэ.

ХЗБХ-ны дарга Баттөмөрийн Энхбаярын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 53,5 хувиар санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан хэлэлцэх асуудал дээр ҮХЦ-ийн гишүүнийг чөлөөлөх асуудлыг нэмж оруулж хэлэлцье.

Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцье. ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ХЗБХ-ны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддорж нь 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр ҮХЦ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд ирүүлсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103.1-д Цэцийн гишүүн хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн гэж заасны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн ТГ/512 тоот албан бичиг ирүүлсэн.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддорж нь хүндэтгэн үзэх бусад шалтгаан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох талаар дурдаад, өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан байна.

ХЗБХ 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлд заасан журмын дагуу ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддоржийн ирүүлсэн хүсэлт, Ерөнхийлөгчийн Тамгын газраас албан бичгээр ирүүлсэн саналыг хэлэлцсэн болно. ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддоржийн өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа үг хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр би асуулт байхгүй. Санал хэлэх гэсэн юм. Энэ МАН Улсын Их Хурал дээр олонх байна. Бүх л юманд Засгийн эрх барьж байна. Тэгээд эрх мэдэл нь их багадааг юм шиг байгаа юм. Үгүй ээ тэгээд тэр нэг Цэц гээд байгууллага чинь харин аль болохоор олон ургалч үзэл, тэгээд л олон намын угшил тэнд бол нам бус л байгаа. Тэгэхдээ намын угшил ч гэдэг юм уу ийм зүйл байж байж энэ хууль тогтоомж энэ бүх зүйл чинь шударга болно шүү дээ. Тэгээд энэ

зааланд шударга ёс яриад байдаг хэр нь дандаа гаргаж байгаа шийдвэрүүд нь шударга бус. Би мэдэж байна. Нанзаддорж өөрөө өргөдлөө өгөхөөсөө илүү өгүүлсэн юм. Тэгэхээр ингээд хуучин юу гэдэг юм АН-ын угшилтай гэсэн хүмүүсийг болохоор ингээд өргөдлийг нь хүчээр өгүүлээд байдаг.

Тэгчхээд МАН-ын угшилтай хүмүүсийг нь болохоор нөгөө тэтгэврийн нас нь болчихсон, бүх л юм ингээд л чөлөөлөх боломж байхад ерөөсөө чөлөөлдөггүй. Тэгэхээр энэ чинь өөрөө зүгээр нийгэмд шударга бус байдлыг л харуулж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр та нар ингээд юм их хэтрэхээрээ бялуурахаараа ер нь болдоггүй шүү гэдгийг бас би зүгээр дэд даргын хувьд хэлчихье. Тийм учраас дараа бол зүгээр одоо яах вэ дээ нөгөө өөрөө өргөдлөө өгсөн юм гэнэ лээ гээд энэ нэг хүүхэд хуурч байгаа юм шиг ийм зүйлээ болих хэрэгтэй. Ер нь эрх барьж байгаа намынхан ингээд хэтэрхий юманд нэг хүч түрсэн. Тэгээд сүүлийн үеийн тэр гаргаж байгаа шийдвэрүүд дээр ч гэсэн хар, дандаа улс төрийн захиалгаар ингэж ажиллаж болохгүй шүү дээ. Бид нар энэ үр хүүхдэдээ хойч үедээ шударга нийгмийг үлдээе л гэж ажиллаж байгаа. Тийм учраас энэ дээр бол цаашидаа ингэж их нэг ийм дарангуйлдаг, ингэж их хүч түрдэг, ингэж их намын харьяалаар нь өргөдлийг нь өгүүлдэг энэ байдлаа ер нь болиоч л гэж хэлмээр байна. Та нарт бол эрх мэдэл багадаагүй, та нарынх бол ихдэж байгаа. Та нар харин МАН мөрийн хөтөлбөрөө бол дийлэнхийг нь биелүүлээгүй л байгаа шүү дээ. Өнөөдөр ард түмний амьдрал ямар байгаа билээ. Ийм зүйлүүд дээрээ л ажилла даа. Тэгээд л дандаа нэг албан тушаалын хойноос хөөцөлдсөн.

Үгүй ээ тэгээд тэнд нэг тийм ардчилсан үзэл бодолтой хуучин АН-ын гишүүн байсан хүн байхаар ер нь яах гээд яагаад байдаг юм. Бусад тэр Герман соёлтой орнууд чинь тэр Хууль зүйн сайд нь, Батлан хамгаалахын сайд нь дандаа сөрөг хүчний хүмүүсээ зориуд тавьдаг л

юм байна лээ шүү дээ. Тэгээд 1 ийм хачин арга энэ тэрээсээ ер нь болих хэрэгтэй шүү та нар.

Л.Мөнхбаатар: Одонтуяа гишүүн үг хэллээ. ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддорж Улсын Их Хурлын даргад хандаж бас өргөдөл гаргасан. Энэ өргөдөлдөө бол хувийн хүсэлт буюу ар гэрийн гачигдалтай байдал болон өндөр настны тэтгэвэрт гарахтай холбогдуулан өргөдлөө өгсөн тухайгаа бас дурдсан байгаа гэдгийг бас энд хэлье. Ингээд санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна, нууц санал хураалт явагдана. Бэлтгэл ажил хангагдсан уу? Тамгын газар нууц санал хураалт явуулах бэлтгэлийг хангая. Санал хураалт явуулах бэлэн болсон байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цагааны Нанзаддоржийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 51,2 хувиар санал дэмжигдлээ. ҮХЦ-ийн гишүүн Цагааны Нанзаддоржийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Тогтоолыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Цагааны Нанзаддоржийг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.47 цаг

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Дараагийнхаа асуудалд оръё. Улс төрийн намын тухай хуулийн санал хураалтыг явуулъя. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй нийтдээ 65 санал байна. Санал хураалтад бэлэн үү? Санал хураалтыг явуулъя. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гишүүн” гэснийг, 3.1.7 дахь заалтын “биет ба биет бус хөрөнгө,” гэснийг, 3.1.14 дэх заалтын “шууд, эсхүл шууд бус” гэснийг болон 3.1.13 дахь заалтыг тус тус хасаж, 3.1.3 дахь заалтын “сонгогдсон” гэсний дараа “, томилогдсон” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Адъяасүрэн, Батжаргал, Ганбаатар, Ганболд, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан, Тэмүүлэн, Цогтгэрэл, Энхтүвшин цаашид Ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. 53,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “өдрийг” гэснийг “өдрөөс эхлэх жилийг” гэж өөрчилж, 3.1.6, 3.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.6.“намын санхүүгийн тайлан” гэж тайлант хугацаанд намаас энэ хуульд заасны дагуу гаргасан болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан тайлангийн цахим болон хэвлэмэл мэдээллийн бүрдлийг;

3.1.8.“төрийн санхүүжилт” гэж нам чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж, санхүүжилтийн зохих хэсэгт нь төрөөс мөнгөн хэлбэрээр олгож буй санхүүгийн дэмжлэгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дахь заалтын “ард түмний” гэснийг “иргэдийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “болон тухайн намыг” гэснийг хасаж, 5.9 дэх хэсгийн “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” гэсний дараа “болон холбогдох бусад” гэж нэмж, 5.10 дахь хэсгийн “үзэл бодлоор” гэснийг “үзэл бодол, боловсрол зэргээр” гэж, 5.13 дахь хэсгийн “үүсгэн байгуулахад оролцохыг” гэснийг “үүсгэн байгуулах, гишүүнээр элсэхийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1% хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “24 жилийн” гэснийг “12 жилийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмэх:

“6.8.Улсын дээд шүүхийн Тамгын газар намын нэрийн санг хөтөлж, лавлагаа олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход болон төрийн улс төрийн албан тушаалд намаас санал болгож сонгогдох, томилогдох нэр дэвшигчийг тодруулахад” гэснийг “байгууллагыг бүрдүүлэхдээ” гэж өөрчилж, 8.2.3 дахь заалтын “аль нэг хүйсийн” гэсний өмнө “нэр дэвшүүлэхдээ” гэж нэмж, 8.8 дахь хэсгийг 8.8, 8.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.8.Жендэрийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 01-ний дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

8.9.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,9 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “цахимаар явуулж болно. Ингэхдээ сонгуулийн төв байгууллагаар баталгаажсан программ хангамжийг ашиглана” гэснийг “аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно” гэж, 9.7 дахь хэсгийн “Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын” гэснийг “холбогдох хуульд заасны дагуу” гэж, “хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг мэдээлнэ” гэснийг “энэ хуулийн 43.8-д заасныг баримтална” гэж, 9.9 дэх хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-д” гэж, 9.10 дахь хэсгийн “9.6.1-9.6.7-д” гэснийг “9.6.1-9.6.12-д” гэж тус тус өөрчилж, 9.4 дэх

хэсгийн “Цахим хуралдаан, санал хураалтын үр дүнд гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно.” гэсэн эхний өгүүлбэрийг хасаж, 9.6 дэх заалтын “намын” гэсний дараа “болон харьяа байгууллагын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.6.4 дэх заалт нэмэх:

“9.6.4.намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үг авах гэж байгаа юм уу? Зочин танилцуулъя. Зочин танилцуулъя. Парламентын номын сангийн хуралдаан Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн холбооны болон аймаг, нийслэлийн тэргүүний уншигч Даашдоржийн Нацагдоржийн тэмдэгт сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “тусгаар тогтнол,” гэсний дараа “бүрэн эрхт байдал,” гэж, 10.1.3 дахь заалтын “гүйцэлдүүлэх” гэсний дараа “үйл ажиллагаа явуулах” гэж тус тус нэмж, 10.1.3 дахь заалтын “үймээн самуун дэгдээх,” гэснийг хасаж, 10.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.4.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж, 12.2 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 12.3.5 дахь заалтын “хаягийн нотлох баримт”

гэснийг “хаягийн мэдээлэл” гэж тус тус өөрчилж, 12.3.7 дахь заалтын “намын санхүүгийн асуудал” гэсний өмнө “намын дарга,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Энэ хуулийн 12.3.6, 12.3.7, 12.3.8-д заасан мэдээллийн маягтыг Улсын дээд шүүх батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.5 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж, 13.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 13.5, 13.6 дахь хэсэг нэмэх:

“13.5.Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана.

13.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.5-д заасан нэрийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж, 14.4 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “намын бүртгэлд” гэж, 14.9 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж, “13.1, 14.1-д” гэснийг “12.1, 13.1, 14.1-д” гэж тус тус өөрчилж, 14.3 дахь хэсгийн “гэрчилгээ” гэсний дараа “, тамга тэмдгийн хяналтын дугаар” гэж, 14.6 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний

дараа “, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, “баримт бичиг” гэсний дараа “, лавлагаа,” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын гурван өдрийн дотор өргөдөл гаргагчид бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.7, 14.11 дэх хэсэг тус тус нэмэх:

“14.7.Энэ хуулийн 12.2, 12.3, 12.4, 13.7, 15.3, 21.1, 21.4-т заасан болон бусад мэдээлэл, баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийг холбогдох бусад байгууллагад хүргүүлэх журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, сонгуулийн төв байгууллагын дарга хамтран батална.

14.11.Намыг бүртгэхтэй холбоотой журмыг сонгуулийн төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн Улсын дээд шүүх батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах”

“15.4.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 15.3-т заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг

бүртгэж энэ тухай нийтэд мэдээлж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 17.2.2 дахь заалтын “жил тутам” гэснийг “жилийн хугацаанд” гэж, 17.2.2 дахь заалтын “болон” гэснийг “бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах” гэж тус тус өөрчилж, 17.3 дахь хэсгийн “Намын дүрэмд заасан тохиолдолд” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.4.Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг тус тус нэмэх:

“19.4.Нам бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгон шалгаруулах хороотой байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Энэ хуулийн 19.4-т заасан хороо нь нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-д заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” Санал гаргасан ажлын хэсэг санал. Хураалтыг цуцаллаа.

МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын хэсгийн ахлагч үг авъя. Үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Би чиглэл авах гэж байгаа юм. Энэ 16 дахь санал буюу 19-ийн дүгээр зүйлийн 19.4, 19.5, 19.6 дахь томъёоллыг түрүүн Энхбаяр гишүүн бас тодорхой саналууд хэлсэн. Тэгээд сая бид нар энэ завсарлагааны хугацаанд ажлын дэд хэсгийнхэнтэйгээ ярилцаж байгаад энэ 16 дахь санал дээр дахин боловсруулах чиглэл аваад засаж бас сайжруулах шаардлага байгаа учраас би дахин боловсруулах чиглэл өгөөч гэж хэлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Тогтохсүрэн гишүүний саналыг үндэслээд санал хураалтын 16 буюу төслийн 19 дүгээр зүйлд оруулсан энэ нэмэлт, өөрчлөлт дээр гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ янзалж орж ирье. Энэ бол санал хураалт явагдахгүй. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

17.Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 58,1 хувийн хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана:

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.6 дахь хэсэг нэмэх:

“21.6.Энэ зүйлд заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,1 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсний дараа “сонгуулийн төв байгууллага” гэж нэмж, 22.2 дахь хэсгийг 22.2, 22.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 23.1, 24.1-д заасан шийдвэрийг хүлээн авснаас, эсхүл 25.3-т заасан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн намыг бүртгэлээс хасаж гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоно.

22.3.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгасан тухай шийдвэр, шаардлагатай бусад мэдээллийг сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдэд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62,8 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,9 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллагад” гэснийг “Улсын дээд шүүхэд” гэж өөрчилж, 24.2 дахь хэсгийг 24.2, 24.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.2.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу шийдвэр гарсан бол татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

24.3.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 24.2-т заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийг иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж өөрчилж, 25.3 дахь хэсгийн “шийдвэр гаргаж,” гэсний дараа “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэж нэмж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай үндэслэл бүхий санал гаргаж, холбогдох нотлох баримт, хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “энэ хуулийн 36.3-т заасан” гэснийг “энэ хуулиар зөвшөөрсөн” гэж, 26.4 дэх хэсгийн “үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар” гэснийг “үйл ажиллагаанд” гэж, 26.8 дахь хэсгийн “цахим мөнгөн хэрэгсэл /крипто валют, NFT зэрэг/-ээр” гэснийг “цахим мөнгөөр” гэж тус тус өөрчилж, 26.6 дахь хэсгийн “зарцуулсан бол” гэснийг

дараа “сонгуулийн төв байгууллага” гэж, 26.7 дахь хэсгийн “хүлээн авах бөгөөд өөр” гэсний дараа “харилцах” гэж тус тус нэмж, 26.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “0.5 хувиар” гэснийг “0.7 хувиар” гэж, 27.3 дахь хэсэг, 27.6.1 дэх заалтын “2-оос” гэснийг “нэг ба түүнээс” гэж, 27.6.5 дахь заалтын “50 дахин” гэснийг “25 дахин” гэж, 27.9 дэх хэсгийн “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчилж, 27.11 дэх хэсгийн “Нам тарах,” гэснийг болон мөн зүйлийн 27.8 дахь хэсгийг хасаж, доор дурдсан агуулгатай 27.10, 27.12, 27.13 дахь хэсэг нэмэх:

“27.10.Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (C1 x T1) хэсгийг эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, төрийн санхүүжилтийн (C2 x T2) хэсгийг тухайн суудалд сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намд олгоно.

27.12.Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлууна.

27.13.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,9 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 28.1-д заасан” гэснийг “Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ” гэж, “30 хоногийн” гэснийг “долоо хоногийн” гэж, 28.2 дахь хэсгийн “гаргасан” гэснийг “баталсан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “2 удаа” гэснийг, 29.5 дахь хэсгийн “суурь” гэснийг, 29.10 дахь хэсгийн “давж” гэснийг тус тус хасаж, 29.4 дэх хэсгийн “нягтлан шалгах ажиллагаа явуулж буй бол уул ажиллагаа дууссаны дараа” гэснийг “хянасны дараа” гэж, 29.5 дахь хэсгийн “төрийн санхүүжилт авах намын эрх үүссэн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөс” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилээс” гэж, 29.6 дахь хэсгийн “энэ хуулийн 27.5-д заасны дагуу тухайн намын авсан хүчинтэй саналын тоо (C1)-нд суурилсан төрийн санхүүжилтийн хэсгийг” гэснийг “энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (C1 x T1) хэсгийг дараагийн жилд” гэж, 29.7 дахь хэсгийн “Тайлангийн агуулга алдаа, зөрчилтэй эсэхээс үл хамааран тайлангаа” гэснийг “Санхүүгийн тайлангаа” гэж, “тэмдэглэлийн” гэснийг “дүгнэлтийн” гэж, 29.9 дэх хэсгийн “нийтлэгдсэн” гэснийг “тусгасан” гэж, “36.3.1-36.3.3-д” гэснийг “36.3.1-36.3.4-т” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах 31 дүгээр зүйл. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хяналт тавих, тавих хяналт. 31.1, Тийм байна.

28 дугаар саналыг танилцуулъя. Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “1 хувиас доошгүй” гэснийг “нэг ба түүнээс дээш хувийн” гэж, 30.1.1 дэх заалтын “зохион байгуулахад” гэснийг “зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор” гэж, 30.1.2 дахь заалтын “телевизээр жилд” гэснийг “телевизээс гаргасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,8 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Хэн үг хэлэх юм бэ? Өнөрболор гишүүн үг хэлье. Өнөрболор гишүүний микрофоныг өгөөрэй.

Д.Өнөрболор: Төрөөс улс төрийн намыг санхүүжүүлэхээр орж ирж байгаа. Тэгээд энэ 126 гишүүнээр тооцсон зардлын тооцоолол ер нь одоо яг байна уу? Ер нь хэдий хэмжээний хөрөнгө зарцуулахаар байгаа вэ?

Нөгөө нэг асуулт нь мөнгөний сонгуулийг юуг ер нь яг ямар, ямар зүйл, заалтаар ер нь ор тас халсан бэ гэдэг дээр бол хоёргүй утгаар эргэлзээгүй бас хариулт авъя гэж бодож байна. Энэ төслийн 29 дүгээр 29-д бол энэ төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналтыг нөгөө л нэг төрийн байгууллагуудын хяналт чиг үүргийг хуваарилаад тэгээд өгсөн ийм л яг энэ хуваарилалтын дагуу зохицуулж байгаа ийм зохицуулалт л орж ирж байна гэж харагдаж байна л даа. Тэгээд нам, эвслийн энэ сонгуулийн болон энэ

сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ер нь нээлттэй болгох нь маш ач холбогдолтой. Миний бие бол бас намын удирдлагад бас удирдах албан тушаалын бүрэлдэхүүнд бас ажиллаж байсан ийм туршилагатай. Тэгээд нам үйл ажиллагаа явуулахад бол энэ санхүүгийн хүндрэл бэрхшээл гардаг гэдэгт гэдэгт бол үнэхээр ойлгож байгаа.

Гэхдээ өнөөдөр энэ Монголын энэ намууд энэ улс төрийн намын санхүүжилтийн зарчмыг ил тод шилэн байлгаж, энэ ард түмний оюун санаанд нээлттэй хяналттай байлгаж байна гэмээ чинь л энэ ард түмний итгэл итгэлцэл төр хоёрын хоорондын итгэлцэл бол ойртох ийм нөхцөл бүрдэнэ. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ яг энэ мөрдлөг яг энэ зарчим тийм ээ өнөөдөр хангагдаагүйгээс л болоод өнөөдөр Монголын төрийн бүх уналт үүнээс бол үүдэлтэй. Тэгээд ер нь бол МАН бол яг энэ асуудал дээр энэ эгзэгтэй цаг үед бол манлайллаа үзүүлэх бол нэн шаардлагатай.

Ер нь ард иргэдийн энэ төрд итгэх итгэлийг бас ойртуулах яг энэ хэм хэмжээг бас тийм ээ зөв ойлгомжтой болгож ард иргэдийн хүлээлтэд зөв хариу арга хэмжээ авах нь бол маш чухал асуудал байж байгаа. Яагаад? Яагаад гэхээр энэ улс төрийн нам санхүүгийн ил тод хариуцлагагүйн нэг гол илэрхийлэл бол энэ нүүрсний хулгай, Хөгжлийн банк, тэгээд л энэ тусгай сангуудын асуудал байж байгаа. Энэ мерит зарчмаар дэвшдэггүй тийм ээ мөнгөөр албан тушаал худалдан авдаг энэ төрд үүрлэхийн нээлттэй зам болж байгаа юм. Улс төрийн санхүүг одоо энэ намуудын санхүү нээлттэй ил тод болоогүйн шан харамж нь улс орны ядуурал, энэ авлига хээл хахууль үнэ цэнгүй улс төрч, хүндлэгдээгүй төр, энэ ёс зүйн шалан дээр унасан уналтын нэг хэсэг болж байгаа юм.

Улс төрийн нам ер нь эрүүл санхүүжилт энэ санхүүгийн нээлттэй,

хариуцлагатай байх, байхгүй байгаа энэ тохиолдолд ер нь улс оронд ямар ч утгаараа энэ идеал итгэл үнэмшлийн үрийг бол бид нар бол тарьж чадахгүй. Тийм учраас энэ улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангах явдал бол ард иргэд төрийн төрд итгэх итгэлийг бол сэргээх нэг гол алхмуудын нэг хэсэг болж байгаа. Тийм учраас үүнтэй холбоотойгоор бас яг энэ 2 асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энэ бол зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж байгаа. Ийм болохоор Хуралдааны дэгийн тухай хуулиараа асуулт асуухгүй. Зөвхөн дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болдог дэгтэй. Тийм болохоор асуултад хариулах боломжгүй байна. Санал хураалтыг саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүдээ, 55,8 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “намын дансаар” гэснийг “зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд” гэж, “тооцооны” гэснийг “харилцах” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийн “үнэлэн бүртгэж” гэснийг болон 33.5 дахь хэсэг, мөн зүйлийн 33.13 дахь хэсгийн “байгууллагад өгөх” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,8 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 х Т1) хэсгийг дараагийн жилд” гэж өөрчилж, 34.6.5 дахь заалтын “, бусад удирдах албан тушаалтан” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.5.6 дахь заалт, 34.12, 34.13 дахь хэсэг тус тус нэмэх:

“34.5.6.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай

хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Энэ саналын томъёоллыг гүйцээн боловсруулахаар авчихмаар байна. Ажлын хэсэг дээр яригдсан асуудлын зарим нь хасагдаагүй үлдчихсэн юм билээ. Тэр бусад албан хаагчид гэж хасъя гэж байгаагийн өмнө удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал гэсэн үг байгаа юм. Тэрийг авах ёстой үг байгаа юм. Тийм учраас гүйцээн боловсруулах чиглэлээр авчихмаар байна энэ юуг.

Л.Мөнхбаатар: Хуралдааныг шуурхай явуулна хэдүүлээ. Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан саналаар, ажлын хэсгийн гишүүн байгаа шүү дээ Батжаргал гишүүн тийм ээ. Ажлын хэсгийн гишүүн энэ саналыг гаргаж байгаа учраас 31 дэх санал хураалт буюу төслийн 34 дүгээр зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

32.Төслийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “заасан худалдан борлуулах” гэснийг “заасны дагуу захиран зарцуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “хөрөнгийн баланс” гэснийг “хөрөнгийн бүртгэл” гэж, 36.3.7 дахь

заалтын “арга хэмжээ зохион байгуулах, ном болон нийтлэл хэвлэн борлуулах үйл ажиллагаанаас” гэснийг “намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар” гэж, 36.14 дэх хэсгийн “бодлогын судалгааны байгууллага зэрэг түүний дэргэдэх, харьяа байгууллагын санхүүгийн тайланг” гэснийг “намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг” гэж тус тус өөрчилж, 36.3.5, 36.3.6, 36.4.9 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 36.5, 36.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Хөрөнгөд дараах зүйлийг бүртгэнэ:

- 36.5.1.барилга;
- 36.5.2.эзэмшлийн газар;
- 36.5.3.ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл;
- 36.5.4.бэлэн мөнгөний үлдэгдэл;
- 36.5.5.хуримтлал;
- 36.5.6.бусад хөрөнгө.

36.6.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран энэ хуульд нийцүүлэн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “тайлангаа нэгдсэн байдлаар” гэснийг “нэгтгэсэн тайланг” гэж, 37.6 дахь хэсгийн “бүртгэл болон санхүүгийн” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр, 37.4.1 дэх заалтын “намын гишүүний тоо.” гэснийг, 37.7 дахь хэсгийн “, эсхүл төлөөллийн төв байгууллагагүй бол удирдах дээд байгууллагаас” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “Тайланг аудитын байгууллагаар” гэснийг “Санхүүгийн тайланг” гэж, 38.2, 38.9 дэх хэсгийн “Аудитор” гэснийг “Аудитын хуулийн этгээд” гэж, 38.2 дахь хэсгийн “баримт материалтай” гэснийг “баримт бичигтэй” гэж, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “аудиторын” гэснийг “аудитын” гэж, 38.5 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг “этгээд” гэж, 38.9 дэх хэсгийн “тайланг гаргахад хэрэглэсэн баримт бичиг, нягтлан бодох бүртгэл,” гэснийг “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт,” гэж, 38.10 дахь хэсгийн “баталгаа гарахад хангалттай” гэснийг “баталгаа гаргана” гэж, 38.14 дэх хэсгийн “Шалгалтын тэмдэглэлийг” гэснийг “Аудитын дүгнэлтийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.6, 38.8, 38.13 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.7, 38.12 дахь хэсгийг 38.1, 38.5, 38.9 дэх хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.5.Энэ хуулийн 38.1-д заасан аудитын хяналтыг хийхдээ намын санхүүгийн тайлан болон аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн эрсдэлд үндэслэн орон нутгийн салбар нэгж байгууллагын таваас доошгүй хувийг түүвэрт хамруулна.

38.9.Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг нягтлан бодох

бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох олон улсын стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт, тайлан гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тийм улс төрийн намын санхүүжилт бол нэлээн хяналттай болж байгаа нь болсон зохицуулалтууд байна. 56,1 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

37.Төслийн 39 дүгээр зүйлийн гарчгийн “тайланг нягтлан шалгах” гэснийг “тайлангийн хяналт” гэж, 39.1 дэх хэсгийн “хэлбэр болон агуулгын хувьд зөв, бодитой эсэх, энэ хуулийн Тавдугаар бүлэгт” гэснийг “энэ хуульд” гэж, “нягтлан шалгах” гэснийг “хянах” гэж, 39.2 дахь хэсгийн “ажлын 15-аас доошгүй хоногийн” гэснийг “ажлын таваас доошгүй өдрийн” гэж, 39.3 дахь хэсгийн “хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн” гэснийг “хүлээн авч хянаад 4 дүгээр сарын 05-ны” гэж, 39.4 дэх хэсгийн “Нягтлан шалгах ажиллагаа” гэснийг “Хяналтын ажиллагаа” гэж, 39.5 дахь хэсгийн “тухайн алдаа, зөрчлийг арилгаж сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу” гэснийг “аудитын хуулийн этгээдийн тогтоосон хугацаанд тухайн алдаа, зөрчлийг арилгаж,” гэж, 39.7 дахь хэсгийн “Тайланг нягтлан шалгах ажиллагааны” гэснийг “Санхүүгийн тайланг хянах” гэж тус тус өөрчилж, 39.4.3, 39.4.4, 39.6 дахь хэсгийг болон мөн зүйлийн 39.7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 39 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 39.5 дахь хэсэг нэмэх:

“39.5.Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “мэдүүлэх” гэснийг “мэдэгдэх” гэж, 40.2 дахь хэсгийн “нягтлан шалгах ажиллагааны явцад” гэснийг “хянах явцад” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 41 дүгээр зүйлийн гарчгийн “Төрөөс олгосон санхүүжилтийг буцааж төлөх” гэснийг “Аудитын дүгнэлтээр тогтоосон алдаа, зөрчлийн үр дагавар” гэж өөрчилж, 41.2, 41.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн (С1 х Т1) хэсгийг дараагийн жилд олгохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг тус тус хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3, 34.5.4-д заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандивыг гурав дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. ХЗБХ-ны дарга Баттөмөрийн Энхбаяр үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ нэг ийм үг ерөөсөө уншигдахгүй байна. Энэ найруулгаар янзлах юм уу эсвэл яамаар юм. Сонгуулийн

төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандив гэдэг үг уншигдаад байна. Тэгэхээр сонгуулийн төв байгууллага нь тухайн намыг хууль бусаар хандив авах шийдвэрийг нь гаргачихсан юм шиг ийм утга логик уншигдаад байна. Хэл зүйн хувьд. Уг нь бол санаа нь бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр сонгуулийн төв байгууллагад төлнө гэдэг холбоосоор бичсэн юм шиг байна. Уг нь өгүүлбэр.

Тэгэхээр энийг найруулгын хувьд нам хандивыг шилжүүлээгүй бол, шилжүүлээгүй бол хууль бусаар авсан хандив хууль бусаар авсан хандив юм уу, хууль зөрчиж авсан хандив юм уу, хууль зөрчигдөж авсан хандив юм уу? Нам бол хууль бусаар аваагүй байгаад байгаа шүү дээ. Тэр хандив өгч байгаа иргэн чинь л хамгийн гол нь хууль юу яачхаад байгаа байхгүй юу. Өгч байгаа хандивыг нь хэмжээнээс нь илүү өгчихсөн, өгөх ёсгүй гадаадын хүн өгчихсөн. Тэрийг чинь нам чинь өөрөө дансанд нь орж ирж байгаа мөнгө нь гадаадын иргэн үү, Монголын иргэн үү гэдгийг чинь нам чинь мэдэхгүй шүү дээ. Тэгэхээр нам хууль бусаар аваагүй байхгүй юу, намд хууль бусаар өгчихсөн байхгүй юу. Ер нь бол санаа нь.

2 дугаарт сонгуулийн төв байгууллагын шийдвэрээр тухайн нам хууль бусаар авсан хандив гэж уншигдаад байна. Тэгэхээр энэ найруулгын хувьд болж л өгөхгүй байна даа. Энийг найруулахгүй бол.

Л.Мөнхбаатар: Энэ Баттөмөрийн Энхбаяр гишүүний хэлж байгаа зүйл бол үндэслэлтэй байна. Тэгэхгүй бол хууль бусаар, нам хууль бусаар авсан гээд байгаа гэхдээ агуулгыг бол илэрхийлэхгүй байна шүү дээ тийм ээ. Тийм учраас төслийн 41 дүгээр санал хураалт буюу төслийн 42 дугаар зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Эцсийн найруулга дээр, эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хороогоор дахин хэлэлцэж орж ирье.

42.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “5 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2.2 дахь заалтын “болон тарсан” гэснийг хасаж, мөн зүйлийг 7 дугаар зүйлд нэгтгэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгынх нь санал байна.

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын “нийгмийн” гэсний дараа “сонирхлын” гэж тус тус, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “албан тушаалтны зүгээс” гэсний дараа “заналхийлэх,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.6 дахь хэсгийн “тайланг” гэсний өмнө “санхүүгийн” гэж, 29.9 дэх хэсгийн “тайланд” гэсний өмнө “санхүүгийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал уналаа. ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд горимын гаргая. Танай Байнгын хорооны оруулсан асуудал байна даа.

Н.Энхболд: Сая Байнгын хорооны санал дээр өгсөн чинь энэ аппарат буруу ажиллачих шиг боллоо даргаа, та хүчингүй, энэ чинь би өөрөө гаргасан саналаа унагаана гэж байхгүй л дээ. Тийм. Хүчингүй болгоод дахиад санал хурааж өгөөч.

Л.Мөнхбаатар: Аппарат бол буруу гаргана гэж бас байхгүй байх. Тийм ухаалаг байна гэж байхгүй байх. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1-ийн, горим дэмжигдсэн. Одоо үндсэн санал хураалтаа явуулъя. Саналын

томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “төрийн санхүүжилт авах эрх үүсэх жил” гэснийг “төрийн санхүүжилтийн эрх үүсэх жил” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “мөшгөн хавчих” гэснийг “мөрдөн мөшгөх” гэж, 5.6 дахь хэсгийн “бичиг баримтад” гэснийг “баримт бичигт” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “хуульд тогтоомжид” гэснийг “хууль тогтоомжид” гэж, “хуульд тогтоомжид” гэснийг “хууль тогтоомжид” гэж гэдэг нь ямар агуулгатай юм бол. Хуульд гэсэн юм байна. “хуульд тогтоомжид” гэснийг “хууль тогтоомжид” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “байдлын” гэснийг “байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн “хийж” гэснийг “хийлгээж” гэж, 12 дугаар зүйлийн 12.3.8 дахь заалтын “хөрөнгийн мэдээ” гэснийг “хөрөнгийн мэдээлэл” гэж, 12.4 дэх хэсгийн “хөрөнгийн мэдээнд” гэснийг “хөрөнгийн мэдээлэлд” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтын “гишүүнчлэлээс” гэснийг “гишүүнээс” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “10 хоногийн” гэснийг “10 өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “гишүүдийн” гэснийг “гишүүний” гэж, 25.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “Улсын дээд шүүхийн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийн “тооцон бодоход” гэснийг “тооцоолоход” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийн “баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “зорилго, бодлогыг тодорхойлсон” гэснийг дараах “үндсэн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “хэдийд ч” гэснийг дараах “намаас”

гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “нам” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтын “буюу” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.3 дахь хэсгийн “үндэсний” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,2 хувиар санал дэмжигдлээ. Найруулгын саналууд хураагдаж дууслаа.

Дагасан хуулиудаа явна. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя ТББХ-ны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “энэ хуульд нийцүүлэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү өөрчлөлтөө Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлье. Цогтгэрэл гишүүн микрофоныг.

О.Цогтгэрэл: Энэ дээр нэг үг байна. Энэ хэрэгжих хугацааг бас олон намууд санал гаргаад, яг намын дотоод дүрэм, дотоод зохион байгуулалт,

дүрэмтэй холбоотой зүйлийг сонгуулийн дараа хэрэгжүүлж эхэлье гэдэг дээр бас ажлын хэсгээс ингээд санал нэгдсэн юм. Тэгэхдээ энэ дээр нөгөө нөхцөл байдал дээр ирэх жилийн парламентын сонгуулийн дун яаж гарахаас хамаараад хэрвээ намууд магадгүй цөөн биш намууд эвсэх нэгдэх үйл ажиллагаа явагдах ийм нөхцөл байдал үүсэхийг бас таашигүй. Тэр тохиолдолд нөгөө 7 сарын 1-нээс хууль хэрэгжээд эхэлчихсэн. Зарим намууд чинь төлөөллийн төв байгууллага ч үгүй байдаг. Тэгэхээр энэ хугацаанд тийм хууль, эрх зүйн хувьд тийм хүндрэлтэй байдал бас үүсэх юм биш байгаа? Магадгүй Засгийн газрын чинь байгуулах хугацаа чинь өөрөө хуулийн хугацаатай. Тэгэхээр энийг яг энэ ажлын хэсэг энэ тэр дээрээ бид нар бас энэ үүсээж болох хүндрэлийг харгалзсан, ярьсан, харгалзсан, тооцсон зүйлүүд ер нь байгаа билүү? Энийг бас ингээд анхаарах хэрэгтэй юм болов уу. Энэ чинь хариулж болдог билүү? Болохгүй. Тэгэхээр энийг ер нь дараа ажлын хэсэг дээр бас нэлээн энийг нь уян хатан байдлаар зарим зүйлүүдийг харгалзаж үзэх шаардлагатай юм шиг санагдаж байна.

Л.Мөнхбаатар: ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд үг хэлье. Энхболд даргын микрофоныг өгөөрэй.

Н.Энхболд: Ямар ч байсан энүүгээрээ явуулчихъя. Тэгээд хэдүүлээ ярья. Тэгээд ер нь бол жишээ нь эвсэл энэ тэр болно гээд намууд сонгуулийн өмнө яривал эсхүл сонгуулийн ер нь өмнө л ярьж таарна л даа. Дараа нь бараг л хэцүү л байх. Тэгэхдээ тэрэн дотроо нөгөө бас бололцоотой хувилбаруудаа тооцсон байхаар гэрээ юмнуудаа хийсэн байх нь зүйтэй болов уу. Ямар ч байсан үргэлжлүүлээд хэдүүлээ яаж болох вэ гэдгийг нь бас нэг давхар яриад, ядаж протокол юманд тусгаад үлдээчихье.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя.

Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалт нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дунгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хэрэгжинэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Дарга энэ дээр Улсын Их Хурлын 2024 оны ээлжит гэдэг үгийг оруулмаар байна. 2024 гэдэг үг оруулмаар байгаа юм. Тэгэхгүй бол хэзээний ээлжит, ээлжит бус болчих гээд байгаа юм. Тийм учраас энийг, үгүй ээ үгүй, орхиулж яах юм бэ? Зүгээр дэмжигдчихье. Тэрийг редакцаар авах уу, найруулгаар авах уу? Ажлын хэсэг ямар ч байсан яриад, 2024 гэдэг үг оруулчихмаар байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Санал хураалт явагдах гэж байна шүү дээ. Гэхдээ энэ юу юм уу, 2024 гэж хийхээр бол энэ чинь өөрөө зарчмын шинжтэй нэг бол чиглэл авах юм уу аль эсвэл юу, яах юм уу? Тэгэхгүй бол наадуул чинь орох боломжгүй болно шүү дээ. Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэнгийн гаргасан саналаар саналын дагуу энэ 3 дахь санал буюу 3 дугаар зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Дараагийнхаа хуулийг оръё. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ. Энэ хууль, хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Их Хурлын тогтоол гарна. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Хуулийн төсөл буцаах тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Тогтоолын төсөл батлагдсанд тооцлоо.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Улс төрийн нам, шашны байгууллагыг” гэснийг “Шашны байгууллагыг” гэж, 15.2.3, 15.2.4, 15.2.5 дахь заалтын дугаарыг “15.2.1, 15.2.2, 15.2.3” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг, эсхүл мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээг зах зээлийн дундаж ханшаар үнэлсэн дүнг нэг аравны тав дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх. Үг авах юм уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ бол Зөрчлийн хуульд өөрчлөлт орж байгаа өөрчлөлт байна. Зөрчлийн хуульд ийм хууль зүйн техникт байхгүй томъёолол орж ирж байх юм. Энэ үйлчилгээг зах зээлийн дундаж ханшаар үнэлсэн дүнг 1,5 дахин үржүүлсэнтэйгээр торгоно гэж одоо ер нь ямар энэ Зөрчлийн хууль чинь агуулга нь ийм шүү дээ шууд хэрэгжинэ, хэн нэгэн энийг дунд нь тайлбарлахгүй, ихэсгэж, багасгахгүй, хэдэн нэгжээр торгоно гээд шууд хэлдэг хууль байхгүй юу техник нь. Тэгэхэд чинь энэ чинь одоо энд хөрөнгийн үнэлгээ яригдах нь байна. Нэг эмээл байна, эмээл энэ эмээл бол 1 тэрбумын эмээл л дээ. Хүннү хааны эмээл. Энэ бол Энх-Амгалан хааны хөрөг, хөөрөг. Энэ чинь бүүр Зөрчлийн хуулиасаа бүүр салаад явчихлаа. Зөрчлийн хуульд ийм шийтгэл байхгүй шүү дээ. Энэ чинь шууд хэрэгждэг улаан гэрлээр гарлаа бол тэр 50км цагийн хурдтай байна уу, 100км цагийн хурдтай байна уу тэр падгүй байдаг байхгүй юу. Шууд тас, хэдэн төгрөг. Гудамжинд хог хаялаа. Чи шилэн сав хаясан уу, том хог хаясан уу, жижиг цаас хаясан уу ер падгүй. Энийг чинь ингэж үнэлдэггүй хууль байхгүй юу. Зөрчлийн хуулийн онцлог нь тэндээ байдаг юм. Хүн тайлбарладаггүй. Шууд хэрэгждэг. Энэ чинь болохоор бүр үнэлгээ хөрөнгийн үнэлгээ болоод явчихлаа шүү дээ энэ чинь. Ингээд ихэсгэж, багасах уу болоод явчихлаа энэ. Ийм шийтгэл би Зөрчлийн хуульд мэдэхгүй байгаад байна.

Тэгэхээр энэ Зөрчлийн хуулийн шийтгэлийг энэ уг нь ХЗБХ-гоор л ордог байсан, ер нь орохоо болиод ерөөсөө ийм, ийм шийтгэлүүд. Тэгээд насанд хүрээгүй мал хурьцуулна гэдэг юм чинь ер нь энэ ХЗБХ-гоор ордоггүйгээс болоод л яригдаад байгаа шүү дээ энэ чинь. Тэгээд ийм томъёололтой хуулиуд орж ирдэг.

Л.Мөнхбаатар: Энхбаяр гишүүний гаргасан саналаар уг төслийн заалтуудыг Зөрчлийн хуулийн үзэл баримтлал болон хуулийн бичилтийн техникт нийцүүлэн дахин боловсруулъя. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Хуулийн төслийг Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. Энэ дараагийнхыг нь бол хураагаад явчхаж болох юм байна тийм ээ? Саяынхаас бусад нь болохоор юм байна. Бусад нь бол зөвхөн мөнгөн дүнгээр юм байна. Тийм ээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нэг банк дахь нэг дансаар хүлээн аваагүй бол арван мянган нэгжтэй” гэснийг “банкны нэг дансаар хүлээн аваагүй бол тухайн орлогын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн хандивын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. Засгийн газрын гишүүн Их Хурлын гишүүнээр давхар хашиж байгаа гишүүдээс бол манай Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг бол Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд бол хамгийн идэвхтэй сайн оролцож байгааг бас тэмдэглэн хэлье. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “арван мянган нэгжтэй” гэснийг “тухайн хандивын мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ.

Тав.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “энэ хуулийн 3.1.6-д заасны дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй.” Үг хэлэх юм уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ бичилтийн хувьд нэг хууль зүйн техникийн хувьд нэг буруу текстэйгээр төгсөөд байна. Харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй гэж төгсөөд байна. Хууль үйлчилнэ, үйлчлэхгүй гэдэг заалт хуульд бичигддэггүй. Хууль бол ерөөсөө л үйлчилнэ. Хууль ийм харилцааг зохицуулна, зохицуулахгүй гэж бичигддэг байхгүй юу. Аягүй бол 1/3 нь энэ харилцааг зохицуулна гэсэн нэг ийм заалт л байгаа байх гэж би бодож байна. Томьёололтой. Тэгвэл энэ 2/3 нь холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэж төгсөх ёстой. Энэ хуулиар зохицуулахгүй гэж. Тэрнээс биш энэ хууль үйлчлэхгүй гэдэг ийм хууль зүйн техник байхгүй. Хууль бол ерөөсөө л үйлчилнэ, бүх хууль үйлчилнэ, бүх хууль үйлчилнэ. Энэ хууль нь үйлчилдэг хууль, энэ хууль нь үйлчилдэггүй хууль гэсэн ойлголт байхгүй. Тэгэхээр энэ яах вэ энийг?

Л.Мөнхбаатар: Ингэе наадах чинь бол бас үндэслэлтэй байна. Үйлчлэхгүй гэдэгт томьёолол бол хэрэглэдэггүй байгаа. Тийм учраас нэг бол зохицуулахгүй гэж томьёолно, үгүй бол энэ зүйл хамаарахгүй гэдэг бас үгээр хамаарахгүй гэдэг үгээр томьёолж болно. Ийм учраас энэ ТББХ-ны энэ дэмжсэн энэ санал буюу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд оруулж байгаа энэ нэмэлтийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Хуульд нийцүүлэх гэсэн нэр томьёонд оновчтой нэр томьёолох гэсэн ийм чиглэлээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд

доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй.

“85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Чиглэл авах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: 85.6 дахь заалттай холбогдуулаад энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэх гэж байгаа юм. Энийг нөгөө ярилцсанаас хойш бид нар нөгөө холбогдох байгууллагатай нь бас ярьж, томьёоллыг өөрчлөх ийм шаардлага үүсээд байгаа юм. Тийм учраас би энэ зүйл, заалтыг таныг гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энэ ТББХ-ны дэмжсэн санал дээр 85.6 дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

2.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

25.8.8.Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах, идэвхгүй болон идэвхтэйд тооцох, татан буулгах, тамга тэмдгийн хяналтын, регистрийн, хувийн хэргийн дугаар, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, эдгээртэй холбогдсон бүртгэл болон намын нэрийн сан хөтлөх, лавлагаа олгох;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг

танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Хороо улс төрийн намын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.6.1.Улс төрийн намын тухай хуулийн 9.10-т заасан мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлэх;

7.6.2.төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах маягтыг батлах;

7.6.3.намд өгөх хандивын бүртгэлийг хөтлөх маягтыг батлах;

7.6.4.хуульд заасан үндэслэл журмын дагуу намыг тараах тухай санал гаргах;

7.6.5.намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож, төсөвт суулган олгох;

7.6.6.намд төрөөс үзүүлэх хууль бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх; гэнэ үү. намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг олгох, шийдвэрлэх;

7.6.7.Улс төрийн намын тухай хуулийн 8.9, 10.3-т заасны дагуу хяналт хэрэгжүүлэх;

7.6.8.Улс төрийн намын тухай хуулийн 26.6-д заасны дагуу шийдвэр гаргах;

7.6.9.улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт тавих;

7.6.10.Улс төрийн намын тухай хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдээ санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ажлын албанд” гэснийг “Тамгын газарт” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “ажлын алба” гэснийг “Тамгын газар” гэж, 15.1 дэх хэсгийн “ажлын албатай” гэснийг “Тамгын газартай” гэж, мөн хэсгийн “Хороо батална.” гэснийг “Хороо батална. Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно.” гэж, 15.2 дахь хэсгийн “ажлын албаны” гэснийг “Тамгын газрын” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ-ны дэмжсэн санал байна.

1.Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн “нарийвчилсан журам, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/,” гэснийг “журам батлах, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын дээд шүүх /Д.Ганзориг/,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Үг авах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ тогтоолын төсөл дээр энэ Ерөнхий сайдад даалгасан заалтыг өөрчилж, Дээд шүүхэд чиглэл өгөхтэй холбоотой асуудал байгаа юм. Тэгээд энэ дээр бас найруулгын редакцын хувьд нэлээн харж үзмээр юмнууд гараад байгаа учраас таныг энэ 1 дүгээр заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Тэгье. Засгийн газар байсныгаа Дээд шүүх болгож байгаа юм байна шүү дээ тийм ээ? Тийм учраас найруулгын хувьд дахин авч үзэх шаардлага байгаа юм байна. Ийм учраас тогтоолын төслийн нэг дэх хэсэг дэх хэсэг дээр гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

2.Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ тогтоолыг Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,4 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

16.08 цаг

Зургаа.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд орёе. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна. Энэ нэлээн олон санал хураалттай байгаа шүү. Гишүүд суугаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт шилжүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулж, гишүүдэд Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс төслийн зарим нэр томъёо, зарчим, нислэгийн үйл ажиллагааны төрөл, ерөнхий зохицуулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлөг өмчлөх эзэмшигч, хариуцагч уг үйл ажиллагааны хуваарилалт, иргэний нисэхийн дүрэм болон иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад тавигдах шаардлага зэрэг асуудлыг олон улсын гэрээ, конвенцын стандарт, шаардлагад болон олон улсын холбогдох хуулиудад нийцүүлж өөрчлөн найруулах санал бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдэд гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн иргэний агаарын хөлгийн баг, багийн бүрэлдэхүүн, нислэгтэй холбогдох үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг төсөлд нэмж тусган ОУНБ дахь нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээг Иргэний нисэхийн дүрмийн

дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд ажлын хэсгээс бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд сумдад нислэг үйлдэх боломжийг хангасан зохицуулалтыг тусгах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төсөлд тусгасан нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авах болон агаарын хөлгийг албадан саатуулахад эзсвэг хэрэглэхийг хориглоно гэсэн заалтуудыг хэрхэн өөрчлөн найруулсан талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн, зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүрээр санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэхийг, өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы

нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Доржийн Эрдэнэбат, ИНЕГ-ын дарга Чимэддоржийн Мөнхтуяа, ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга Пүрэвжавын Ганболд, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Нямсамбуугийн Батсайхан, Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер Зинамидарын Туяа нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Энэ их чухал зүйл ярьж байгаа. Тэгээд энэ дээр би хоёрхон зүйлийг бас тодруулж асуух гэсэн юм. Тэгэхээр энэ 13 дугаар зүйл дээр иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт гэсэн зүйл байгаа. Үүн дээр бүүр яг бодитойгоор үйл ажиллагааг илүү эдийн засагжуулах зорилгоор нэг үйл ажиллагаа эхлэх, эдийн засгийн зөвшөөрөл олгох, үнэ тарифыг хянах энэ тэр гэсэн ийм заалтууд оруулах шаардлагатай л гэж би бодоод байгаа юм. Энэ дээр Бат-Эрдэнэ гишүүн та нэг хариу өгөхгүй юү? Энэ илүү оновчтой, илүү эдийн засагжуулах тал дээр энэ заалтууд нэмбэл яах бол? Энэ дээр таны бодлыг сонсьё.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ хариулъя. Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ийм заалт шинээр орж ирж байгаа. Ер нь бол яах вэ иргэний нисэхийн үйл ажиллагааг конвенцынх нь дагуу олон улсын дүрмийнх нь дагуу бид нар бас нэг загвар дотор оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл олон улсад

зөвшөөрөгдөх хэмжээнд манай Иргэний нисэхийн тухай хууль маань өөрчлөгдөх, шинэчлэгдэх, тэр хэмжээндээ бол үнэлэгдэх, олон улсын дүрэм журам конвенцынхаа дагуу бол үйл ажиллагаа нь явуулж, нэгдсэн нэг алхам, нэг чиглэлд хамт явах гэсэн утгаараа орж ирж байгаа. Эдийн засгийн чиглэл талаасаа бол ер нь эдийн засагжуулах гэх нь бид ерөнхийдөө бол заагаад өгчхөж байгаа юм. Ер нь бол жишиг олон улсын ИСОА-гаас бол гаргаж ирсэн жишиг дүрэм юу байгаа, хуулийн жишиг гэрээ хууль байгаа. Тэр жишиг хуулийн дагуу бол эдийн засагжуулах гэсэн утгаар орж ирж байгаа.

Энэ нь бол бүүр эдийн засгийг бол сайжруулах энэ тэрээ гэж тэр эдийн засаг талаасаа айхтар харахаас гэхээсээ илүү ер нь бол энэ өөрөө commercial энэ эдийн засаг руугаа орсон ийм үйлчилгээ юм гэдгийг л тодорхойлж өгч байгаа юм. Энэ дотор бол зорчигч тээврийн асуудлууд орж ирж байна. Ачаа болон шуудан тээврийн асуудлууд орж ирж байна. Ерөнхий нислэгийн өөрөөр хэлбэл хувийн нислэгүүд өөрсдөө тодорхой хэмжээний эдийн засгийн төлбөртэй үйлчилгээ явуулах ийм боломж бололцоог нь нээж өгч байгаа. Энэ утгаараа бол эдийн засгийн гэсэн утгаар бол орж ирж байна.

Дээрээс нь тэр газрын юуны үйлчилгээнүүд нисэхийн аль ч ямар нэгэн зураг авах ч байдаг юм уу, хор цацах ч байдаг юм уу, энэ үйлчилгээнүүд нь бол тодорхой хэмжээний эдийн засгийн хүрээнд бас төлбөртэй явагдах боломж бололцоог нь нээж өгч байгаа. Ер нь бол либералчлах тал руу нь оруулж байгаа учир эдийн засагт тодорхой хэмжээний төлбөртэй байх, эдийн засаг нь нээлттэй байх боломж бололцоо нь аливаа эдийн засагтай харьцаанд орох ийм боломж бололцоог нь л энд иргэний нисэхийг өргөн хүрээнд нээж байна гэдэг утгаараа л энэ заалт маань бол орж ирж байгаа юм. Эдийн засгийн зохицуулалт гэж гэдгээрээ ингэж орж ирж байгаа юм. Түүнээс биш

ингээд ашигтай байх эд нар гээд л бүхэл бүтэн нөхцөл байдлыг нь цаашаа задлах гэхээсээ илүү хамгийн гол нь энд бид нар хууль дотор бол гол юм бол ерөөсөө аюулгүй байдлыг бол хангах талынхаа зүйл нь бол илүү түлхүү орж ирж байдаг юм л даа энэ хууль дээр.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу та? Энэ чинь угаасаа л нэг л удаа асуух байх. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Би үг хэлэх гэсэн юм. Бас энэ нэг олон улсын арга хэмжээ давхцаад байгаа учраас яг тухайн санал хураалт дээр нь бас байхгүй таарч магадгүй. Энэ их чухал заалт байгаа юм. Энэ хамгийн сүүлд төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг хасах гэдэг заалт байгаа. Энэ заалт бол нөгөө Байнгын хороон дээр санамсаргүй зүгээр ер нь уначихсан. Тийм учраас энэ заалтыг бид нар босгож ирэх ёстой юм. Яагаад гэхээр энийг хасах ёстой юм. Өөрөөр хэлбэл энэ бид нар энэ заалтыг улсын төсөвт энэ навигацийн үйлчилгээний орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ гээд шууд энэ хуульд заачих юм бол энэ Чикагогийн конвенцыг зөрчих гээд байгаа.

Чикагогийн конвенц зөрчихөөр яах вэ гэхээр яг энэ хуулийг олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хараад л аудитын шалгалт хийхэд л энэ бол ерөөсөө үл тохирол болох ийм ноцтой асуудал үүснэ. Мэдээж бол өмнө нь бусад төсөв санхүүгийнхээ тийм бусад төсөв санхүүгийнхээ үйл ажиллагаагаар энийг тодорхой зүйлийг Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд ингээд төвлөрүүлээд явах боломжтой юм байна лээ. Гагцхүү энэ хуульд ингэж бичих нь өөрөө энэ олон улсын конвенц зөрчих ийм зүйл байгаа юм шүү. Тэгэхээр би гишүүддээ юу гэж хүсэж байгаа гэхээр энэ төгсгөлд нь Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал гэдгийг кноподоо хүрэхгүй байж байгаад энэ саналыг босгоорой гэдгийг л хүсэх гээд байгаа юм.

Энэ олон улсын конвенцоо бид нар зөрчиж болохгүй. Тийм.

Тэгэхээр ажлын хэсгийн дарга нь өөрөө энийгээ дэмжээд оруулсан. Ямар ч зөрчилгүй ийм санал байгаа юм. Тэгэхгүй бол бид нарыг энэ орлогоо та нар аюулгүй байдалдаа зарцуулахгүй байна гээд нэлээн асуудалд орох магадлалтай. Энэ хуулийн гол амин сүнс нь бол энэ байгаа юм шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Зарчмын зөрүүтэй санал хураахад ажлын хэсгийн ахлагч бас тухайн үед сануулаарай тийм ээ. Энэ асуудлыг хэлэлцүүлгийн явцад анхааръя. Одонтуяа дарга бас тийм. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. 40 санал байна. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.1. “Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баттөмөр, Ганибал, Оюунчимэг, Энхбаяр цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. Баттөмөрийн Энхбаяр гишүүн горимын санал гаргая. Энхбаяр.

Б.Энхбаяр: Миний тоног төхөөрөмж сая техникийн саатал гараад, санал эсрэгээр гарчихлаа. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүйд тооцох горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаярын гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал

хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт. 53,7 хувиар санал дэмжигдлээ. 2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, сая хүчингүйд тооцсон учраас үндсэн санал хураалтыг явуулна. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. 51,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.5. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах төхөөрөмжийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.8. “аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тоногдсон газар, талбай, усан гадаргууг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.14. “нисэхийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах нисэхийн бусад үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хадгалах тогтолцоог;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.17. “иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж иргэний агаарын хөлгөөр

үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбоотой цогц ажиллагааг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.12 дахь заалтын “болон түүнд хамаарах бусад” гэснийг түүнд шууд дэмжлэг үзүүлэх бусад” гэж, “гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг” гэснийг “гүйцэтгэхийг” гэж, 5.1.15 дахь заалтын “хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар” гэснийг “иргэний нисэхийг” гэж, 5.1.16 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 59 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “шаардлагатай гэж үзвэл гадаад улсын” гэснийг хасаж, “тухайн” гэснийг “гадаад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалтын “навигацийн” гэсний дараа “болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “стандарт, журмын” гэснийг “стандартын” гэж, 9.2.5 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчилж, 9.2.5 дахь заалтын “зөвшөөрөл,” гэсний дараа “агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “тухайн салбарт 15-аас доошгүй жил ажилласан” гэснийг, Монгол Улсын иргэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу” гэж өөрчилж, 10.2 дахь хэсгийн “дараах” гэсний өмнө “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна” гэж, 10.2.5 дахь заалтын “мэдээлэх” гэсний өмнө “холбогдох этгээдэд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “Конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг, 12.1.11 дэх заалтын “том, дунд, жижиг

оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Яах юм үг авах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 14 дүгээр заалт дээр аюулгүй байдалтай холбоотой нэг багахан асуудлууд хаягдсан байна лээ. Даргаа энийг гүйцээн боловсруулахаар та нэг үүрэг даалгавар өгөөд ингээд яваач л гэсэн ийм хүсэлтийг гаргаж ирж байгаа юм. Үгүй ээ ерөнхийдөө утга агуулгын хувьд жосоохон засаж оруулах асуудал болчихоод байгаа юм. Ерөнхийдөө бол бас юм нь бол орчихсон. Тэгээд жосоохон хаягдчихаад байна. Тийм, тодруулах хэрэгтэй болж байна. Та нэг гүйцээн боловсруулах юу өгөөч гэж.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнийн саналын дагуу 14 дэх санал хураалт буюу төслийн 12 дугаар зүйлийн 12 дугаар зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Томьёоллыг оновчтой болгоё гэж байгаа юм байна тийм ээ. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

15.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.19 дэх заалт, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтын “аргачлал” гэснийг хасаж, 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг эдийн засгийн зохицуулалтын дүрмээр зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Энэ хуулийн 14.1, 15.2 дахь хэсэгт хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Томилогдсон гадаадын” гэснийг “Гадаад улсын эрх бүхий байгууллагаас томилогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмэх:

“19 дүгээр зүйл.Иргэний агаарын хөлгийн баг

19.1.Иргэний агаарын хөлгийн баг нь нисгэгч болон багийн бусад гишүүдээс бүрдэнэ.

19.2.Нислэгийн үед нислэгтэй холбогдох үйл ажиллагаа явуулах нисгэгчээс бусад ажилтнууд агаарын хөлгийн багийн бусад гишүүнд хамаарна.

19.3.Монгол Улсын иргэний агаарын хөлгийн багийн бүрэлдэхүүнд гадаад улсын иргэн байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 17 дугаар зүйл болгох.

“17 дугаар зүйл.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа

17.1.Ерөнхий зориулалтын нислэгт хувийн болон чөлөөт, хөнгөн, хэт хөнгөн, хүнгүй агаарын хөлгөөр гүйцэтгэх, хэт

хөнгөн агаарын хөлгөөр гүйцэтгэх сонирхогчийн нислэг болон тэдгээрт хамаарах бусад нислэг багтана.

17.2.Ерөнхий зориулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч хариуцна.

17.3.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

17.4.Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсгийн “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, 22.1.7 дахь заалтын “агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисгэх багийн” гэснийг “нисгэгчийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Чикагогийн конвенцын 25 дугаар зүйлийн дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар хэсэг нэмэх.

“Тайлбар: Энэ зүйлд заасан “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуулийн 4.1.1-д заасныг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “стандарт, журмын”

гэснийг, “стандартын” гэж өөрчилж, 27.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.3.Конвенцын хавсралтад заасан стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглан хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,1 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “төрийн өмчит” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмэх:

“33.3.Олон улсын нисэх буудал дахь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Аубакир гишүүн асуултаа асууя. Үг хэлье. Тийм зарчмын зөрүүтэй санал учраас үг хэлнэ.

Т.Аубакир: Энэ ОУНБ дахь нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ гэж байгааг энэ нөгөө АБХА гэж ойлгож болох уу, мөн үү? Энэ тэгээд өмнө нь төрийн өмчид байж байгаад, энэ төрийн өмчит хуулийн этгээд гээд орж ирэхээрээ яг ялгаа нь юу юм бол 1 дүгээрт?

2 дугаарт ОУНБ-д дахь аюулгүй хамгаалалт гэж байгаа юм. Тэгээд орон нутгийн чанартай аэропортуудынхаа хамгаалалтыг нь ямар хуулийн этгээд хамгаалах вэ? Нэг тийм зөвхөн олон улсын юм шиг болоод явчихсан байх юм. Өмнө нь бол АБХА бол бас төрийн өмчит олон улсын гэрээ конвенцоор зохицуулагддаг л байгууллага байсан юм шүү дээ. Тэр олон улсын гэрээ конвенц чинь хэвээрээ юм байгаа биз дээ.

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Дэгээрэй дэмжсэн, дэмжээгүйг үг хэлэх боломжтой байгаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүдээ. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “аэродромд нисгэх” гэснийг “аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн” гэж өөрчилж, 34.1.2 дахь заалтын “өндөржүүлсэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “хяналтын” гэснийг “хяналт тавих мэргэжлийн” гэж, “7-гоос” гэснийг “таваас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “анхан шатны мэдээллийг нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх, дэлгэрэнгүй мэдээллийг” гэснийг “анхан шатны болон дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний өмнө “өмчлөгч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “шалгагч шинжлэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“51.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3 дахь заалтын “, эсхүл” гэснийг “болон” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “төрийн бодлого” гэснийг “талаар төрөөс баримтлах бодлого” гэж, 8.1.9, 8.1.10 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Конвенц, түүний” гэснийг “Конвенцын” гэж, 9.2.2 дахь заалтын “тохирогч” гэснийг “тохиролцогч” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсгийн “нөлөөлөхүйц” гэснийг “нөлөөлж болзошгүй” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “үзлэг” гэснийг “хяналт” гэж, “иргэний нисэхийн мэргэжсэн” гэснийг “нисэхийн гэрчилгээжсэн” гэж, 11.3 дахь хэсгийн “шилжүүлэн гүйцэтгүүлэх” гэснийг “шилжүүлэх” гэж, 12.1.8 дахь заалтын “эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.9 дэх заалтын “хамгаалалтын хөтөлбөр” гэснийг “хамгаалалт” гэж, 12.1.12 дахь заалтын “ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.13 дахь заалтын “болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “, аэродромыг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.10, 12.1.14, 12.1.15, 12.1.16, 12.1.18 дахь заалтын “байгууллагын

гэрчилгээжүүлэлт” гэснийг “байгууллагыг гэрчилгээжүүлэх” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “үр шим” гэснийг “үр ашиг” гэж, 16.1.2 дахь заалтын “ажил гэдэгт” гэснийг “ажилд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь” гэснийг “Агаарын тээвэрлэгч” гэж, “гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий” гэснийг “гүйцэтгэх шаардлага хангасан” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.7, 22.1.8 дахь заалтын “нисгэх” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 19.3 дахь заалтын “өөрөөр шийдвэрлэх” гэснийг “нислэгийг хэвийн үргэлжлүүлэх” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “зорчигчийг аюулгүй болгох” гэснийг “зорчигчид шаардлага тавьж, аюулгүй байдлыг хангах” гэж, 21.4 дэх хэсгийн “учруулахуйц” гэснийг “учруулж болзошгүй,” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтын “зөрчсөн” гэснийг “зөрчиж” гэж, 22.1 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “нэвтрэн өнгөрөх” гэснийг “нэвтрэх” гэж, 23.2 дахь хэсгийн “Нислэгийн хөдөлгөөний” гэснийг “Агаарын навигацийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт” гэснийг “нутаг дэвсгэр, агаарын зайд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “зайн” гэснийг “зайд” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж, 29.3 дахь хэсгийн “аэродром нь” гэснийг “аэродромын үйл ажиллагаа эрхлэгч” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “хууль, дүрмийг” гэснийг “хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрмийг” гэж, 33.4 дэх хэсгийн “хураан авах, эсхүл саатуулна” гэснийг “хураан авна” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, “гэрчилгээжүүлэлт” гэснийг “гэрчилгээ” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.3 дахь заалтын “үзлэг” гэснийг “хяналт” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “нислэг техникийн” гэснийг “агаарын хөлгийн”

гэж, 42 дугаар зүйлийн 42.4.6 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дахь хэсгийн “алба” гэснийг “байгууллага” гэж тус тус, “төрийн захиргааны байгууллага” гэснийг “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тохиолдол бүрд өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “үйлдэж байгаа” гэснийг дараах “улсын агаарын хөлгийн” гэснийг мөн заалтын “бусад” гэснийг дараа шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нэлээн урт л юм байна. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “, тэдгээрийг багтаасан” гэснийг, 5.1.7 дахь заалтын “эсхүл” гэснийг, 5.1.10 дахь заалтын түүний” гэснийг, 5.1.13 дахь заалтын “төлөв” гэснийг, 5.1.18 дахь заалтын “Чикагогийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “үйл” гэснийг, 9.2.5 дахь заалтын “иргэний” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “эсхүл” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “агаарын хөлөг үйлдвэрлэгчийн” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нислэгийн үйл ажиллагаанд” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “агаарын хөлөг” гэснийг, 23.2 дахь хэсгийн “нисгэх” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “зориулсан” гэснийг дараах “аэродромын” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “дарга, нисгэх” гэснийг, 43 дугаар зүйлийн 43.2.1, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “ямар ч үед” гэснийг тус тус хасах. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. Найруулгын санал л гарсан юм байна даа. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “хэлэлцэн” гэснийг өмнө “Конвенцын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “Дарга” гэснийг дараа “энэ хуулийн 11.1-д заасан” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “зохицуулалт” гэснийг дараа “хийх” гэж,

18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “гэрчилгээ” гэсний өмнө “агаарын тээвэрлэгчийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “Нислэгийн” гэсний дараа “үед” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний дараа “цаашид “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэх/” гэж, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хамгаалалтын” гэсний дараа “үйлчилгээний” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “нислэгт” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал байна. Танилцуулъя. Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг хасах. Энэ дээр ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дээр төсөвтэй холбоотой асуудал бас орж ирж байгаа юм. Ер нь бол нисэхийн салбар дээр хоёрхон үйлчилгээний хураамж байдаг. Нэг нь бол аюулгүй байдлаа хангуулсан үйлчилгээ үзүүлснийхээ хүрээнд зорчигчоос авч байгаа такс байгаа. Нөгөөдөх нь бол агаарын навигацийн үйлчилгээ үзүүлснийхээ хувьд бол нэг хураамж төлж байгаа юм. Тэгэхээр энэ аэро навигацийн хураамжийг орж ирсэн төсөлдөө болохоор тодорхой хувийг, тодорхой хугацааны дотор улсын төсөвт бол хурааж авна, хураана, төлнө гэсэн нэг ийм заалт байсныг нь үндсэнд нь бол бас хасаж байгаа юм.

Яагаад гэхээр олон улсын ИСЮ олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тавьж байгаа шаардлага бол энэ олон улсын нисэхийн конвенцынхоо дагуу үйлчилгээг зөвхөн аюулгүй байдлыг хангах үйлчилгээ хүрээнд бол үйлчилгээ үзүүлнэ. Түүнээсээ бол тодорхой хэмжээний шимтгэл хураамж авна.

Авсан мөнгөө зөвхөн аюулгүй байдлынхаа тоног төхөөрөмжийг сайжруулах үйлчилгээгээ нэмэгдүүлэх хүрээнд хөрөнгө оруулалтаа хийнэ. Энд тодорхой хэмжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд хийх хөрөнгө оруулалтын боломж бололцооныхоо хэрээр яг тэрэндээ таарсан мөнгөний хураамжийг авна гэсэн нэг ийм л ИСЮ-гийн юуны конвенцын заалт байгаад байгаа юм.

Бид болохоор ер нь бол дэлхийд олон улсын юу нь иргэний нисэхийн хоёрхон байгууллага улс байгаа. Тэрний нэг нь манайх. Би одоо нөгөө улсын нэг их дурдаад яах вэ. Ганцхан манайх бол 2 улс байгаагийн нэг нь манайх улсын төсөвтөө мөнгөө тушаачхаж байгаа юм. Тэгэхээр иргэний ИСЮ-ийн шаардлагын хүрээнд бид нар үнэхээр 1 дүгээрт бол та нар дэндүү их эсвэл юу аваад байгаа юм уу, хураамж аваад байгаа юм уу, тийм болохоор улсдаа төлөөд байгаа юм уу гэдэг нэг асуудал болж байгаа юм.

2 дугаарт яг бид нарт хүрч ирээд шалгалтын хүрээнд ИСЮ-гоос тавьж байгаа дүн бол хамгийн гол асуудал бол энд байж байдаг. Хамгийн гол аюулгүй байдлыг хангах ёстой аэро навигацийнхаа үйл ажиллагаа дээр та нар хөрөнгө оруулалтаа оруулахгүй байна гэсэн ийм шаардлагыг бол улсынхаа төсөвт суулгаад байна гэсэн ийм энийгээ боль гэсэн ийм шаардлагыг бол тавьж байдаг. 2018-аас 2019 оны үед хамгийн их хөрөнгө оруулалтыг бид нар бол энэ аэро навигацийнхаа тоног төхөөрөмжийг Монгол Улсынхаа бүтэн нутаг дэвсгэртээ хяналт тавих ийм боломж бололцоо хөрөнгө оруулалтыг бол хамгийн ихээр бол хийсэн. Энэ дээр олон улсын ИСЮ-гийн хүрээнд маш том үнэлгээ авсан. Тэгээд манайхаар дайран өнгөрөх онгоцны тоо бол эрс нэмэгдсэн, эрс нэмэгдсэн.

Ер нь болбол 2 дахин 40 гаруй мянган онгоц дамжин өнгөрдөг байсан бол 120 140-өөд хэмжээнд бол очсон. Энэ хэмжээнд бол хөрөнгө оруулалт бол

юунууд орж ирсэн. Өөрөөр хэлбэл дээгүүр нисэж байгаа онгоцны тоо бол нэмэгдсэн юм. Тэгэхээр урьд өмнө бид нар яг энэ заалт байхгүй байхад тэртээ тэргүй улсынхаа төсөвт бол суугаад явж байсан шүү дээ. Тэр хэмжээгээрээ бол одоо ч гэсэн улсынхаа төсөвт суулгаад тодорхой хэмжээний мөнгийг бол улсдаа тушаагаад юу өгөөд төсөвт суулгаад явах ийм бүрэн бололцоотой байгаа. Ганцхан одоо энийг бид нар хийж зааснаараа олон улсын ИСЮ-гийн хүрээнд үнэлэмж маань доошоо буучихдаг хангалтгүй дүн авах. Ингэснээр Монгол Улсаар дамжин өнгөрөх энэ нислэгийн маань тоо, үнэлгээ буурах ийм нөхцөл байдал бий болгочих юм. Тийм болохоор та бүхэн маань энэ дээр анхаарал хандуулж өгөөч гэж та бүхнээс хүсэж байгаа юм. Тийм.

Л.Мөнхбаатар: Энэ ажлын хэсгийн ахлагч саналаа тодорхой хэлэх үү та?

Ж.Бат-Эрдэнэ: Энийг Эдийн засгийн байнгын хороон дээр унасан саналыг босгож өгөөч босгож өгөөч л гэж байгаа юм. Тийм, тийм. Баярлалаа. Дэмжээгүй саналыг.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр үг хэлье. Ажлын хэсгийн ахлагч бол саналыг босгох гээд байгаа юм байна шүү дээ тийм үү?

Б.Энхбаяр: Миний хувьд энэ Эдийн засгийн байнгын хороон дээр төслийн 28.2 дахь хэсгийг хасах саналыг дэмжихгүй үг хэлээд, тэгээд дэмжүүлээгүй байхад хувь нэмэр оруулсан хүн нь юм байгаа юм. Би бол ямар үндэслэлээр энэ хасаж болохгүй гэдэг үндэслэлийг ярьсан гэхээр энэ нийтдээ зуугаад сая долларын хэмжээний буюу 300-400 тэрбум төгрөгийг улсын төсөвт ер нь оруулдаг байх уу, үгүй юү гэдэгтэй холбоотой ганц санал хураалт бид шийдэх гээд байгаа бол цаад яригдаж байгаа мөнгөн дүн нь бол нэлээн том

хэмжээний мөнгө яригдах гэж байгаа юм нэг.

2 дугаарт миний гаргасан гол үндэслэл бол агаарын Монгол Улсын агаарын навигацгийн орлого бол ИНЕГ-ын өөрийнх нь бол өмч биш. Агаар бол нийтийн өмч, нийтийн өмч. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нийт ард түмний хүртээлтэй мэдэлд байдаг агаарыг ашиглуулсны төлөө орж байгаа орлого байхгүй юу. Тийм учраас энэ байгууллагын өмч биш. Бид нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар. Яамны өмч биш, нэг сайд энийг юунд зарах вэ гэдгийг захиран зарцуулаад байдаг бас өмч биш. Энэ орлогыг ер нь яг юунд зарцуулах юм, ямар хэмжээнд зарцуулах юм гэдэг асуудал өөрөө нарийн зохицуулагдах учиртай. Маши нарийн зохицуулагдах учиртай.

Тэгэхгүй бол ИНЕГ-ын дарга түүгээрээ 3, 400 тэрбум төгрөгийг ер нь мэддэг байг гээд хаявал энэ асар том хэмжээний авлига, асар том хэмжээний мөнгөн урсгалыг нэг байгууллагын даргад дур зоргод өгөх гээд байгаа юм. Тийм учраас би бол ямар агуулгаар ярьсан бэ гэхээр 1 дүгээрт энэ публик буюу нийтийн өмч гэдэг агуулгаа сайн ойлгоорой. Монгол Улсын агаарыг ашиглуулсны төлөөх орлого шүү 1.

2 дугаарт тэр агуулгаараа Улсын Их Хурлын буюу нийт ард түмний төлөөллийн дээд байгууллага Монгол Улсын төсөв, санхүү зээлийн бодлогыг тодорхойлох Үндсэн хуульд заачихсан бүрэн эрхтэй байгууллагын хараа хяналтаас гадуур байж болохгүй шүү гэдгийг би хэлээд байсан юм. Одоо бид нар энэ нүүрсний хулгай яриад Эрдэнэс таван толгойг яриад л байгаа шүү дээ. Нэг гүйцэтгэх захирал хэдэн их наядоор нь Улсын Их Хурлаар оруулаагүй, мэдүүлээгүй, ард түмний төлөөлөгчид нь мэдүүлээгүй, хараа хяналтаас гадуур юу болоод одоо бид хойноос нь юу болж байгаа вэ гэдэг асуудалдаа дүгнэлт хийх ёстой.

Тийм учраас хэрвээ энэ заалтыг хассан тохиолдолд, хассан тохиолдолд энэ ерөөсөө Улсын Их Хурлаар орохгүй шүү гэдэг агуулгаар хасаж байгаа хэрэг биш гэж би протоколд бүүр зориуд тэмдэглэж байгаа юм. 100 хувь энэ орлогыг Зам, тээврийн сайд, ИНЕГ-ын дарга захиран зарцуулна гэдгийг зөвшөөрч байгаа хэрэг биш шүү. Зөвшөөрч байгаа хэрэг биш. Саяын олон улсын гэрээ конвенцын заалтыг ойлгож байна. Тэгэхдээ энэтэй холбоотой энийг захиран зарцуулахтай холбоотой, юунд захиран зарцуулахтай холбоотой энэ нарийн зохицуулалт бол ард түмний төлөөллийн байгууллагад ядаж тайлагнагддаг байх ёстой шүү тэгвэл. Ядаж. Төсвийн гүйцэтгэл дээр орж ирдэг байх ёстой шүү. Засгийн газар энэ дээр журмыг нь гаргадаг байх ёстой шүү. Тэрнээс биш энийг ерөөсөө ингээд түүгээрээ захиран зарцуул, 100 хувь ерөөсөө төсөвт ордоггүй байх гэдгийг Улсын Их Хурал шийдэх гэж байгаа асуудал би биш шүү гэдгийг бүүр зориуд протоколд тэмдэглэж байгаа юм. Тодорхой хувь хэмжээ нь, одоо би бид хууль дээр хувь хэмжээ зааж чадахгүй байгаа бол 50 хувь нь юм уу, 20 хувь нь юм уу, 30 хувь нь юм уу заавал улсын төсөвт ордог байх ёстой гэдгийг хэрвээ бичихгүй байгаа бол бичихгүй байгаа бол уг нь бол би тэр олон улсын гэрээ конвенц дээр энэ орлогыг тухайн улсынх нь парламент ерөөсөө мэдэж болохгүй гэсэн заалт би байхгүй гэж ойлгож байгаа.

Монгол Улс бол Үндсэн хуульдаа нийцээгүй олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй гээд Үндсэн хуульдаа биччихсэн. Тэгэхээр манай улсын Үндсэн хуульд би харшилсан заалт Үндсэн хууль маань илүү хүчин төгөлдөр үйлчлэх учраас энийг би зориуд протоколд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэллээ. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. 13,2 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Эдийн засгийн байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Энхбаяр гишүүний хэлсэн зүйл бол протоколд тэмдэглүүлж байгаа. Тийм учраас Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг хийхдээ Энхбаяр гишүүний хэлсэн саналуудыг харгалзан үзэж бас дахин авч хэлэлцээрэй гэдгийг хэлье. Санал хураалт бол явагдчихсан байгаа. Энийг зүгээр сануулаад хэлчихье.

Дараагийн санал хураалтаа явуулъя. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “4 дүгээр зүйлийн” гэсний дараа “4.1.1 дэх заалтын “дээших хийн мандлын агаарын давхаргын” гэснийг “дээших агаар мандлын” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ. Ажлын хэсэгт ажиллалаа.

17.01 цаг

Долоо.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Дараагийнхаа асуудалд оръё. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Ажлын хэсгийн

гишүүдийн нэрс байна уу? Аваад ирээрэй. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 57 санал байна. Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хөтөлбөр хэрэгжүүлэх” гэсний дараах “хувийн нэмэлт тэтгэврийн” гэснийг хасаж, “талуудын” гэсний өмнө “оролцогч” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анужин, Батжаргал, Ганбаатар, Доржханд, Идэрбат, Жаргалмаа, Мөнх-Оргил, Оюунчимэг, Сандаг-Очир, Саранчимэг, Туваан, Чинзориг. Санал хураалт. Санал хураалтыг явуулна. Гишүүд байраа эзэлье. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн хувьд бол Засгийн газраас өргөн барьснаас гадна Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Баагаагийн Баттөмөр, Батсүхийн Саранчимэг, Лхагвын Мөнхбаатар, мөн Нарантуяа, өмнөх парламентад байсан Нарантуяа нарын гишүүд Хувийн тэтгэврийн тухай хуулийг санаачилж өргөн барьсан. Үүнийг хамтатган хэлэлцэж байгаа гэдгийг бас хэлье. Санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хэн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргая. Гишүүдээ.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дутуу дарагдчих шиг боллоо, тийм болохоор санал хүчингүй гэсэн санал хураалт явуулж өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн цаашид гүйцэд дарж байна шүү. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар тус санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд. 52,6 хувиар санал дэмжигдлээ. Саналын, сая хүчингүйд тооцсон учраас үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. Хуулийн төслийг санаачлагч Булгантуяа сайд, Байнгын хорооны дарга Анужин нар ирцээ бүрдүүлье. Хэн санал гаргах юм бэ? Энх-Амгалан гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн горимын санал гаргая.

Л.Энх-Амгалан: Хурлын дарга юу, сая нөгөө аппарат ажилласангүй. Дахиад санал хураалт хийж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалангийн гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ. 3.Төслийн 4 дүгээр зүйлийн, одоо яг үндсэн санал хураалтаа явуулах юм байна. Сая хүчингүйд тооцсон учраас. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Саяын үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “даатгалд хамрагдсан” гэснийг “даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “31.1.3-т заасан урт хугацааны даатгал эрхэлж буй этгээдийг” гэснийг “4.1.2-т заасан

даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан урт хугацааны даатгал эрхэлж байгаа компанийг” гэж, 5.1.10 дахь заалтын “хөрөнгө эзэмших” гэснийг “хөрөнгө өмчлөх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 5.1.16 дахь заалтын “бүрэн” гэснийг болон 5.1.17, 5.1.18 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, 5.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.21. “хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “түүнийг” гэж, 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагааг” гэснийг “хөтөлбөрийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хүртэл хувь хүний” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “тогтоолгохоор хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох” гэснийг “тогтоолгох” гэж өөрчилж, “хүртэл ажил олгогчийн” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүд. 8.Төслийн 9 дүгээр, 65,8 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мөнгөн дүн ба төлөх” гэсний дараах “давтамж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,4 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “шимтгэл төлөх” гэснийг дараах “давтамж,” гэснийг хасаж, 10.4 дэх хэсгийн “хамрагдсан ажилтны” гэсний дараа “сард” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсгийн “сар бүр тооцож,” гэсний дараа “хагас жил тутамд” гэж, 11.7 дахь хэсгийн “Баталгаат өгөөжийн” гэсний дараа “жилийн” гэж нэмж, “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/ны” гэж /цаашид тохиолдол бүрд/ өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Яасан үг авах юм уу? Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлье.

Д.Өнөрболор: Компанийн статустай ийм тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн зах зээл дээр оролцогч ийм Сангийн хууль бол орж ирж байгаа. Тэгээд энэ хуулийг ер нь хэзээнээс мөрдөж эхлэх вэ гэж асууя. Ер нь энэ бол гараагаа бас зөв эхлэхгүй бол болохгүй. Одоогийн нийгмийн даатгалын сангийн явуулж ирсэн үйл ажиллагаа бол үндсэндээ төсөв энэ эдийн засагт бол дандаа алдагдалтай ийм сөрөг нөлөөлөлтэй явж ирсэн. Нэг жилийн энэ төсөвт ирэх ачаалал гээд тэгэхэд чинь л 1 их наяд төгрөг байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуримтлалын санг бол зөвхөн компанийн болон энэ бусад хуулиар зохицуулахаас гадна, удирдлага зохион байгуулалт энэ менежмент талаасаа энэ асуудлыг ер нь яах юм бэ гэдгийг яг энэ хуулиар бол илүү тодорхой болгож оруулж ирэх ёстой гэж бол үзэж байна.

Тэгээд энэ хуулийн төслийн хар даа бусад баримт бичгээс ингээд харахлаар НДШ 4 хувиар нэмэгдэж, 2 хувийг нь ажил олгогч, 2 хувийг нь ажилтан төлнө гээд ингээд ийм байдлаар зарцуулах зардлын тооцооллыг бол хийсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ дагалдаж байгаа хуулиараа ингэж хийчхээд, хуулийн

төсөл дээрээ болохоороо ажил олгогчийн төлж байгаа шимтгэлийн 50 хувиас, ажилтны 20 хувиас хэтрэхгүй гэсэн ийм заалт байгаад байгаа юм. Тэгэхээр энийг юуг ер нь яг юу гэж ойлгох юм бэ? Тодорхой асуухад ер нь энэ НДШ ер нь хэдэн хувиар нэмэгдэж байгаа юм бэ? Энэ санд төвлөрнө гэсэн гэж ойлгох юм уу, энэ тооцооллыг нь. Ер нь энэ сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудал бол маш чухал асуудал байгаад байгаа.

Нөгөө л нэг энэ юугаар шударгаар хөдөлмөр эрхэлдэг, тийм ээ юу ажил олгогч юм уу эсвэл юу гэдэг юм энэ нөгөө шимтгэл төлөгчдийн нуруун дээр илүү их ачаалал үүсэх ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм биш үү гэдэг асуудал энэ юу нь бичиг баримтаас чинь харагдаад байна. Хэрэв нэмэгдүүлэхээргүй, үнэхээр нэмэгдүүлэхээргүй одоо байгаа энэ нийгмийн даатгалын шимтгэлийг тийм ээ тодорхой хувиар бүрдүүлнэ гэж бодож байгаа бол төсөвт ирэх ачааллын дарамтыг ер нь хэрхэн бууруулна гэж үзэж байгаа юм бэ? Энэ дутагдаж байгаа эх үүсвэрийг ер нь яаж хангана гэж үзэж байгаа юм бэ, бүрдүүлэх юм бэ?

Нийгмийн даатгалын санг энэ мөнгөжүүлэх, энэ хуримтлалын санг бий болгохдоо байгалийн баялгийн менежмент тийм ээ, хуваарилалт энэ Амнатын зохистой хуваарилалтыг бол хийж, энэ санг тогтворжуулах бол хэрэгтэй. Гэтэл энэ хууль бол орж ирээгүй байгаа. Тэгээд энэ хуультай уялдуулж орж ирэх нь би бас зүйтэй гэж авч үзэж байгаа юм. Тэгээд энэ сан ер нь амжилттай энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд үүсэх эрсдэлүүдийг ер нь бас ингээд сайтар тооцож бодож үзэхгүй бол болохгүй. Тухайлбал энэ Удирдах Зөвлөлийн бүтэц байна. Энэ хяналтын бүтэц байна. Гүйцэтгэлийн гүйцэтгэх удирдлагын бүтэц байна тийм ээ. Тэгээд энэ хуучин энэ арилжааны банкнууд энэ Хөгжлийн банкнуудтай холбоотой өнгөрсөн хугацаанд гарсан энэ хулгай луйвар ийм асуудлуудтай давхацсан ийм адил жишиг тогтох вий

гэдэг дээр бол үнэхээр санаа зовж байна. Тийм учраас энэ сангийн удирдлага, зохион байгуулалт энэ менежментийн асуудлуудаа бол тодорхой болгох хэрэгтэй байна.

Нөгөөтээгүүр бол гишүүд даатгуулагчдын өмнө хүлээх үүрэг, тэгээд энэ хариуцлагын асуудлуудаа бол бас яг энэ хуульдаа оруулж зохицуулах тодорхой шаардлагатай байна гэж бол харагдаж байна. Энэ тал дээр тайлбар авъя.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүнээ энэ зарчмын зөрүүтэй санал хураалт дээр бол асуулт, хариулт бол байдаггүй. Хэлэлцэх эсэх асуудал дээр энэ асуудлыг ярьж болно. Түүнээс гадна Байнгын хороо хуулийн төслийг зүйл, заалт бүрээр нь санал хураадаг. Тэр үед бас мөн ярих боломжтой байсан гэдгийг хэлье. Ингээд өөр, Ням-Осорын Учрал гишүүн дэмжиж үг хэлэх юм уу? Учрал гишүүн үг хэлье.

Н.Учрал: 2017 онд АХБ-ны зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулаад, тухайн үед Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдаар ажиллаж байсан энэ Номтойбаяр сайд энийг өргөн барьсан. Дараа нь тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулаад тухайн үед энэ Мөнхбаатар гишүүн бидний хамт өргөн мэдүүлсэн энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хууль дээр энэ АХБ-ны саналуудыг тусгаад, бидний 5 гишүүн өргөн барьсан. Ингээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн хууль гээд эдгээр хуулиудыг нэгтгээд энэ хуулийн төслийг бид хэлэлцэж байна.

Тэгэхээр 1 онцлог зүйл нь юу юм бэ гэхээр энэ бол нөгөө албан журмаар нөгөө ажилтан ажил олгогч хоёрын 17 хувиас нь тэр 2 хувийг нь албан журмаар төлөх зохицуулалт бол өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа хуульд байхгүй. Өнөөдрийн хууль бол сайн дураараа хувийн нэмэлт тэтгэврийн санд тодорхой хуримтлал

үүсэх бололцоог иргэддээ нээж өгч байгаа. Тэгэхээр 20 оны улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт олон давхаргад тэтгэврийн тогтолцоотой болно гэдэг зорилтыг дэвшүүлсэн. Өнөөдрийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт мөн олон давхаргад тэтгэврийн тогтолцоо руу шилжинэ гэдгийг дэвшүүлсэн. Одоо бол тэтгэврийн хувийн тэтгэврийн санг зохицуулсан ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй хэдий ч өнөөдөр арилжааны банкнууд дэргэдээ ТББ-ын нэрээр ТББ-ын статусаар тэтгэврийн сангийн үйл ажиллагаа явуулж байдаг. Эргээд өнөөдөр Голомтоос, Ардаас эхнээсээ тэтгэвэрт гараад эхэлчихсэн.

Гэтэл бид нар өнөөдөр хууль, эрх зүйн зохицуулалтыг нь хийхгүйгээр иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахгүйгээр л яваад байна гэсэн үг. Хэрэв тэтгэврийн сан эрсдэлд орвол хэн хариуцлагыг нь хүлээх вэ гэхээр тэр чинь ТББ-ын статусаар яваад байгаа юм. Тэгэхээр Өнөрболор гишүүн бол нөгөө албан журмаар гэж ойлгоод байх шиг байна. Дээрээс нь яах вэ энийг нөгөө олон жил бид нөгөө ажлын хэсэг гээд ажиллачихсан учраас ёстой олон ярьсаар байгаад өөрсдөө ч тэр нөгөө ярианаасаа бараг нөгөө уйдах шахуу юм болж байна шүү дээ. Энэ аягүй олон сайдуудын үед ингээд л ороод л ирдэг, ороод л ирдэг. Энэ удаагийн энэ тэтгэврийн шинэчлэл бол нөгөө нэг алхам урагшилж байна. Ядаж хагас хуримтлал руу, ядаж олон давхаргат руу, ядаж тэтгэврийн индексжүүлэх асуудлыг хөндөөд ингээд оруулаад ирж байгаа юм.

Тэгэхээр Өнөрболор гишүүн бол яах вэ хуулиа уншихаас гадна эхнээс нь бас ярьж эхэлбэл нэлээн их цаг хугацаа шаардах учраас би бол ингээд зогсъя. Энэ бол сайн дураараа, дээрээс нь танд бас хэлэхэд тэтгэвэр бол нөгөө нэг санхүүгийн даатгалын бүтээгдэхүүн бас биш байхгүй юу. Тооцож болдог асуудал. Даатгал бол тооцож болдоггүй эрсдэл. Тэтгэвэр бол цаг хугацаатай, тооцож

болдог. Тийм учраас энэ дээр бол бүүр нөгөө танин мэдэхүйн болоод нөгөө онолын ойлголт танд эхэлж өгч байж араас нь хууль яривал юм уу одоо хаашаа юм.

Гэхдээ зүгээр нэг л зүйлийг ярья. Одоо бүгдээрээ хувийн нэмэлт тэтгэврийн санг хуульчилснаараа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах гэж байгаа юм. Сая Туваан гишүүний хэлээд байгаагаар. Нэгэнт нөгөө ТББ-ын статусаар хүмүүст хуримтлалыг нь аваад, тэтгэвэрт гарахад нь олгоод байхад манай Тогтохсүрэн дарга бол байнга асууж байгаа шүү дээ. Тэтгэврийн, хувийн тэтгэврийн санд цалингаасаа тодорхой шимтгэл төлье гэхээр эрх зүйн зохицуулалт байхгүй учраас эрсдэлтэй байгаад байна. Энийг хуульчилчихвал иргэд ч гэсэн илүү орлогоо хуримтлуулдаг болно. Тэгээд тэр мөнгийг нь хөрөнгө оруулалт менежментийн компаниар удирдуулаад хөрөнгийн зах зээлийг бодитоор дэмжих нөхцөл бололцоо бий болно. Ер нь бол хувийн тэтгэврийн сан байгуулагдсанаар хөрөнгийн зах зээл буюу бид нар нөгөө 2 тулгууртай эдийн засагтай болох эхлэлийг л тавих гээд байгаа юм. Нөгөө бонд авдаг, үнэт цаас авдаг, листэд компанид хөрөнгө оруулалт хийдэг. Ингээд хөрөнгийн зах зээл дэмжигдээд эхлэх юм бол цаашидаа бид нар энэ хувийн тэтгэврийн сангаараа дамжуулаад хөрөнгийн зах зээлээ дэмжих тодорхой ойлголт бий болно. Тийм учраас гишүүн танд одоо хэлэхэд энэ бол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах гээд байгаа хууль шүү. Нэгэнт төрийн бусаар баахан хүмүүсийн хуримтлал авчхаад, эрсдэлд оруулахаас нь хамгаалахын тулд энэ хуулийг даруй гаргах хэрэгтэй. СЗХ хяналтаа тавих хэрэгтэй. СЗХ тэр хувийн тэтгэврийн сангуудад тавьдаг шаардлагаа тавих ёстой.

Дээрээс нь энэ ажлын хэсгийнхэнд бас нэг хэлэхэд нөгөө яг банк шиг 20 хувиас дээш эзэмшиж, нэг хуулийн этгээд болохгүй гэдэг зохицуулалт энэ дотор

байгаа биз дээ. Тэр алдагдсан харагдаад байгаа шүү. Ажлын хэсэг хэсэг хийх ёстой ажиллаарай. Нөгөө банк шиг нэг хуулийн этгээд 20 хувиас дээш эзэмшигч байж болохгүй. Тэрийг бол нөгөө бидний гишүүдийн хууль дээр бол оруулсан юм. Ингээд 20 хувиас дээш байхгүй гэхээр 5 хуулийн этгээд л оролцох, тэгээд 1 компани давуу хийх эдлэхгүй байх ёстой гээд ингээд энэ бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Нэг гишүүн 2 удаа үг хэлэхгүй. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн л үг хэлэхээр байгаа. Гишүүд үг хэлж дууслаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Гишүүд суудалдаа суугаарай. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13.1-д” гэсний өмнө “эрх залгамжлагч, өвлөгч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ. 12.Төслийн, гишүүд санал хураах боломж нөхцөлөөр хангая.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж, 14.3 дахь хэсгийн “санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг” гэснийг “санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрдэлийг” гэж тус тус өөрчилж, 14.7.5 дахь заалтын “зүйл” гэснийг болон 14.7.2 дахь заалтыг тус тус хасаж, 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.6 дахь заалт нэмэх:

“14.2.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлэе.

Б.Энхбаяр: Энэ нөгөө 2 жил хагасын өмнө Улсын Их Хуралд өргөн баригдаж байсан, хэлэлцэхийг нь

шийдчихсэн хууль орж ирж байгаа учраас нөгөө бараг мартчихсан, дахиж үзэх шаардлага гарч байгаа юм. Яах вэ АХБ-ны бас төсөл хөтөлбөрийн хүрээнд бичигдсэн гэдгээрээ энэ нэлээн жсоохон бас хэл найруулга, орчуулгын нэр томъёог нь их анхаарахгүй бол болохгүй байна. Жишээлбэл одоо бидний энэ санал хураах гэж байгаа 14.2.6 хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх гэж. Тохиромжтой этгээд гэж ер нь ямар этгээд байдаг юм бэ? Тохиромжтой этгээд гэдгийг хууль зүйн нэр томъёондоо тайлбарласан юм болов уу гээд би энэ 5 дугаар зүйлийг нь харсан чинь алга байна. Тэгэхээр энэ нөгөө personal... хэлээд байгаа юм уу гэдэг шиг тохиромжтой этгээд гэж энэ хууль зүйн би ер нь огт сонсоогүй нэг ийм ойлголт ороод ирчихсэн байна.

Энэтэй холбоотойгоор хуралдаан даргалагчаас ерөнхийд нь нэг чиглэл өгөөч гэж хүсэх гэж байна. Би хэд хэдэн заалт уншиж өгнө та хэдэд. Тухайлбал хуулийн төслийн 15.6.удирдах зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна. 15.6.5.хорооноос тогтоосон бусад шалгуур, 17.5.хороо нь дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана, 17.5.4.бусад үндэслэлээр татгалзана гэж байгаа юм. Энэ нэг юу нь мэдэгдэхгүй. 18 дугаар зүйл хорооноос 18.1.6 хорооноос баталсан дүрэм журам тодорхойлсон бусад холбогдох бичиг баримт. Нөгөө нэг бүрдүүлэх баримт дотор нь. Хороо нь дахиад энэ хуульд зааснаас нэг бичиг баримтууд шаардах юм шиг байна.

20 дугаар зүйл.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийг түдгэлзүүлэх буюу дуусгавар болгоно. 20.1.8.хууль тогтоомжид заасан бусад. Юу юм мэдэхгүй. Бусад гэдэг үндэслэлээр хүчингүй болгоно. 28 дугаар зүйл.Хөрөнгө оруулалт хийхийг хориглох гэж заалт. Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно. 28.1.7.хорооноос хориглосон бусад. 32 дугаар зүйл. Кастодианы гэрээгээр дараах харилцааг

зохицуулна. 32.1.4.бусад. Бусад харилцааг зохицуулна. 36 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сан урт хугацааны даатгалын хөрөнгө оруулалтын менежментийн компанитай дараах асуудлыг тусгасан хөрөнгө оруулалтын менежментийн гэрээ байгуулна. 36.1.4.холбогдох хууль тогтоомжид заасан бусад. Энэ ерөөсөө ийм нэг, 38 дугаар зүйл. Хороо дараах нөхцөлд холбогдох хариуцлагын арга хэмжээ авна. 38.1.4.бусад. Энэ юу болоод явчлав? Хасагдаж байгаа юм уу?

Жишээлбэл миний саяын уншсан 15.6 байгаа шүү дээ. Хорооноос тогтоосон бусад шалгуур гэдэг бол энэний дараагийн хураах гэж байгаа 15 дугаар зүйлтэй холбоотой санал хураах гэж байгаа асуудал дээр бол хөндөгдөөгүй байна. Хөндөгдөөгүй. Тэр бусад шалгуур гэдэг бол хөндөгдөөгүй байна одоо, дараагийнх дээр. Тэгээд би тулгаж үзээд энэ бусад гэдэг ийм, ийм тогтоосон юмнууд ер нь юу байна гээд нэг бүрчлэн үзэж байгаад сая нэг ийм юмнуудыг хэлж байгаа юм жишээлбэл. Тэгээд энэ асуудлыг одоо яг одоо бидний хураах гэж байгаа асуудал дээр бол тохиромжтой этгээд гэж энэ ямар этгээд байна вэ? Энэ хуулийн нэр томъёо дотор бол тохиромжтой этгээдийг тайлбарласан нэр томъёоны тайлбар бол байхгүй байна хуульд. Би тийм учраас энэ үгийг хэлж байгаа.

Л.Мөнхбаатар: Энэ саяын Энхбаяр гишүүний хэлээд байгаа энэ бусад харилцаа, бусад шалгуур, холбогдох хууль тогтоомжид заасан бусад гэх мэтчилэн ингээд тодорхойгүй томъёолоод байгаа энэ зүйлүүдийг бол нэгтгээд, сүүлд нь найруулгын саналаар хасаж байгаа юм байна тийм үү? Хасаж байгаа юм байна. Тийм учраас санал хураалт явагдах учраас энэ зүйлийг энэ тэр бол чиглэл өгөх боломжгүй байна. Энэ тохиромжтой этгээд гэдэг бол өөрөө өөр хууль тогтоомжид байгаа юм уу энэ заалт нь? Энэ хуулийн хууль зүйн нэр томъёо байгаа шүү дээ. Энэ хуульд

заасан. Тэр нэр томъёонд байхгүй байгаа болбол нь энэ асуудал дээр, ямар хууль дээр байгаа юм бэ? Энэ өөрөө хуульд нэрлэгдсэн нэр томъёо мөн юм уу? Хэрвээ хуульд нэрлэгдээгүй байх юм болбол нь энэ асуудлыг гүйцээн боловсруулах, байгаа юм уу? Тэгвэл хуульд бол тодорхойлогдсон нэр томъёо юм байна. Тийм учраас чиглэл өгөхгүй. Санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг, саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ Байнгын хороон дээр саяын нэгэнт хуульд тодорхойлогдсон томъёолол байгаа бол түүнийгээ эшлэх нь бол зүйтэй шүү. Тэрийг анхааруулж хэлье. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “сангийн удирдах зөвлөл” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл, бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.6 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага, холбогдох этгээд” гэснийг “бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.9.7 дахь заалтын “үйл ажиллагааг эрхлэх” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 16 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараах “нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 17 дугаар зүйлийн гарчгийн “зөвшөөрөл олгох үйл ажиллагаа” гэснийг “зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэж, 17.3 дахь хэсгийн “45 хоногийн” гэснийг “21 өдрийн” гэж, 17.4 дэх хэсгийн “баримт бичиг, мэдээллийг” гэснийг “мэдээлэл, баримт бичиг, тодруулга, тайлбар” гэж, “60 хоногийн” гэснийг “45 өдрийн” гэж тус тус өөрчилж, 17.5.4 дэх заалтыг “худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан.” гэж өөрчлөн найруулж, 17.1 дэх хэсгийн “Хороонд”

гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 17.1.7 дахь заалтыг хасаж, 17.3 дахь хэсгийн “ирүүлэхийг шаардах,” гэсний дараа “тодруулга, тайлбар авах” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “хүсэлт гаргагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.8, 17.9, 17.10, 17.11, 17.12, 17.13, 17.14, 17.15 дахь хэсэг тус тус нэмэх:

“17.8.Хороо дараах тохиолдолд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

17.8.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

17.8.2.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

17.8.3.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

17.8.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

17.9.энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тоггоосноос хойш хувийн тэтгэврийн сан, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

17.10.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 17.9-д заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

17.11.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын таван өдрийн дотор хувийн тэтгэврийн санд хүргүүлнэ.

17.12.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

17.13.Энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

17.14.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

17.14.1.хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дуусгавар болгохоос ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар мэдэгдсэн;

17.14.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

17.14.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

17.14.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

17.14.5.Зөвшөөрлийн тухай хуульд заасан бусад.

17.15.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт санал хураалтыг түдгэлзүүллээ. Ням-Осорын Учрал, мөн Баттөмөрийн Энхбаяр гишүүн нар үг хэлнэ. Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг тэр 2 жил хагасын өмнө өргөн барьсан хуультай нэгтгэсэн гэж би ойлгоод байгаа юм. Гэхдээ энэ хамгийн чухал заалтыг энэ ажлын хэсэг оруулж ирээгүй байна. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэхэд тэр хувийн тэтгэврийн санг байгуулахад нэг хөрөнгө оруулагч нь буюу тэр хувийн тэтгэврийн сангийн нэг эзэмшигч нь 10-аас дээш хувийг эзэмшихгүй гэдэг заалт байсан байхгүй юу. Анх тэр гишүүдийн өргөн барьсан хууль дээр. Гэтэл энэ заалт ер нь хааччихав? Тэгээд одоо сүүлдээ ямар байдал үүсэх вэ гэхээр наадах чинь 20, 30 жилийн дараа бас л нөгөө сая банкнууд дээр нэг банк эзэмшиж байгаа нөхөр л хамаг юм руу хөрөнгө оруулалт хийлээ гээд. Энэ чинь хуулийн боломж байсан л байхгүй юу.

Гэтэл өнөөдөр ингээд хувийн тэтгэврийн санг байгуулах нэг компани 10-аас дээш хувийг эзэмшихгүй гэдэг энэ заалтыг хийхгүй бол сүүлдээ бас л нэг компани, нэг этгээд ерөөсөө л энэ хувийн тэтгэврийн санг бүтнээр нь эзэмших ийм л нөхцөл байдал үүснэ шүү дээ. Тэгэхээр тэр заалтыг байхгүй болгочихсон байгаа. Тэгээд СЗХ тусгай зөвшөөрөл өгөхдөө тэгээд л бараг 50, 60, 70, 80 хувийг нь эзэмшдэг ийм сангуудад зөвшөөрөл өгөөд байх нь байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь эрсдэл. Яагаад энэ заалтыг аваад хаячхав? Анх нөгөө гишүүдийн хууль дээр 10 хувь гээд байсан байхгүй юу. Тэгэхээр багадаа 10 хувь гэхээр багадаа 10 компани нийлээд нэг хувийн тэтгэврийн санг 10 хуулийн этгээд нийлж байгуулах ийм

заалт байсан юм. Гэтэл одоо хэн ч байгуулж болох л болчихлоо гэсэн үг.

Тэгээд 1 хувьцаа эзэмшигчтэй тэтгэврийн сан байгуулагдах гээд байна шүү дээ, хувийн тэтгэврийн сан. Тэгэхээр энэний чинь цаана дахиад л эрсдэл байна. Тэгээд ажлын хэсгийнхэн тэгээд ядаж энэ 17 дугаар заалт дээр энэ зүйл дээрээ энэ босгыг тавьж өгөөч. Тэгээд ер нь бол СЗХ-ны ажил бол үнэхээр их тоймгүй их болчихлоо шүү дээ. Одоо энэ хууль гарснаараа тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг хороо гаргах ёстой. СЗХ бол салбар болгон руу ороод, өнөөдөр ажлын ачааллаа бол дийлэхээ больсон. Тэгээд ер нь манай ингээд Их Хурал дээр ингээд нэг хуулийг нь ингээд бүүр ингээд хав дарчихдаг. 2 жил хагас энэ хуулийг хав дарсан шүү дээ. Засгийн газраас өргөн мэдүүлнэ гэж хэлээд л дараад л байсан, дараад л байсан. Тэгээд сая энэ Энхбаяр гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Үнэхээр гишүүдийн барьсан нөгөө хуулийг бүүр мартчихсан байхгүй юу. Тэгээд ингээд олон жилийн дараа нэг ийм юм оруулж ирээд ингээд нэгтгэхээр чинь манай хууль дээр ч юу байсан юм, Засгийн хууль чинь ч юу болсон юм. Тэгээд ингээд ерөөсөө нэг ингээд дунд нь асар чухал заалтууд орхигдчихлоо.

Хоёрт энэ СЗХ ажлаа үнэхээр барахаа больсон, дийлэхээ больсон. Одоо энэ нэг нөхцөл шаардлагын журмыг бол гаргах гэж хэр удахыг бол үнэхээр таашигүй. Үнэхээр таашигүй. Тэгээд одоо нөгөө юу, юу болсон. Нөгөө Мэргэжлийн холбооны хууль. Энэ чинь энэ СЗХ-ны ажлын ачааллыг л багасгахад бас нэг тодорхой хувь нэмэр оруулах хууль байхгүй юу. Мэргэжлийн холбооны хуулийг гаргачихсан бол мэргэжлийн дүгнэлт өгөөд СЗХ хамтраад ажиллах бололцоог нь бүрдүүлье гээд л Мэргэжлийн холбооны хуулийг өргөн бариад, хэлэлцэх эсэхийг дэмжээд бас одоо нэг 3 дахь жил рүүгээ орж байна уу. Засгийн газар өргөн мэдүүлээд нэгтгэнэ л гэсэн. Одоо тэгээд ерөөсөө сүүлдээ нэг

ингээд нэг гишүүдийн хуулийг Засгийн хуультай нэгтгэдэг гэдэг нэг ийм сайхан жишигтэй болчихсон.

Тэгээд нэгтгэсэн гэдэг нэрийдлээр хамгийн гол заалтыг нь аваад хаячихсан. Би бол энэ 10 хувийг хэрвээ тавихгүй бол би энэ хуулийг ер нь дэмжих бололцоогүй юм байна гэдгийг бол бас хэлчихье. Яагаад гэхээр сүүлдээ сая тэр нөгөө ХХБ-ны асуудал ч гэсэн энэ шүү дээ. Үгүй ээ тэр чинь хуулийн боломж нь байсан юм чинь нэг хүн нэг банкийг эзэмшээд л бүх юм руу хөрөнгө оруулалт хийсэн л гээд байсан. Түүн шиг олон жилийн дараа хувийн тэтгэврийн санг ганцаараа эзэмшдэг хэсэг бүлэг баахан нөхдүүд гарч ирнэ. Энэ чинь иргэдээ хамгаалах гэж хийсэн хууль болохоос биш бид нар нэг хэдэн бизнес эрхлэгч нарыг эсвэл нэг нөгөө нэг банкийг дэмжих гээд байгаа хууль энэ биш шүү. Тийм учраас сая энэ Өнөрболор гишүүн ч бай, энэ Даваасүрэн гишүүн ч бай хэлээд байгаа бас үнэний ортой байгаа шүү дээ. Хэрвээ яг ийм босгуудыг авч хаяад ингээд батлах гэж байвал ийм хууль хэрэггүй. Хэсэг бүлэг нэг ганц, хоёр хүнийг дэмжих гэсэн хууль хэрэггүй. Иргэдээ хамгаалах гэсэн хууль гаргах гэж бид нар энэ Мөнхбаатар Их Хурлын дэд дарга, Баттөмөр гишүүн бид нар энэ хуулийг барьсан шүү. Иргэдээ хамгаалах гэсэн.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ чинь Засгийн газраас санаачилсан болон Учрал нарын гишүүдээс санаачилсан хуулийн төслийг нэгтгэж байгаа шүү дээ. Нэг хууль санаачлагч нь сая нэг үг хэлчихлээ шүү сая. Тэгэхээр энэ хуулийн цаашдын хувь заяанд би шууд нөлөөлөх байх гэж бодож байна нэг.

2 сая түрүүн би хэлсэн энэ баахан бусад гэдэг баахан шаардлага хууль дээр тавьчихсан байна. Энийгээ янзалж байгаа юу гэсэн чинь яг хэлж байгаа бусдуудыг чинь бүгдийг нь янзалчихсан байгаа гээд надад бол ингээд танхимд бол

хэлсэн. Би бол яг хуулийн өргөн барьсан төсөл, энэ санал хураалгаж байгаа саналын томъёолол хоёрыг яг тулгаж хараад уншаад яваад байгаа юм. Одоо бидний санал хураах гэж байгаа 17 дугаар зүйлийн 17 дугаар зүйлүүд дээр нэмж байгаа, хасаж байгаа томъёоллыг сая уншсан. Энд хасагдаж байгаа дотор лав тэр бусад гэдэг чинь алга байна. Өөрөөр хэлбэл бусад гэдэг зүйл чинь үлдчихсэн байна. Жишээлбэл 17.1.7.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт хороонд хүргүүлнэ. 17.1.7.бусад баримт бичиг.

Одоо бидний сая санал хурааж дэмжих гэж байгаа 17.15 хамгийн сүүлийн өгүүлбэрийн та бүхэн уншаарай. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг хороо батална. Энэ Зөвшөөрлийн хуулийн концепцтой нийцэхгүй байна. Бид Зөвшөөрлийн хуулиар ямар концепц гаргасан гэхээр тусгай зөвшөөрөл олгохдоо хүнээс шаардаж байгаа шаардлагууд, бичиг баримтууд зөвхөн Зөвшөөрлийн хуульд бичнэ. Зөвшөөрлийн хуульд бичигдээгүй ямар нэгэн журмаар, хэн нэгэн даргын баталсан журмаар нэмэлт бичиг баримт шаарддаг, нэмэлт хэм хэмжээ тогтоодог, нэмэлт шаардлага тавьдаг энэ бүх зүйлийг бид Зөвшөөрлийн хуулиар цуцалсан байхгүй юу.

Тэгэнгүүт энэ хуулийн чинь концепц юу болоод байна вэ гэхээр жишээлбэл 17.15 одоо санал хураагаад дэмжигдвэл энэ хуульд зааснаас нэмэлт шаардлагыг нь хороо батална гэдэг ийм заалт бид нар батлах гэж байгаа юм. Хороо ямар нэмэлт шаардлага тавих вэ гэдгээ өөрөө мэдэх гэж байгаа юм. Хороо өөрөө ямар нэмэлт шаардлага тавьж байгаад хүний юмыг цуцлах боломжийг бүрдүүлэх гэж байгаа юм. Бид ийм хууль зүйн техниктэй 20 жил явсан учраас хуулиас гадуур тэр хороо, агентлагийн дарга, сайд гэсэн хүмүүс чинь хуулийн

дээр гарч авлигажсан юм. Хүнээс нэмэлт бичиг баримт хүндрүүлдэг, удаадаг, шаарддаг, авлигажсан төртэй болсон юм. Бид дийлэхээ больсон учраас зөвхөн хуульд зааж заасан үндэслэлээр л хүнээс иргэдээсээ бичиг баримт шаардъя. Хуульд заасан хугацаанд нь л шийддэг байя. Хуульд заачихсан бичиг баримтуудыг өгчихсөн байвал тэр хүний зөвшөөрөл автоматаар олгогддог байя. Хүнээс хамааралгүй болгоё гэдэг энэ авлигагүй болох, авлигаас урьдчилан сэргийлэх ийм эрх зүйн шинэтгэлүүдийг хийж байгаа юм.

Тэгэхээр энэ ерөнхий үзэл санаанд энэ бусад, бусад, бусад хууль дээр хэм хэмжээ тогтоочоод дахиад тэрийг нь хороо тогтоогоод байх энэ заалтууд чинь асуудал үүсгэнэ. Хэрэгжилт дээр. Дараа нь СЗХ-ны дарга гэдэг бол хэнд тусгай зөвшөөрөл өгөх, хэний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хэнээс ямар бичиг баримт шаардах гэдэг ийм хуулиас хүрээ хязгааргүй эрхтэй болчихно. Би энэ асуудлыг 2 дахь удаагаа энэ СЗХ-ноос орж ирж байгаа хууль дээр анзаарч байгаа. Нэг нь Виртуал хөрөнгийн хууль дээр байсан. Мааш их журмыг, мааш их хэм хэмжээнүүдийг СЗХ-ны дарга тогтооно, дарга тогтооно, дарга тогтооно. 10 хэдэн журам байсан байхгүй юу. Тийм учраас энэ ерөөсөө ийм байж болохгүй, энэ санхүүгийн. Тэгвэл энэ хуулиар СЗХ-ны дарга энэ хууль доторх бүх харилцааг журмаар зохицуулна гэдэг ганц үгтэй хууль баталчих гэдэг үг хэлж байсан юм. Тэр үед Виртуал хөрөнгийн хууль дээр. Боломжтой бүх харилцааг бид хуульчлах ёстой. Хууль ойлгомжтой байх ёстой. Энэ хуулийг уншаад иргэн хүн ямар бичиг баримтыг бүрдүүлэв бүрдүүлэх юм, юуг зөрчвөл би ямар хариуцлага тооцох вэ гэдгээ ойлгодог байх ёстой. Энэ журмыг харахаар тэнд нэг СЗХ дахиад нэг нэмэлт шаардлага тавих юм байна. Дахиад журам.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: 2 зүйл хэлье. Гишүүд үг хэлсэн болно. 2 зүйл байна. 1 дүгээрт энэ хууль бол Засгийн газраас

өргөн мэдүүлснээс гадна Учрал нарын гишүүд бас хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг нэгтгэсэн ийм төсөл байгаа учраас хууль санаачлагч Ням-Осорын Учралын бас саналыг бас харгалзан үзэх нь зүйтэй. Тийм учраас 1 дүгээрт.

2 дугаарт Энхбаяр гишүүний хэлж байгаа тэр зүйл бол бас тодорхой үндэслэл байгаа юм. Ер нь аливаа харилцааг хуульчлахдаа их тодорхой нэрлэж хуульчлах хэрэгтэй, нэрлэж заах хэрэгтэй. Түүнээс биш бусад гэдэг юм уу ийм уут гаргаад байх юм бол түүгээр дамжаад хуульд заагдаагүй шаардлага, шалгууруудыг тавиад, энэ нь бол иргэдэд хүндрэл учруулж болзошгүй. Ийм учраас цаашид ер нь Улсын Их Хурлын Тамгын газар, Байнгын хороод бол энэ дээр анхаарах нь зүйтэй. Ийм 2 үндэслэлээр 15 дахь санал хураалт буюу төслийн 17 дугаар зүйлийг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Тийм, одоо энэ агуулгаараа 17 дугаар зүйлдээ Учрал гишүүн, Энхбаяр гишүүний хэлсэн саналуудыг харгалзан үзэж, Байнгын хороон дээрээ гүйцээн боловсруулья.

16.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 18.1.3 дахь заалтын “гэрээний санал” гэснийг “гэрээ” гэж, 18.2 дахь хэсгийн “30 хоногийн” гэснийг “20 өдрийн” гэж тус тус өөрчилж, 18.1.4 дэх заалтын “, бусад баримт бичгийн загвар” гэснийг болон 18.1.5 дахь заалтыг тус тус хасах. Санал хураалтыг түдгэлзүүлье. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье. Дараа нь Ням-Осорын Учрал гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ бол 18 дугаар зүйл буюу нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх гэсэн зүйл анги байна зүйл байна. 18.1.хувийн тэтгэврийн сан урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүртгүүлэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт хороонд хүргүүлнэ гэж байгаа юм. Энд би түрүүн хэлж байсан. 18.1.6.хорооноос

баталсан дүрэм журам тодорхойлсон бусад холбогдох бичиг баримтыг ирүүлнэ гээд бас нэг ийм ерөнхий байж байгаа юм. Энийг энэ заалтыг бусдыг бол хасчихсан гээд байгаа шүү дээ. Одоо сая энэ уншсан дотор 18.1.6-г хасах гэж бол байхгүй байна. Тэгэхээр би бол 18.1.6 нь төсөлдөө үлдэх гэж байна гэж уншаад байна, харж байна. Хорооноос баталсан дүрэм журамд тодорхойлсон бусад холбогдох бичиг баримтыг ирүүлнэ гэдэг ийм хууль батлах гээд байгаа байхгүй юу. Юу нь мэдэгдэхгүй.

Л.Мөнхбаатар: Ням-Осорын Учрал гишүүн үг хэлье.

Н.Учрал: Би энэ Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг энэ ажлын хэсэг бол их сайн ажиллаж, тодорхой зорилтуудыг дэвшүүлж, түүндээ хүрэх гэж урагшилсан гэдэгт бол би сэтгэл дүүрэн байгаа. Гэхдээ Хувийн нэмэлт тэтгэврийн хууль дээр бидний 5 гишүүний өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг нь дэмжигдээд Их Хурал дээр 2 жил хагас болсон хуультай нь нэгтгэж, өнөөдөр энд санал хураагдаж байгаа гэж би ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр түрүүн би бас буруу ойлгосон. Би бас Өнөрболор гишүүнээс хүлцэл өчиж байна. Энэ бол том эрсдэл. Ямар эрсдэл вэ гэхээр хувийн тэтгэврийн санг байгуулахад нэг эзэмшигч 10 хувиас дээш эзэмшихгүй гэдэг заалтыг хийхгүйгээр нээлттэй хаяна гэдэг бол иргэд сайн дурынх ч бай тодорхой тэр хувийн тэтгэврийн сан дээр сар болгон цалингаасаа шимтгэл төлөөд 20 жил, 10 жил төлсний дараа тэтгэвэрт гарахад Төрийн тэтгэврийн сангаас гадна хувийн нэмэлт тэтгэврийн сангаас шимтгэлийнхээ үр дүнд, хөдөлмөрлөснийхөө үр дүнд тэр шимтгэлийг тэтгэвэрт гарахдаа дараагийн тэр хувийн тэтгэврийн сангаас авах гээд байна шүү дээ.

Гэтэл тэр тэтгэврийн сан янз бүрийн байдлаар дампуурвал, янз бүрийн байдлаар эрсдэлд орвол яах вэ гэдгийг л энэ гишүүд сануулаад байна. Өнөөдөр

Голомтын тэтгэврийн сан, Ардын тэтгэврийн сан, маш олон тэтгэврийн сангууд хуульгүй учраас ийм үйл ажиллагааг ТББ-ын зарчмаар хийгээд байдаг. Энэ бол зөв, буруу биш. Хөрөнгийн зах зээлийг дэмжих гээд, хөрөнгө оруулалт хийгээд, ингээд иргэдийнхээ өнөөдөр сар болгон төлж байгаа мөнгийг нь хувьцаанд оруулаад, ингээд өнөөдөр тэтгэвэрт гарахад нь илүү шимтгэлд суурилсан тэр тэтгэврийнх нь үр дүнг нь хишигийг нь хүртээгээд ингээд явж байгаа. Энэ бол зөв.

Гэхдээ иргэдийн хуримтлалыг эргээд иргэддээ хүртээж чадахгүй эрсдэлд оруулбал яах вэ гэдгээс бид сэрэмжлэх ёстой гэдэг утгаараа өнөөдөр энэ хуульд хандах ёстой. Тийм учраас энэ СЗХ зөвшөөрлийг өгөхдөө тэр босгуудыг нь харж байж, нэг хуулийн этгээд 10 хувь байна шүү гэдгийг нь харж байж өгөх ёстой. Дээрээс нь ажлын хэсэг энэ Энхбаяр гишүүний хэлж байгаа дээр анхаараач. Зөвшөөрлийн хуулийг яах гэж гаргасан юм. Төр бол хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг. Хувийн хэвшил бол хуульд хориглоогүй бол тухайн үйл ажиллагааг явуулдаг. Ийм л 2 ялгаатай шүү дээ. Гэтэл Зөвшөөрлийн хуульд зөвшөөрөл ав гэж заагаагүйгээс бусад зүйл чинь зөвшөөрөлгүй шүү гэдгийг энэ Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсэг зөндөө хэлсэн юм шүү дээ.

Гэтэл гадна, түүнээс гадна гээд биччихээр чинь СЗХ өмнөхөө барж дийлэхгүй байхад дахиад нэг ийм олон журам гаргаж чадах юм уу? Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийг би бас ажлын хэсгийг нь ахалсан. Засгийн газраас мэдүүлсэн хуулийг ахлаад батлуулахад тухайн үед бараг 11 журам гарах ёстой байсан. Өнөөдөр 2 журам л гарсан гэж надад мэдээлсэн. Бусад нь гараагүй. Яагаад гэвэл тэнд мэргэжилтэн байхгүй. Өнөөдөр энэ хууль гарлаа. Энэ тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт тавигдах шалгуур шаардлага энэ олон журмын чинь гарах бололцоо тэр байгууллагад байхгүй. Яагаад гэвэл тэр

хүмүүс ачааллаа дийлэхгүй байгаа юм. Тийм учраас аргаа бараад Мэргэжлийн холбооны хуулийг миний бие санаачлаад Их Хуралд өргөн мэдүүлээд 2 жил хав дараад байна шүү дээ.

Яагаад тэгсэн бэ гэхээр жишээ нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хууль дээр ч гэсэн мэргэжлийн холбоо дүгнэлтээ гаргаасай, хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт тавигдах шаардлага дээр мөн тэр энэ мэргэжлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод хамтарч ажиллаасай гэдэг утгаараа л энэ хуулийг баталж өгөөсэй гэж хүссэн. Гэтэл дахиад л ийм байдалтай л байгаа. Тэгээд түрүүн Их Хурлын энэ Хууль, эрх зүйн газраас би бас асуумаар байгаа юм. Яагаад гэхээр энэ бол миний бас хариуцлага юм. Бидний 5 гишүүний барьсан хууль батлагдлаа. Миний нэр дээр нь явж байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн Учрал нарын хууль гээд. Энэ чинь хүссэн, хүсээгүй энэ хууль чинь ингээд батлагдсаны дараа Учрал гэдэг нөхөр ийм хууль баталсан гээд үлдэх гээд байна шүү дээ. 20 жилийн дараа эрсдэлд учирвал би энд хариуцлага хүлээхгүй шүү гэдгийг би өнөөдөр протоколд үлдээж байна.

Тийм учраас би үгээ хэлэх ёстой юм байна. Өнөөдөр яагаад миний болон бидний 5 гишүүний баталсан хуулийн тэр заалтыг хасаад, тэр заалтыг энэ заалтын агуулга нэг гэж нэгтгэлээ. Энэ заалтыг нь хүлээж авлаа. Энэ заалтыг нь хаслаа гээд явдаг байтал миний нэрийг дээр нь оруулчихаад, яагаад өнөөдөр Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийг ингээд заалт заалтаар нь хэлэлцүүлээд. Миний хууль хаана байна вэ? Бидний 5 гишүүний хууль хаана байна вэ гэж би асуух хэрэгтэй шүү дээ. Эсвэл миний нэрийг дээрээс нь авна. Би хуулиа тусад нь хэлэлцүүлье. Хувийн нэмэлт тэтгэврийн хууль дээр. Бусад хуулийн асуудал дээр бол би ямар нэгэн давхар хууль мэдүүлээгүй учраас надад хамаагүй.

Л.Мөнхбатаар: Дэмжсэн 3, дэмжээгүй 3 л хүн үг хэлнэ л дээ. Булгантуяа сайд үг хэлье. Тэгээд санал хураалтаа явуулъя. Булгантуяа сайдыг үг хэлсний дараа.

Х.Булгантуяа: Учрал гишүүний санаа зовж байгаа асуудал зөв. Тэгэхдээ Учрал гишүүнээ бид нар, бид нар ер нь таны өргөн барьсан хуулиас 2 санал л саналаас бусад нь энэ бүрэн шигтгэгдсэн байж байгаа. Албан журмын даатгалын тэтгэврийн шимтгэлийн дүр 4 хувиас 17 хувиас 4-ийг хувийн тэтгэврийн санд өгнө гэсэн тэрүүнийг одоохондоо бол арай хэтэрхий эрсдэлтэй байна гээд үгүй гэсэн.

Нөгөөдөх нь 10 хувь гэдэг нь бид нар ямар ч байсан энэ цоо шинэ харилцааг эхлээд эхлүүлэх гэж байгаа байхгүй юу 1 дүгээрт. 2 дугаарт бид нар ТӨК-ийн хувьчлалыг хийхдээ ч манай ААН-үүд ч гэсэндээ IPO гаргаад, хувьчлал хийхдээ мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг орж ирээсэй гэж боддог. Тэгж байж энэ бид нар дор хаяж 40 хувь дээр нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид байхгүй бол бүүр жижиглээд хаячихаар хэн нь ч үүнд хариуцлага бас хүлээдэггүй. Тэгэхээр бид нар ийм утгаараа ямар ч байсан энэ шинэ цоо шинэ тогтолцоог таны хэлж байгаа үнэн. СЗХ ч гэсэндээ үүн дээр яг санхүүгийн чадавхтай тийм компани үүнийг авч яваасай гэж хүсэж байгаа. Бид нар ч гэсэн үүнийг хүсэж байгаа юм.

Одоохондоо энэ ирэх оноос 7 сарын 1-нээс эхэллээ гэхэд одоогийн банк шиг 40, 50 их наядын активтай болтол ахиад бас нэлээн удах байх. Тэр болтол бид нар дараагийн зохицуулалтуудыг хийж болох байх гэж харж байна. Тэгэхээр хэдүүлээ өнөө өчигдрөөс өнөөдөр болтол 2, 3 жил дамжиж явсан хуулиа ганцхан ийм асуудлаас болоод үгүй ээ би хуулиа татна гэж байгаа бол 1 дүгээрт их л хайран байна.

Энхбаяр гишүүний тэр та нөгөө тусгай зөвшөөрөл олгох хөтөлбөр

бүртгүүлэх хоёрыг хооронд нь холиод байх юм. 17 дугаар хэсэг чинь тусгай зөвшөөрөл олгох дээр бүр Ба, Бэ-гүй зүйл заалтуудыг нь биччихсэн байж байгаа. Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм шинээр баталсан, хувийн тэтгэврийн сангийн дүрэм гэх мэтчилэн. Энэ нь болохоороо шинээр бүтээгдэхүүн буюу энд хөтөлбөр батлуулахад юу хэрэгтэй вэ гэдгийг заасан байж байгаа. Үүн дээр СЗХ одоо ч гэсэн яг л ийм байж байгаа. Тусгай журам гаргадаг, журмынхаа дагуу нэмэлт жишээлбэл активаар тооцоо гэх мэтчилэн шаардах бол эрх байгаа байх гэж бодож байна. Тэрүүнийг одоохондоо бид нар Ба, Бэ-гүй хуульд бас оруулж заахад бас жоохон хүндрэлтэй байгаад байна.

Таны хэлж байгаа Зөвшөөрлийн тухай хуулиар бол тусгай зөвшөөрөл авахтай холбоотой бүхий л шаардлагатай баримт бичгийг хуульд бол бид нар тусгах ёстой гэсэн. Тэр бол үүнд харин тусгаад явж байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ эхлээд энэ цоо шинэ харилцааг ямар ч байсан эхлүүлэе. Мэдээж үүнтэй холбоотойгоор зохицуулалтуудыг бол бас хийгээд явах нь зүйтэй. Гэхдээ хувийн тэтгэврийн сан дээр хууль гарангуут 100 хувь хүн болгон хувийн тэтгэврийн сантай болж чадахгүй байх. Энэ бол бас энэ чинь хүн болгон тэтгэвэртээ гарахдаа маш их хуримтлалтай гардаггүйтэй адилхан бас их амаргүй. Гэхдээ ялангуяа уул уурхайн салбарынхан, томоохон групп компаниуд бол ажилчдаа ялангуяа тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд үүнийг бол авч явах сонирхол бол байдаг юм билээ. Бид харин үүн дээр юу хийж өгсөн бэ гэхээр хэрвээ ажил, хэрвээ энэ та энэ хөрөнгө оруулалтын хувийн тэтгэврийн сангийн компани бол өөрөө өөрийнхөө харилцан хамааралтай этгээдэд хөрөнгө оруулалт хийхгүй, дээрээс нь нэмээд менежмент удирдлага зохион байгуулалтынх нь энэ зохицуулалтуудыг бол бид нар бас хийж өгсөн байж байгаа.

Энэ бол бас харьцангуй шинэ учраас манай СЗХ-н дээр бол нэмэлт ачаалал ирнэ. Бид нар бас Монголбанк зохицуулалтыг хийх үү, СЗХ зохицуулалтыг хийх үү гэж байгаад ихэнх улс оронд бол Санхүүгийн зохицуулалтын хороо нь үүнийг хийдэг. Тэгээд ийм байдлаар бас хийсэн байж байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. 50 гаруй санал хураалт байгаа. Тийм учраас санал хураалтаа жаахан шуурхайлъя хэдүүлээ. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн гарчиг болон 19.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж өөрчилж, 19.2 дахь хэсгийн “, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах

20.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

20.1.1.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

20.1.2.энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан маркетинг болон зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн;

20.1.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын таван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

20.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 20.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

20.4.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын таван өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

20.5.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг нэг сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын хоёр өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

20.6.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хүсэлтийг үндэслэн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

20.7.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд залруулаагүй тохиолдолд Хороо хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

20.8.Энэ хуулийн 17.12-т заасан шийдвэр гарсан бол хувийн нэмэлт

тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

20.9.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Ажлын хэсэг, Тамгын газар анхаармаар байна. Яах вэ нэг зарчим байгаа юм. Би нийтлэг ярих гэж байгаа юм. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэдэг бол юу гэсэн үг вэ гэхээр манай өнгөрсөн практик бол яагаад явчихсан бэ гэхээр хуулиар дандаа эрх шилжүүлээд аваад байсан юм. Тэрийг Засгийн газар, энийг сайд, энийг агентлагийн дарга, энийг нь ингэнэ, манай хуулиуд ийм ерөнхий хуулиуд их гаргадаг байсан. Би энийг нэг талаасаа залхуу хууль гэж хэлнэ. Залхуурчих уу. Нөгөө талаасаа мэдлэггүй учраас тэгээд түүгээрээ нэг нөхөр цаашаа энийг амьдрал баялаг ингээд зохицуулаарай гэдэг ийм хуулийн системчлэлээр явснаас болоод асуудал үүсчихсэн юм.

Яагаад тэр ардчилсан, эрх зүйт ёс төлөвшсөн улсуудын хуулиуд нь боть ботиор тийм зузаан хуулиуд байдаг вэ гэхээр нэн тодорхой байдаг байхгүй юу. Өөрөөр хэлбэл энэ тэр процессыг маш дэлгэрэнгүй байдлаар бичигддэг. Унишиж байгаа иргэдэд, байгууллагуудад ойлгомжтой, хөрөнгө оруулагчдад ойлгомжтой. Нөгөө талаараа тэр хөрөнгө оруулж байгаа хүнийг эрсдэлээс хамгаалж байгаа юм. Нэн тодорхой байна гэдэг бол хөрөнгө оруулагчийг эрсдэлээс хамгаалж байгаа юм. Тэр хуульд заагаагүй үндэслэлээр хэн нэгэн дарга, сайд, дараа нь журам тогтоогоод, хөрөнгө оруулагчийг дарамтлаад, шантаажлаад, тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгоод, цуцлаад, түдгэлзүүлээд байлгахгүй гэж хуулийг тодорхой бичдэг.

Одоо бид нар саяын уншсан 20.1 хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ гэж байгаа юм. Түдгэлзүүлэх гэж байгаа заалт. Үндэслэл нь 20.1.3.холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн. Энэ ямар хуулийг хэлээд байгаа юм бэ? Хууль тогтоомж гэдэг бол нэршил бол хуулиас гадна захиргааны хэм хэмжээ акт буюу Засаг дарга, Засгийн газар, агентлаг хорооноос баталсан хэм хэмжээний актуудыг нийлүүлээд бид хууль тогтоомж гэж ярьдаг. Тэгээд тэр даргын шийдвэрийг биелүүлээгүй зөрчил илэрвэл түдгэлзүүлнэ гэдэг бид хууль бичээд байгаад байгаа байхгүй юу даа.

2 дугаарт 29. Одоо санал хураалтын хамгийн сүүлд уншигдсан. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг хороо батална гэдэг бид хууль батлах гээд байна шүү дээ. Үгүй ээ, энэ хуулиараа зохицуулахгүй юм уу? Энэ харилцаагаа. Би ойлгохдоо энэ нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулах гээд бид хууль батлах гээд байна гэж суугаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт яг энэ хууль дээрээ энэ журмыг нь хороо батална гээд. Ингээд ийм нэг харсан нэг зохицуулаад байгаа юм шиг, энэ нөгөө талдаа энэ салбарт бизнес эрхлэх гэж байгаа сонирхогч, одоо эрхэлж байгаа хүмүүст тодорхой уншигдахгүй, энэний дараа дахиад нэг хороо нэг журам гаргах юм байна. Тэр нь юу гаргах юм бүү мэд, чөтгөр бүү мэд. Энэ анхны хэлэлцүүлгийг нь дахиж явуулбал яасан юм бэ? Нэг хууль санаачлагч нь ч гэсэн ийм санал гаргаад байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Булгантуяа сайд үг хэлье. Тэгээд санал хураалтыг явуулна.

Х.Булгантуяа: Энэ бол бүтээгдэхүүн гаргах байж байгаа юм. Ер нь бол яах вэ санхүүгийн зохицуулалттай

холбоотой хэдэн том хуулиуд л үйлчилж байгаа. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль гэх мэтчилэн. Тэгэхээр энэ холбогдох хуулиуд гэдэг нь ерөнхийдөө СЗХ-ны хүрээнд хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой, үнэт цаас худалдан авахтай холбоотой гэх мэтчилэн эдгээр хуулиудаар холбогдох хуулиуд гээд гарахаас өөр аргагүй л дээ. Дээрээс нь нэмээд журам гээд үнэнийг хэлэхэд нэлээн олон юмнуудыг бид нар журмаар бүх бараг л ихэнх хуулиудаар зохицуулагдаж л байгаа шүү дээ одоо ч гэсэн дээ. Саяхан хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хууль дээр гээд 30 гаруй журам. Одоо Нийгмийн даатгалын багц хууль гэхэд бараг 60 гаруй журам гэх мэтчилэн нарийн зохицуулалтуудыг бол журмаар батална.

Дээрээс нь нэмээд энэ нарийвчилсан журам нь болохоороо журмыг нь бид нар ХЗДХЯ-тай бүртгүүлээд бас ингээд явна гэсэн үг. Тэгэхээр одоо хэрвээ энийг бүгдээрэнг нь бичнэ гэвэл их л урт, маш их нарийн процессын л хууль болох гээд байдаг 1 дүгээрт.

2 дугаарт дээрээс нь бид санхүүгийн зах зээл бид нар бараг 1-ээс 2 жилийн дараа хэрхэн яаж өөрчлөгдөж, техник тоног төхөөрөмж нь, ИТ нь, тэгээд бүртгэл тооцоо нь хэрхэн яаж өөрчлөгддөгийг бид нар бас өнөөдөр урьдчилж харж бүгдээрэнг нь Ба, Бэ-гүй хуульчлахад бас их хэцүү салбар байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол магадгүй жишигээлбэл Эрүүгийн хуулиас бас арай өөр байх утгаараа Үнэт цаасны тухай хуулийг ч гэсэн Засгийн газраас өргөн барих гэж байгаа юм. Үүн дээр ч гэсэндээ холбогдох журмуудыг Санхүүгийн зохицуулах хороо гаргаад, ингээд батлуулаад явахаар, хэрэгжээд явахаар бас оруулж өгсөн байж байгаа.

Л.Мөнхбаатар: Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүдээ. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлье. Цэвэгдоржийн Туваан гишүүн дараа нь үг хэлье. Өнөрболор гишүүний микрофоныг өгөөрэй.

Д.Өнөрболор: Тийм. Тэгэхлээр бид нарын хувьд бол энэ Засгийн газар болон нэр бүхий 5 гишүүн өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр бол ажлын хэсэг ажиллаад бол оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд та хэд ч гэсэн бас хариуцлагын асуудал дээр ч гэсэн бас

ингээд ийм хариуцлагатай асуудал дээр зөрчилтэй байгаа юм байна шүү дээ. Учрал гишүүнээ ер нь ингээд иргэддээ нээлттэй, иргэдийгээ хамгаалъя гэсэн үнэхээр ийм хууль батлах гэж байгаа бол гишүүдийнхээ үгийг бол сонсох нь би зүйтэй байх гэж бодож байна. Бид нар ямар би ерөөсөө л эх үүсвэрийн асуудал яаж шийдэгдэх юм, энэний эргэлтийн менежмент нь яах юм, ямар үр дүн гарах юм, ямар цаг хугацаанд хэзээ эхлүүлэх юм бэ маш тодорхой асуултуудыг асуусан шүү дээ.

Тэгээд нэгнийгээ доромжлоод л ингээд л ингэж байр сууриа илэрхийлнэ гээд тэгэх юм бол хэн ч тэгж бол байр сууриа илэрхийлж болно. Тэгээд энэ би танай ажлын хэсгийг бол үнэхээр муу ажиллачихжээ гэж бол хэлээд байгаа асуудал бол байхгүй шүү дээ. Гэхдээ нэг зүйлийг та нар бас энэ дээр бол анхаарах хэрэгтэй байна Учрал гишүүнээ. Энэ хууль өөрөө 50 гаруй зүйл, заалттай оруулж ирж байгаа хууль. Тэгсэн хэр нь амьдрал дээр 50 гаруй зарчмын зөрүүтэй саналын ийм томъёололтой орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ хэр зэрэг ажилласан бэ гэдгийг эндээс та нар өөрсдөө дүгнэлтээ гаргана биз дээ. Тэгээд миний хувьд бол мэдэхгүй, ойлгохгүй байгаа асуудал бол огт байхгүй л гэж бол би бодож байна. Ер нь олон хүнийг ажлын байраар хангаж, энэ харилцаанд орж ирсэн орж байсан хүний хувиар бол энэ харилцааг бол дэндүү сайн мэдэх хүний хувиар ч гэсэн энэ хууль дээр тодорхой тодруулгыг би асуусан.

Тэгээд энэ хууль дээр бичигдсэн байгааг дагалдах энэ бичиг баримтууд дээр ингээд харьцуулаад үзэхээр үнэхээр тодруулахаас өөр аргагүй асуудал байж байгаа. Тэгээд шал өөр сайн дураараа юм уу эсвэл албан татвар төлөх ийм хэлбэр лүү оруулаад ингээд явчхаж байгаа нь бол тун харамсалтай байна. Гэхдээ яг энэ сангийн, энэ санг бол би бол байгуулж болно гэж бол бодож л байна. Гэхдээ яг таны яриад байгаа шиг ийм үр дүнд хүрэх баталгаа хаана байна вэ л гэж асуугаад

байгаа юм би. Яагаад одоогийн би ямар энэ нийгмийн даатгалын сангийн явуулж ирж байгаа үйл ажиллагаа, энэ менежмент, энэ үр дүн, үр шимийг нь энэ шударгаар татвар төлж байгаа, НДШ төлж байгаа иргэд ААН-ийн энэ үр шим, үр өгөөжөө хүртэж байгаа энэ нөхцөл байдлыг би ямар танд энд тайлбарлалтай нь биш дээ.

Тэтгэвэртээ хүртэл тийм ээ ингээд амьжиргаандаа хүрэлцэхгүй байгаа яг энэ цаг үед энэ зөв зохицуулалт уу? Энэний тодорхой хэсгийг нь юм уу, 100 хувь тийм ээ үүгээр эх үүсвэрийг нь бүрдүүлэх гээд байгаа юм уу? Ямар хэсгийг нь энэ эх үүсвэрээр бүрдүүлэх гээд байгаа юм бэ? Хэрэв бүрдүүлэх гэж байгаа бол та нарын энэ тавьж байгаа энэ асуудал чинь та нарын бодож, тийм ээ, тооцоолж байгаа тэр үр дүнд хүрэх эсэх нь баталгаатай байна уу гэдэг асуудал л байгаа шүү дээ. Тэгээд ингээд ярихаар хүнийг доромжлоод байх юм. Ер нь бол би бас энэ дээр санал хэлсэн шүү дээ. Баялгийн сангийн энэ хуультайгаа энэ ер нь үндсэндээ энэ асуудал чинь цуг орж ирэх юм байна. Тэгж байж, тэгж байж тийм биз дээ энэ чинь ингээд бүтэн том агуулгаараа бүрэн шийдэгдэх ийм хариуцлагатай хууль болох юм байна л гэж харагдаж байна.

Л.Мөнхбаатар: 18 цаг болсон байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг сунгаж хуралдуулъя. Өнөөдөр хэлэлцэх асуудлууд олон байгаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт, үг хэлье.

Ц.Туваан: Энэ Нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгаа. Тэгээд багц хууль дотор энэ нийтдээ 5 хууль байгаа. Тэгээд бид хэд бас энэ 4 хуулийг нь ингээд анхны хэлэлцүүлгийг нь энэ тэр хийгээд ингээд явчихсан. 5 дахь хууль нь орж ирж байна. Энэ бол бас аргагүй олон асуудал яригдаж байгаа. Энэ Монголд ерөөсөө урьд нь зохицуулж байгаагүй харилцаа, цоо шинэ харилцаа. Тэгээд дээрээс нь бид нар энэ хавар иргэддээ тайлангаа тавьж явахдаа

Нийгмийн даатгалын багц хуулийг бүх сонгогчдодоо танилцуулж явсан. Тэр үед бид нар бол иргэддээ олон жил ярьсан энэ олон давхаргат тэтгэврийн тогтолцоо руу орно гэж ингэж тайлбарлаж явсан. Иргэд бас таатай хүлээж авсан.

Юу гэхээр иргэдэд сонголт өгч байгаа юм. Энэ нөгөө суурь тэтгэврийн асуудлыг бид нар хөндөж оруулж ирж чадаагүй учраас энэ хагас хуримтлалын тогтолцоо руу бид нар орох ийм боломж нь хязгаарлагдчихлаа л даа энэ удаа. Тэгэхээр одоо бид нар энэ Хувийн тэтгэврийн тогтолцооны хуулиа гаргахгүй бол юун олон бэ, бүүр юун 2 давхаргат вэ ч болох гээд байна. Ерөөсөө сонголтгүй хуримтлалын, биш ээ хуваарилалтын тогтолцоогоороо л юм явах гэж байна. Тэгэхээр хэдүүлээ энэ цоо шинэ харилцааг бас дэмжээд, мэдээж шинэ учраас засах залруулах зүйлүүд байна. Ажлын хэсэг бас ажиллая. Даргаас бас гүйцээн боловсруулах чиглэл өгөгдөж байгаа ийм зүйлүүд байна. Тэгэхээр одоо хэдүүлээ ямар ч байсан энэ хуулиа гаргаад, зарим зүйлүүд дээр нь яг тэр бичилтийн, техникийн, нэр томъёоны энэ тэр гээд асуудлууд дээр анхааръя. Концепцын асуудал дээр бол бүгд ойлголцож байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ бол маш чухал хууль. Нэг хэлэлцүүлэг хоцорчихсон явж байгаа учраас энийг бас өнөөдөр Их Хурлын дэд дарга Мөнхбаатар дарга бас ойлгоод ингээд цаг сунгаад явж байх шиг байна гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энэ дэмжсэн 3, дэмжээгүй 3 л хэлэх боломжтой. Батжаргал гишүүн, Учрал гишүүн дэмжиж үг хэлэх юм уу? Булгантуяа сайд хэлэх юм уу? Энэ 3 хүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Тэгэхээр бид уламжлалт харилцаагаараа л яриад байна л даа. Нийгмийн даатгалын ерөнхий шимтгэлийнхээ асуудлыг нэмэлт тэтгэврийн тухай хуультайгаа хольж

ойлгоод ингээд асуудлыг үүсгээд байгаа нь л сонин байна нэг.

2 дугаарт энэ бол шинэ хууль. Үүн дээр бодохоор юмнууд бас бий. Бид ажлын хэсэг дотроо ч гэсэн бас байр суурь ерөнхий ойлголтынхоо түвшинд зарим зүйлүүд яг их тодорхой болж чадахгүй зөрүүтэй саналууд байгаа юм. Ганц нэг юман дээр бол. Монгол хүн ам цөөтэй. Тэгээд энэ дам дамаа нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэхэд эхний гараан дээр хэдий хэмжээний хүн хамрагдах вэ гэдэг асуудал өөрөө хязгаартай. Тийм учраас энэ сан дээр эхний удаа төвлөрөх хөрөнгө бас ямар хэмжээтэй байх вэ гэдэг асуудал өөрөө баримжаалахад бас нэлээн төвөгтэй. Тийм учраас дан ганц энэ тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхэлнэ гээд ингээд заачихаар зэрэг энэ ер нь яаж хөрөнгө нь босож ирж эргэлддэг бол. Өнөө хөрөнгө оруулалтын компаниараа хөрөнгөө арвижуулах хэлбэрээр зардал юмаа нөхөөд явна гэхээр зэрэг хөрөнгө оруулалтын компани маань ямар үр өгөөжтэй салбар луу хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг асуудал, буцаагаад бид өнөө хүний хөрөнгийг тодорхой арвижуулах учраас Монголбанкны бодлогын хүүгээс багагүйгээр баталгаат өгөөж өгнө гээд хэлчихсэн байгаа асуудал гээд ингээд бодохоор зэрэг бол бас ерөнхий түвшиндээ нэлээн нарийсгаж харахаар зүйлүүд бий. Олон талаас нь ярьж, ярьж энэ хувилбар дээр орж ирсэн.

Тэр нэг анх сан босгоход тэр аж ахуйн байгууллагуудын хувь хэмжээ энэ тэр яриад байгаа зүйл бол яг нарийндаа уг байгуулсан санг эрхэлж байгаа компани өөрөө үүнийгээ эдийн засгийн үр өгөөжийг нь дээшлүүлэх гээд эргэлтэд оруулаад явчихгүй, зайлигүй тэр хөрөнгө оруулалтын компаниар дамжуулж хөрөнгийнхөө үр өгөөжийг дээшлүүлэх үйл ажиллагаа эрхлэх учраас бас тусгайлсан тийм зохицуулалт хийх нь эхний гарааны үед бол илүүц юм байна гэдэг ерөнхий ийм л ойлголт, зарчим дээр явсан. Тийм учраас үүнийг тал бүрээсээ их

зөв ойлгож явах ёстой. Ямар ч байсан өнөөдөр анхны хэлэлцүүлгийг нь хийгээд, энэ олон яригдаж байгаа санаануудыг бас гүйцээн боловсруулах чиглэл дээр зарим заалтууд дээр нь аваад, ингээд илүү боловсронгуй болгоод авч явах ёстой гэж ингэж ойлгож байна.

Нөгөө 4 хууль бол угаасаа эцсийн хэлэлцүүлэг рүүгээ шилжчихсэн. Тэр 4-ийгөө баталчхаад, үүнийгээ араас нь залгуулаад энэ чуулганыхаа хугацаанд баталчихад бидэнд нэг их юу багц хууль дээр ямарваа нэгэн зөрчил гараад байх юм байхгүй, ийм л зүйл.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүн дэмжиж үг хэллээ. Ер нь энийг явуулъя л гэж байгаа юм байна шүү дээ, тийм үү. Та хэд заавал үг хэлэх шаардлага байна уу? Ням-Осорын Учрал гишүүн үг хэлье.

Н.Учрал: Тийм, энэ Их Хурлын гишүүд бид энэ Их Хурлын чуулганы индэр дээр энэ том хуулийн реформ хэлэлцүүлэг хийж байж нийгэмд ийм буруу ташаа ойлголт өгөөд 2 талцуулаад байгаа нь их зохимжгүй. Тийм учраас л би бас тэр Өнөрболор гишүүн түрүүн гол бас саналаа хэлсэн юм. Жишээ нь энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хууль бол иргэд маань харж байвал бас ойлгоорой. Энэ бол төрийн тэтгэврийн сан огт биш. Энэ хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо Монгол Улсад 2015, зургаан оноос хойш авхуулаад 5, 6 жилийн хугацаанд томоохон ААН байгууллагууд дэргэдээ хуримтлал үүсгээд явдаг ийм жишиг тогтжээ. Тэтгэврийн сан нэртэй ТББ-аар үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр томоохон үндэсний хэмжээний компаниуд ажилчдыгаа дэмжих чиглэлээр тэтгэврийн хуримтлал үүсгээд, ингээд тэр шимтгэлийг нь аваад, эргээд тэтгэвэрт гарахад нь төрөөс олгодог тэтгэврээс гадна хувийн нэмэлт тэтгэврийн сангаас нь нэмэлт тэтгэвэр олгодог ийм тогтолцоо руу шилжсэн. Энэ ч утгаараа энэ бол шинэ жишиг гэхээсээ илүүтэйгээр хуульгүй явж ирсэн л жишиг.

Тийм учраас бид нар хуультай болсноороо нэг талаасаа энэ томоохон ААН, мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыгаа дэмжинэ. Нөгөө талаасаа энэ хуримтлалаа шимтгэлээ төлөөд байгаа иргэдийгээ ажилтнуудыгаа хамгаалах ийм л зорилгоор энэ хууль бол тэртээ тэргүй гарах ёстой гэдэг утгаараа оруулж ирсэн. Тэгэхээр энэ бол нөгөө сая Баялгийн сан гэж ярихаар чинь энэ чинь огт хамаагүй зүйл шүү дээ. Хувийн нэмэлт тэтгэврийн хуульд энэ баялгийн сан, тэр төрөөс олгох мөнгө төгрөг огт падлий байхгүй, хамаагүй. Энэ бол цэвэр хувийн хэвшил өөрсдөө эсвэл мэргэжлийн хөрөнгө оруулагч нар нэгдээд СЗХ-нд хүсэлт гаргаад, тусгай зөвшөөрлөө аваад тэр ажилтнуудын тодорхой шимтгэлийг аваад, эргээд бүтээгдэхүүнээ санал болгоод, 20 жилийн дараа та ийм хэмжээний тэтгэвэртэй байна, нэрийн данс чинь ингэж өсөж байна гэдгийг нь харуулаад ингээд өгөөжийг нь тооцдог, цаад том агуулгаараа хөрөнгийн зах зээлээ дэмжих л ийм л агуулгатайгаар явж ирсэн.

Өнөөдөр Өнөрболор гишүүн ч бай бизнесийн салбараас гарч ирсэн, одоо ингээд л манай том ААН-үүд бол бүгдээрээ л ийм тэтгэврийн хуримтлалтай болчихлоо шүү дээ. Тэгэхээр энэ хууль бол бидэнтэй бидэнгүй тогтолцоо нь яваад ирчихсэн учраас иргэдийгээ хамгаалах, мэргэжлийн хөрөнгө оруулагч нараа хамгаалах чиглэл рүүгээ хамтраад батлах нь зөв гэдэг утгаараа л өнөөдөр хэлэлцэж байгаа учраас иргэд бас зөвөөр ойлгоорой. Энд бол төрийн ямар нэгэн мөнгө төгрөг босгох гээд, төрөөс ямар нэгэн мөнгө төгрөг дэмжүүлэх гээд, төсвөөс ингээд төгрөг авах гээд байгаа хууль огт биш учраас энэ дээр бол маргаад байх зүйл огт байхгүй.

Харин иргэдийгээ хамгаалах чиглэлээрээ нөгөө миний яриад байгаа тэр ядаж тэтгэврийн санг байгуулахад олон хөрөнгө оруулагч нарыг оруулах нөхцөлийг

бүрдүүлэх болохоороо 10-аа больё, яг Банкны хууль дээр орж ирсэн шиг 20 хувь нь, түүнээс дээш хөрөнгө оруулалтыг нэг хуулийн этгээд хийж болохгүй гэдэг заалтыг нь оруулаад өгчих. Банк чинь бол өөрөө хөрөнгө оруулдаг субъект биш. Харин тэтгэврийн сангийн гол үндсэн үүрэг бол өөрөө хөрөнгө оруулагч байхгүй юу. Тийм учраас тэр ажилтнуудын төлсөн шимтгэлийг буруу зүйлд оруулаад, хөрөнгө мөнгийг нь алдчих вий гэдэг эрсдэлээс сэргийлэхийн тулд олон мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыг оруулах нь, дээрээс нь олон хөрөнгө оруулагч нар орсон учраас бас тэд нар нэгдээд хөрөнгө оруулалт менежментийн зөв компанийг сонгосноороо зөв зүйлд хөрөнгө оруулаад, нөгөө банканд хүүлээд байгаа жилийн тэр хадгаламжийн хүүгээс илүү ашиг олох зөв зүйлд хөрөнгө оруулах нөхцөл бололцоог бүрдүүлэх рүү анхаараач. Энэ заалтыг хийгээд өгөөч л гэж би хэлж байгаа.

Тийм учраас бидний 5 гишүүний энэ санаачилсан хууль дээр гаргасан заалтуудаас алийг нь хасах, алийг нь нэмэх, алийг нь оруулсныг тодорхой хэлээгүйгээр дээр нэр бичээд ингээд хэлэлцүүлснээс болоод ийм ойлгомжгүй байдал үүссэн. Тэгэхээр цаашидаа энэ хуулийнхаа хэлэлцүүлэг дээр, энэ процедуртаа бас та нар маань анхаараач. Бусдаар бол Монгол Улс 95 онд шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоонд шилжсэн цаг үеэс хойш түүхэндээ анх удаа тэтгэврийн шинэчлэл нэг алхаж байгаа шүү. Би үүнд л баяртай байгаа. Тийм учраас ямар ч байсан нэг урагшаа алхъя гэдэг энэ санаачилгыг бол би салбарын сайдыг болоод энэ ажлын хэсгийн ахлагчийг, гишүүдийг дэмжиж байна. Тэгээд миний энэ саналуудыг тусгаж өгөөч.

Дээрээс нь надад яг энэ шигтгэсэн хувилбараа өгөөд, миний болон бидний 5 гишүүний хуулиас аль, аль заалт орсон, ороогүйг ойлгомжтой болгож өгөөч. Тэрнээс биш таны хуулийг ерөнхийд нь шийдчихсэн шүү дээ, 2-оос бусад нь

оруулчихсан гээд байхаар, тэгээд дээр нь миний нэр яваад байгаа болохоор би бас их гайхаж хүлээж авч байна. Тэгээд их тодорхой болгооч л гэдгийг хэлж байна. Агуулгын хувьд бол энэ алхмаа урагшлуулцаа, хамтдаа дэмжээд явъя.

Л.Мөнхбаатар: Энэ ирц байхгүй байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье. Санал хураалт явагдана. Нийтдээ 50 гаруй санал хураалт байгаа. Дараа нь Нийгмийн даатгалын багц хуулиудыг бас үргэлжлүүлэн хэлэлцэж дуусгана өнөөдөр. Тийм учраас гишүүд танхимдаа орж ирье. Хаврын чуулган хаагдах болж байгаагаар холбогдуулан хаврын чуулганы хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудыг бүрэн хэлэлцэж дуусаж байж чуулганыг хаана.

Нөгөөтээгүүр энэ долоо хоногт хэлэлцэх асуудал хэрвээ хэлэлцэж амжихгүй бол хагас сайн өдөр ээлжит бус чуулганыг зарлаж хуралдуулах болно гэдгийг бас гишүүдэд сануулан хэлье. Нөгөөтээгүүр энэ харилцаа бол өөрөө шинэ харилцаа байгаа шүү дээ. Тийм учраас яах вэ зохицуулалтуудын хувьд бол мэдээж сайтар ярилцах шаардлагууд бол байсан байх. Гэхдээ анхны хэлэлцүүлгийг бол Байнгын хороо дээрээ олон талаас нь үзэж, 2 хуулийг нэгтгэж байгаа. 2 санаачлагчийн аль, аль саналуудыг нь нэгтгээд ингэж оруулж ирэх ёстой. Энэ тал дээр бол та бүхэн бас цаашидаа бас анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлъя. МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн, дэд дарга Жигжидийн Батжаргал, дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг өөрөө хаана байна вэ? АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл нар ирцээ бүрдүүлъя. Булгантуяа гишүүн үг хэлье. Булгантуяа гишүүн үг хэлсний дараа санал хураалтыг явуулна.

Х.Булгантуяа: Гишүүдээ би бас Учрал гишүүнд тайлбар хэлэх нь зүйтэй байх. Энэ нөгөө 2 жилийн өмнө өргөн барьсан хууль учраас Зөвшөөрлийн тухай

хууль, цахимжуулалттай холбоотой Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тэгээд Хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой гээд ингээд бусад хуулиудтай бид нар уялдуулах 1 дүгээрт болсон. Зөвхөн Зөвшөөрлийн тухай хуультай холбоотойгоор 33 ийм санал орж ирж байгаа юм. Тэгэхээр ийм нөгөө бусад хуулиудтай уялдуулахтай холбоотойгоор сая түрүүн бас хэлээд байна. Бараг 50 гаруй санал байна гээд.

Дээрээс нь нэмээд 2 хуулийг нэгтгэж бичиж байгаа учраас ийм олон зарчмын зөрүүтэй санал гарахаас өөр аргагүй байгаад байгаа юм. Энэ бол бид нар бас нэг цоо шинэ харилцаа яах вэ олон нийтийн өмнө хэдүүлээ маргаж байгаа ч гэсэндээ иргэд бол үүнээс маш их хүлээлттэй байгаа шүү, энэ харилцаа дээр. Тэгээд бид нар хэрвээ энэ удаа зохицуулалтыг хийж өгөхгүй бол бид нарын зохицуулалттай, зохицуулалтгүй яваад, харин иргэдийн эрх ашиг хохирчих гээд байгаа ийм нөхцөл байдал үүсээд байгаа учраас өнөөдөр та бүхэн маань чуулгандаа идэвхтэй оролцоод, санал хураалтаа явуулж өгөөч л гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явъя, явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Энхбаяр гишүүн, ажлын хэсгийн гишүүн Туваан гишүүн суудалдаа сууя. Санал хураалт гишүүдээ. Улсын Их Хурлын эрхэм гишүүн Бейсен горимын санал гаргая.

Б.Бейсен: Миний төхөөрөмж ажиллаагүй учраас дахин санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Буланы Бейсен гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалтыг явуулъя 20. Саяын саналын томъёоллыг уншиж танилцуулсан үндсэн санал хураалтыг

явуулъя. Санал хураалт. Сүхбаатар гишүүн саналаа өгөөрэй. Наранбаатар гишүүн горимын санал гаргах уу та? Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Төхөөрөмж ажиллаагүй учраас хүчингүй болгож өгнө үү саяын санал хураалтыг.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Энхтүвшин гишүүн горимын санал гаръя. Гишүүд саналаа анхааралтай өгөөрэй. Санал унаад байна шүү.

Т.Энхтүвшин: Сая кноп ажилласангүй даргаа. Тийм учраас санал хураалтыг дахиж явуулж өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 56,4 хувиар санал дэмжигдлээ. 20. Одоо санал хураалтыг үндсэн санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.3.4 дэх заалт, 21.5, 21.6, 21.7 дахь хэсэг тус тус нэмэх:

“21.3.4.гишүүдийн хадгалагдсан эрхийн бүх төлбөрийг бүрэн барагдуулах хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч өөрийн хөрөнгөөр барагдуулах тухай хүсэлтийг санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлж, энэ тухай бүх гишүүдэд мэдэгдэх;

21.5.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч

нь энэ хуулийн 21.3-д заасан арга хэмжээ авна.

21.6.Урт хугацааны даатгагчийн эрхэлж буй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг хассан тохиолдолд энэ хуулийн 22.1-22.11-д заасан арга хэмжээг авна.

21.7.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассаны дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг Хороо батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Би бол ер нь энэ тэтгэврийн тогтолцоог, реформыг хийхийг бол улайран дэмжигч хүн байгаа. Тэрийгээ ер нь олон удаа илэрхийлсэн. Энэ тэтгэврийн реформыг оруулж ирж байгаа, оруулж ирэхийг бол байнга дэмжиж ирсэн. Би Ариунзаяа сайдыг оруулж ирэхэд дэмжиж байсан, Аюурсайхан сайдыг оруулж ирэхэд дэмжиж байсан, Булгантуяа сайдыг энэ асуудлыг явуулахад дэмжиж байсан, Учрал сайдыг явуулахад дэмжиж байсан. Би бүлэг дээрээ бол ер нь олон удаа энийг дэмждэг. Би гол нь нөгөө юу ярих гээд байгаа вэ гэхээр энэ чинь бид хууль.

2001 онд Улсын Их Хурал дахь тухайн үеийн МАХН-ын бүлгийн хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан юм 22 жилийн өмнө. Тэр үед Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль батлагдсан юм. Тэгээд тухайн үед би бүлгийн зөвлөхийн хувьд энэ хууль дээр пирамид буюу шатлан дэвжих луйверын схем хэдэн жилийн дараа хийгдэх эрсдэлтэй байна. Энэ эрсдэлийг нь хаасан зохицуулалт байхгүй байна гэдэг дүгнэлт өгч байсан юм. Хадгаламж зээлийн хоршоод уг хууль батлагдсанаас 5 жилийн дараа дампуурсан юм, 60 мянган хүн хохирсон. Тэгэхээр хууль гэдэг маань өөрөө бас их

тийм эрсдэлийг хааж бөглөсөн байдлаар гарахгүй бол бараг гараагүй нь дээр байдаг юм. Гараагүй нь дээр байдаг.

Тэтгэвэр дээр тийм учраас би санаа зовоод, дараа нь нөгөө ийм эрсдэл гарчих вий гэдэг дээр л санаа зовж тодорхой саналууд дээр хэлээд байгаа юм. Дэгийн хуульд зааснаар анхны хэлэлцүүлэг дээр хийгдчихвэл эцсийн хэлэлцүүлэг дээр энийг залруулах нөгөө дэгийн боломж байдаггүй учраас үг хэлээд байгаа шүү гэдгийг ойлгож хүлээж аваасай гэж хүсэж байна. Тэрнээс би энэ шинэчлэлийн реформыг бол дэмжиж байгаа. Одоо санал хураах гэж байгаа 21.7 дээр хувийн тэтгэврийн сан урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассаны дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг хороо батална гэж байгаа юм. Энэний дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журам гэж ер нь ямар журам байна вэ? Ийм ерөнхий. Би одоо ийм хуулийн ерөөсөө техник мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Хууль зүйн яам бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг бүртгэдэг улсын хэмжээнд. Ийм энэний дараа хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг батална гэсэн ийм журам би хуульд бичиж байсныг мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Ямар журам юм бүү мэдэхгүй.

Энэ хассаны дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагаага энэ хуульд бичдэггүй юм уу л гэж яриад байгаа шүү дээ. Ийм техник ерөөсөө мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Би тэгээд энэ, энэ нарийн бичиг нь ямар хүн байсан юм бол энэ? Энэ бусад гэдэг үгэнд аягүй их дуртай, холбогдох гэдэг үгэнд аягүй их дуртай. Тэгээд бусад юмыг нь журмаар зохицуулна гэж ерөөсөө бичих аягүй их дуртай хүн л ингээд биччихсэн. Би энийг нь л яриад байгаа шүү. Тэрнээс биш би дэмжинэ. Тэгэхдээ би тодорхой ийм асуудлууд дээр протоколд хэлж явахаас

өөр арга алга. Яагаад гэхээр энэ эхний хэлэлцүүлэг.

Л.Мөнхбаатар: Дэгийн хуулиа аваад ир. Энэ хуулийн хэлэлцүүлгийг бас нухацтай явуулах хэрэгтэй, шаардлага байгаа. Шинэ харилцаа, тэр дотроо 2 хуулийг нэгтгэсэн учраас бас олон талаас нь ярих шаардлагууд бол байгаа. Ийм учраас энэ хуулийн санал хураалтыг түр хугацаагаар хойшлуулна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг дараа явуулахаар боллоо. Дараагийн асуудлууддаа орёё. Одоо дараагийн санал хураалтаа явуулъя. Дараагийнхаа асуудалд орёё. Энхбаяр гишүүний саналууд, Учрал гишүүн, ер нь Их Хурлын гишүүдийн хэлсэн саналуудыг бас нэгтгээд энэ асуудлаараа тайлбарлаарай.

18.37 цаг

Найм.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд орно. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах юм бэ? Оюунчимэг, МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Эдгээр хуулиуд бол эцсийн хэлэлцүүлэг учраас зарчмын зөрүүтэй 1, 1 л саналтай байгаад байгаа юм. Тийм учраас шуурхай явна. Мөнхөөгийн Оюунчимэг таныг индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулийн төслийг хэлэлцэхдээ үйлдвэрчний эвлэлийн саналыг хэрхэн тусгасан, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн эцэг, эхийн нийгмийн хамгааллын талаар болон тэтгэвэр өвлөгдөх заалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа малчны тодорхойлолт болон малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс даах, төрөөс даах зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Туваан тэтгэвэрт гарах насны сонголтын талаар асуулт асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй нэг санал, анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул мөн зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй

нэг саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай мөн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016, 17, 18, 19, 20, 21, 22, 23 оны төсвийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай мөн ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа

асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Амарсайханы Хишигбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баасангийн Батжаргал, НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэнд-Аюушийн Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Ренчиндорж, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын дарга Бумчанагийн Даваахуу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Болдбаатарын Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Сүхбаатарын Орхон, судлаач, зөвлөх Гандангийн Ганчимэг нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. 2 санал байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын санал зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн саналууд байна.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал. 1.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

29.7.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд

заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ. Санал гаргасан Нийгмийн бодлогын Байнгын хороо. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал. Төслийн 35 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “Үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх. Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

18.46 цаг

Ес.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Чинзориг манай улсад хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 20 гаруй хувь нь малчид байдаг. Малчдын орлого тогтмол бус, нийгмийн даатгалын хамрагдалт бага, үүнээс шалтгаалж өндөр насны тэтгэвэр тогтоолгох нь бага байдаг тул малчдын нийгмийн хамгааллыг дэмжих, нийгмийн даатгалын хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, цаашидаа тогтмол төлж хэвшүүлэх зорилгоор Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тодорхой хугацаанд малчдыг дэмжих зохицуулалтыг тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Х.Ганхуяг нар малчдыг дэмжих нь Монгол төрийн бодлого мөн боловч нийгмийн нэг бүлгийг тусгайлан дэмжих нь ялгаварлан гадуурхах нөхцөл үүсэхийг анхаарах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүй, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон, ахмад настан төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх

Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг өмнө нь байгаа ажлын хэсэг мөн адил оролцож байгаа гэдгийг хэлье. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. Энэ санал хураалт байхгүй. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

18.51 цаг

Арав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6

дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал гаргаагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн зарчмын зөрүүтэй нэг саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд мөн адил байгаа. Байнгын

хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалтыг явуулъя. Гишүүд суудалдаа сууя, байраа эзэлье, гишүүд саналаа өгнө. Суудалдаа суу, суудалдаа сууж саналаа өгье. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн сууж саналаа өгнө. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бол энд хамаарахгүй гэдгийг бас хэлье. Ганбаатар гишүүн бол заавал суухгүйгээр ч саналаа өгч болно. Бусад нь бол суух нь зүйтэй. Энхбаярын Батиугар гишүүн сууя, сууж саналаа өгье.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгаж байгаа санал байна. 1.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Анужин дарга нэгдсэн хэлэлцүүлэг хийх нь байна.

18.55 цаг

Арван нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Ганбаатар: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал гаргаагүй.

Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн

анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй нэг санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хууль хүчингүй болсонд тооцож тооцох тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд мөн адил байгаа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг танилцуулъя. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай

хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал.

1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсаар өөрчлөн найруулах.

“14.1.Даатгуулагчийн, даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагч тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.” Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжжүүлээ.

19.00 цаг

Арван хоёр.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орно. БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Байнгын хорооноос боловсруулсан БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцсон тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн 1991 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгааг хүчингүй болсонд тооцож, тус хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, тэтгэмжийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужингаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цэвэгдоржийн Туваан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Ер нь 1992 онд батлагдсан Үндсэн хуулиас өмнө батлагдсан хуулиудаас 9 хууль одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Эдгээр хуулиудыг 1992 онд батлагдсан Үндсэн хуульд нийцүүлэх учиртай. Энэ бол Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд бас заагдсан байгаа. Тийм учраас энэ хуулийн эдгээр үлдэж байгаа 8 хуулийг шинэ Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх буюу хүчингүй болгох асуудлыг Хууль зүйн байнгын хороо дахин авч үзэж, ойрын хугацаанд оруулж ирэх нь зүйтэй шүү гэдгийг хэлье.

Байнгын хороо БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй

болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хүчингүй болгож байгаа юм. Одоо хэд хэдэн хууль байгаа энэ. БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль, Эрх олгох тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль гээд нийтдээ 9 хууль байгаад байгаа юм. Эдгээрийг бол бүгдийг нь Үндсэн хуульд нийцүүлэх ийм шаардлага байгаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүдээ. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд илжжүүлээ.

19.05 цаг

Арван гурав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 22 гишүүн бид санаачлан Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн ба өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Газрын тухай хуульд бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулахтай холбоотой дараах хууль зүйн болон практик үндэслэл шаардлага байгаа юм. Сүүлийн 20 гаруй жилийн туршид бэлчээрийг ашиглах.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Гишүүдэд суугаарай.

Д.Тогтохсүрэн: Хамгаалахтай холбоотой эрх зүйн харилцааг сайжруулах шаардлагатай байгаа талаар ярьж, хэлэлцэж 4 удаа хуулийн төслийг боловсруулсан боловч өнөөг хүртэл шийдэлд хүрээгүй юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуульд бэлчээрийг нийтээр дундаа ашиглахаар зохицуулсан нь эмх замбараагүй сорчлон ашиглах, даацыг хэтрүүлэх зэргээр улирлын хуваарьтай сэлгээж ашиглах уламжлалыг алдагдуулсан, талхал, доройтол, цөлжилт үүсэхэд хүргэсэн ч үүний төлөө хэн ч хариуцлага хүлээдэггүй.

Төрийн өмчийн бэлчээр дээр хувийн өмчийн мал аж ахуй эрхлэх харилцааны эрх зүйн хэм хэмжээг нарийвчлан тогтоохгүй явсаар бид өдий хүрсэн. 1990 оны өмч хувьчлалаар малыг хувьд шилжүүлсэн ч, үйлдвэрлэл явуулах талбар болсон бэлчээрийн харилцааг эрх зүйн хүрээнд нарийвчлан оновчтой шийдвэрлэж чадаагүйгээс хяналтгүй, үнэгүй бэлчээрт малчид малын тоо хэт их өсгөх сонирхол давамгайлж хөрөнгө оруулалт хийх сэдэлгүй болсон юм. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайланд дурдсанаар манай улсын нийт бэлчээрийн 65 хувьд ургамлын бүтэц бүрэлдэхүүн харилцан адилгүй түвшинд өөрчлөгдөж, үүний 13 хувь нь цөлжсөн, 29 хувь нь хүчтэй доройтсон байна.

Гэхдээ бэлчээр ашиглалтын ачааллын өнөөгийн горимыг цаг алдалгүйгээр өөрчилж, даацад тохируулж чадвал нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаар сэргэх боломжтой гэж судлаачид дүгнэж байна. Иймд энэхүү боломжийг алдахгүйн тулд бэлчээрийн эрх зүйн зохицуулалтыг яаралтай бүрдүүлэх хэрэгтэй тул Газрын тухай хуульд бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулахтай холбогдох харилцааны зохицуулалтыг хуульчлан зохицуулах нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага зайлиггүй бий болоод байгаа юм.

Хуулийн төсөлд иргэдийн саналыг сонсох зорилгоор нийт улс орон даяар 5 бүс нутагт Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө танилцуулж, малчид, мал бүхий иргэд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, орон нутгийн газрын болон бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, аймаг, сум, багийн Засаг дарга нарыг оролцуулан мянга гаруй иргэдээс санал авлаа. Хэлэлцүүлгийн үед явуулсан санал асуулгын дүнгээс гарахад нийт оролцогчдын 97,7 хувь нь бэлчээр доройтож байгаатай санал бүрэн нийлсэн байна. Өнөөгийн бэлчээрийн харилцааны эрх зүйн орчныг өөрчлөх шаардлага байна уу гэсэн асуудалд оролцогчдын 90,6 хувь нь заавал өөрчлөх хэрэгтэй гэж хариулжээ. Бэлчээр ашиглалтын хэлбэрийн хувьд нийт оролцогчдын 46 хувь нь гэрээгээр ашиглах зөв гэсэн санал өгсөн бол 27 хувь нь малын тоо толгойн албан татварын зохицуулалт чухал гэсэн санал өгсөн байна.

Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын нэг болох мал аж ахуйн үндэсний үнэт зүйлс, хөгжлийн алсын хараа, чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, дотоодын боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангалт, экспортыг нэмэгдүүлэх зорилтыг

хэрэгжилтийг хангах үндсэн суурь болсон бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах харилцааг тогтвортой үр өгөөжтэй болгох асуудал чухал гэж үзэж байгаа юм.

Энэ хуулийн төсөл нь 4 зүйлтэй бөгөөд төсөлд хуулийн хуульд нэмж хэрэглэгдэх нэр томъёог нэмж, бэлчээрийн ангиллыг тогтоож, тэдгээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, эдгээр харилцаанд оролцогчдын оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, тогтоох харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл баталснаар дараах эерэг үр дагаврууд гарна гэж үзэж байна. Үүнд, 1.Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал зан заншилд суурилсан оролцогч талуудын эрх, үүрэг хариуцлагыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин бүрдэнэ. Бэлчээрийг нийтээр ашиглах хариуцлага хүлээдэггүй байдлыг зогсоож, бэлчээрт өөриймсөг хандах, даацад тохируулан хуваарьтай сэлгээтэйгээр зохистой ашиглах, малын тоог өсгөх биш ашиг шим, чанарыг эрхэмлэх хүч, хөрөнгө зарж хамгаалах сэтгэлгээ төлөвшин, эдийн засгийн эргэлтэд оруулж борлуулах боломж бүрдэнэ.

Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах ажлыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж, бэлчээрийн талхлал доройтол, цөлжилтийг бууруулж чадна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн урт хугацаанд тогтвортой эрхлэх, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал хангах нөхцөл бүрдэнэ. Малчид хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэхэд түшиц болно гэж үзэж байна. Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хуулиудыг дагалдан хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иймд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Батжаргал нарын 20 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд малын тоо хурдацтай нэмэгдэж, нүүдлийн мал аж ахуйг эрхлэх явцад хүрээлэн буй орчин, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх асуудал орхигдож, нүүдлийн мал аж ахуйн уламжлал заншлын хэм хэмжээний нөлөө буурч байна. Иймд бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах,

доройтлоос сэргийлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар хууль санаачлагчид уг хуулийн төслүүдийг боловсруулсан байна. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлогт тохируулан бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд тулгуурлан ашиглалт хамгаалалтыг сайжруулах, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах боломж бүрдэнэ гэж үзэн хууль санаачлагчид төслийг боловсруулан *D.parliament.mn* цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан төслийг дэмжиж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ бэлчээрийн асуудал зөвхөн малчдын бус аймаг, сум, хот суурин төдийгүй Монгол Улсын тулгамдсан асуудал болж байгааг тэмдэглээд, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортод төрийн бодлого дэмжлэг шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал махны экспортыг тогтвортой явуулах, бэлчээрийн даац, малын тоо толгойг зүй зохистой болгох, бэлчээрийг хамгаалах зөв менежмент явуулах, хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох зэрэг асуудлыг төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун хуулийн төслийн зохицуулалт хэт ерөнхий байгааг дурдаад худаг, ус цэг гаргах зэрэг зарим тулгамдсан асуудлыг хэлэлцүүлгийн явцад нарийвчлан зохицуулах шаардлагатай талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 57,1 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа нь нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дүгнэлт санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн, Ганибал гишүүн юм уу? Ганибал гишүүнээр тасаллаа. Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Хуулийг бол дэмжиж байгаа юм. Би зүгээр манай Энхбаяр гишүүн, Чинбүрэн гишүүн, Бат-Амгалан гишүүн, Саранчимэг гишүүн бид 5 нийлээд бас нэг Газрын тухай хуульд ялангуяа нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад байгаа газрын асуудлуудыг шийдэхээр хууль өргөн бариад бараг 2, 3 жил болж байна. Энэ газрын асуудлыг ер нь шийдэхгүйгээр иргэдийн бухимдлыг бид нар бол бууруулна гэж 1 дүгээрт байхгүй юм байна лээ. Манай Баянзүрх дүүрэг жишигээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн хувьд хамгийн хүндхэн дүүргүүдийн нэг. Сургуулийг нь барих, цэцэрлэгийг нь барих төсөв санхүүжилтийг нь шийдэж өгч болоод байхад хэцүү нь газар чөлөөлөлт, газрын асуудал байгаад байгаа юм. Тэгээд хамгийн гол нь бид нарыг янз янзаар их бичсэн. Хүмүүст энд тэнд газар өгөх гээд байна гэж. Угтаа бол бид нар хамгийн

чухал нь энэ төрийн байгууллагуудын газруудыг өөрснөө дур мэдээд зарчихдаг, өөр байдлаар нийтийн орон сууц байдлаар эсхүл өөр байдлаар ашиглуулчихдаг үүнийг больё. Энэ төрийн байгууллагуудын газрыг хамгийн түрүүнд төр өөрөө мэдээд эндээ сургуулиа барих уу, цэцэрлэгээ барих уу, нэн шаардлагатай дэд бүтцээ барих уу гэдгээ шийддэг байя.

Дээрээс нь нийтийн эзэмшлийн энэ дундын бас энэ газрууд хэний ч өмч биш ингээд үлдчихдэг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн эрх мэдэлтэй нь тухайн үед энэ газрыг нь өгвөл өгчихдөг, хүүхдийн тоглох газар ч байхгүй, сургууль, цэцэрлэг ч байхгүй үлдчихдэг. Энэ бүгдийг зохицуулъя гээд ялангуяа энэ нийслэл Улаанбаатар хотод бол тулгамдсан энэ газрын асуудлуудыг өргөн барьсан. Газрын багц хуулийг оруулахад нэгтгэж хэлэлцэнэ гэж хэлээд өнөөдрийг болтол байхгүй. Тэгэхээр одоо бэлчээрийн асуудлыг хөндөж ярьж байгаа нь сайн. Тэгэхдээ энэ Улаанбаатар хотын газрын асуудлыг ярихгүй юм уу? Энэ төрийн байгууллагуудын дарга нар өөрсдөө дур мэдэн газар олгодгоо хэвээрээ байх юм уу? Газрынх нь 3 дугаар эмнэлэг гээд тэгж байхад урд талынх нь бараг үүд хаалга нь харагдахгүй болтол газар олголт хийчихсэн байгаа энэ юмнуудыг ингээд үргэлжлүүлээд яваад байх юм уу?

Газрын багц хуулиа өргөн барьчхаад буцаад татаад авчихсан энэ хэзээ бас орж ирэх юм бэ? Нэг ийм хэдэн хууль санаачлагч Тогтохсүрэн даргаас асуулт гэхээсээ илүүтэйгээр тэгээд ийм хэдэн бас санал байна. Тэгээд хөдөө орон нутагт иргэдэд бэлчээрийн асуудал хүнд байгаатай адилхан хотод иргэдэд бас нэг газрын асуудал маш хүнд байна шүү. Тэгээд үүнийгээ бас энэ хуулийг хэрвээ хэлэлцэх гэж байгаа бол хамтад нь байдаг юм уу хэлэлцмээр байна гэдэг ийм саналыг дэвшүүлэх гэсэн юм. Хууль санаачлагчийн зүгээс.

Л.Мөнхбаатар: Хариулах уу? Ер нь санал хэлж байна шүү дээ тийм ээ?

Хууль санаачлагч Дуламдоржийн Тогтохсүрэн товч хариулъя.

Д.Тогтохсүрэн: Өмнө нь санаачлаад, өмнө нь санаачлаад Улсын Их Хуралд хэлэлцэх эсэх нь шийдээд, одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр байгаа тийм хууль бол Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт байгаа бол тэр хууль бол манай хуультай хамтатгаад нэг ажлын хэсэг гаргаад, анхны хэлэлцүүлэг нь хамтарч хийгээд явах бүрэн бололцоотой. Ганцхан хууль санаачлагчид хоорондоо санал нэгдэх ёстой гэж бодож байна.

Засгийн газар өнгөрсөн хавар Газрын тухай хуулийн нэмэлт юу шинэчилсэн найруулгыг өргөн барьсан. Тэгээд 3 сард буцаагаад татаад авчихсан. Одоо шинэчилж боловсруулаад өргөн барих гэж байгаа гэж байгаа. Би намраас орж ирэх болов уу гэж бодож байна. Тэр Газрын тухай орж ирсэн хууль дээр гол нь энэ бэлчээрийн асуудлыг огт зохицуулалт байхгүй байсан юм. Тийм учраас манай хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд бол хамгийн тулгамдсан том асуудал нөгөө бэлчээр учраас бэлчээрийн зохицуулалтыг хиймээр байна гэж ингээж үзээд ингээд бидний 20 гаруй гишүүд санал нэгдээд, энэ хуулийн төслийг боловсруулж, бэлтгээд өнөөдөр Их Хуралд оруулж ирж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Энхбаяр дарга нэрээ татлаа. Асуулт адилхан гэж байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн товч асууя.

Ц.Сандаг-Очир: Товч асуухгүй ээ, минутдаа асууна. Энэ хууль батлагдсанаар ер нь яг ямар үр дүн гарна гэж та бүхэн тооцоолж байгаа вэ? Та бүхний яг хүсээж байгаа үр дүнгээр энэ бэлчээр ашиглалтад зөв зохистой ашиглах, малын тоо толгойгоо малчид маань бас бэлчээрийн даацтай нийцүүлж ингээж зохицуулах тэр бололцоо боломж хэр үүсэхээр байна вэ? Өнөөдөр бол бэлчээрийн асуудлаас болж үнэхээр

танай манайдаа хүрч, чи би-дээ хүрч, барилцаж авалцаж зодолдох асуудал бол наад захын асуудал болсон шүү дээ. Тэгэхээр энэ чинь одоо яг ингээд үе удмаараа олон жил нутагшчихсан, малаа хариулдаг энэ малчид, малчдад давуу байдал үүсэхээр байна уу? Нүүдэл отор хийж байгаа малчдад одоо яах юм бэ? Ган гачгаас болоод зуд түрхнаас болоод арга ядарсандаа л энэ баруун аймгууд чинь бэлчээргүй болоод, даац нь хэтрээд ингээд хүндэрсэн учраас л ингээд л бэлчээр хайгаад л, өвс хайгаад л ингээд л явж байгаа шүү дээ.

Тэгээд ийм нүүдэл суудал хийж яваа малчдыг ер нь нөгөө нөхдүүд нь бид нар ингээд давуу эрхтэй ашиглаж байгаа энэ бэлчээрийг, танайхыг буулгахгүй гээд байвал харин ч эсрэгээрээ бараг малчдын дунд бөөн асуудал болгож бараг ийм асуудал үүсэх вий дээ. Энийг яаж зохицуулах юм бэ? Энийг хэн зохицуулах юм бэ? Багийн дарга нь юм уу, сумын Засаг дарга нь юм уу, байгаль орчны байцаагч юм уу, хөдөө аж ахуйн мэргэжилтэн юм уу, хэнд яг, хэрхэн яаж үүрэгжүүлж байгаа юм, үүрэгжүүлж байгаа юм бэ?

Нөгөө талаар энэ хууль хэрэгжээд эхлэхээр цаашидаа бас малын тоо толгойг бас бэлчээрийн даацтай нийцүүлж цөөрүүлэх асуудлыг л ярих гээд байна л даа. Нөгөө талаар мэдээж бэлчээрээ ингээд хашихгүй, хашиж чадахгүй. Тийм учраас нөгөө нэг хариуцуулсан амны голынхны газар орон нутаг руу мал нь бэлчээрээрээ яваад орчихвол яах юм бэ? Танай мал манай газар луу орчихлоо гээд ингээд бас бөөн хэрүүлийн алим болох юм биш биз дээ. Энийг яаж зохицуулах юм гээд ер нь бол энэ газрын асуудал чинь маш нарийн шүү дээ хөдөө гадаа бол улсын үндэс. Одоохондоо бол хараахан өмчилчхөөгүй байж байна. Өмчилчхөөгүй байгаа учраас өвөлжөө, хаваржаагаа хэдийгээр өмчилсөн ч гэсэн бэлчээрээ бол өмчлөөгүй байгаа учраас хэрүүл маргаантай ч гэсэн байж л байна.

Отрын бүс нутагт яах юм бэ? Хэрлэн Баян-Улаан руу бүх аймгийн малчид орж ирж байна. Энийг тухайн баг гэдэг юм уу, Захирагчийн газраас яаж зохицуулах юм бэ? Энэ чинь арга ядахдаа л туугдаад л ингээд л бэлчээр өвс хараад л ингээд ирж байна шүү дээ. Гэтэл нөгөө нутаг орных нь малчид давуу эрхтэйгээр манайхны бэлчээр нутаг юм гээд ингээд суучхаад хөдлөхгүй байвал яах вэ? Хөдлөхгүй байвал яах вэ?

Нөгөө талаар малчид чинь уг нь бол жилийн 4 улиралдаа 4 нүүж байх ёстой. Гэтэл одоо бол үндсэндээ бараг хоёрхон л нүүдэг болсон. Өвөлжөөндөө нэг нүүдэг, хаваржаалаад хаваржаан дээрээ зусдаг, намарждаг болсон. Энэ нь өөрөө эргээд бэлчээрийн даац талхалж, бэлчээрийн өвс ургамлын гаралтад сөргөөр нөлөөлж байгаа юм. Сөргөөр нөлөөлж байгаа юм. Нүүхгүй байвал яах юм, ямар хариуцлагын арга хэмжээ байгаа юм бэ? Тухайн малчдыг хариуцуулчихсан, танайх зусландаа байх ёстой, намаржаалах ёстой, хаваржаалах ёстой, хаваржаалахгүй байвал яах юм бэ, өвөлжөөнөөсөө буухгүй байвал яах юм бэ, тэр зуслангаасаа нүүхгүй байвал яах юм бэ, ямар арга хэмжээ авах юм бэ? Энэ үүргийг нь хэнд хариуцуулсан юм гээд маш олон асуудлууд гарч ирэх юм байна. Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл санаачлагч Дуламдоржийн Тогтохсүрэн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Сандаг-Очир гишүүн бол маш чухал юм асууж байна. Яг л нөгөө өнөөдөр байгаа тулгамдсан асуудал. Би нэг маш товчхон хариулъя. Бэлчээрийг 5 ангилж байгаа. Улирлын бэлчээр нөгөө хавар, зун, намар, өвөл, хаврын улирлын бэлчээр. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, нийтийн бэлчээр гээд ингээд ангилж байгаа юм. Энэ ангиллын дагуу 1 дүгээрт явна. 2 дахь хамгийн чухал юм бол ерөөсөө сэлгэнэ. Жишээ нь энэ хуульд биччихсэн байгаа.

Өвөл хаврын бэлчээрийг зун, намар ашиглахгүй, сэлгээж байж нөгөө талхлалт бий болгохгүй байх ийм л арга хэмжээ авч байгаа юм.

2 дахь хамгийн том юм малчид дангаараа бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахгүй. Сандаг-Очир гишүүнээ бүлгээр явна, райоонаар. Энэ гол нутаг гол усныхан бөөнөөрөө юу гэдэг юм 20 өрх байдаг бол энэ 20 өрх нэг бүлэг болж, бэлчээрээ хуваарьтай ашиглана, бүлэг болж. Тэгэхээр 1 өрх дангаараа бэлчээр ашиглахгүй. Заавал бүлгээрээ бэлчээр ашиглана. Энэ нь нөгөө бэлчээрээ бүлгээр ашиглаж байгаа учраас таны яриад байгаа нөгөө бэлчээр ойр ойрхон орох гээд ингээд асуудлуудыг зохицуулж байгаа юм.

Отрын бүс нутаг гэдгийг, ер нь нөөц бэлчээрийн нөөц нутаг буюу отрын бүс нутгийг бүх түвшинд бий болгож байгаа юм. Баг 10 хувь нийт бэлчээрийн, сум 10 хувь, аймаг, 10 хувь нөөц бэлчээртэй байна. Хүндрэхээр нөөц бэлчээр лүүгээ орно. Огт нөгөө байгалийн бэрхшээл үүсээд ган гачиг үүсээд бэлчээргүй болбол тэр баг доторх малчдыг наашаа, цаашаа нөгөө отрын нөөц бэлчээр лүү орох асуудлыг багийн зохицуулна. Сум доторхыг сум зохицуулна. Аймаг доторх сумдын хоорондын асуудлыг аймаг зохицуулна. Аймгуудын хоорондын асуудлыг Засгийн газар зохицуулна. Тэгэхдээ заавал гэрээгээр, бас гэрээгээр. Отрын нөөц бүс, отрын бүс нутагт бол зөвхөн бэлчээрийн даацад тохирсон мал л оруулна. Бэлчээрийн даацад тохирсон мал. Манайх өнөөдөр энэ зохицуулалтууд байхгүй учраас нөгөө бэлчээрийн даацаасаа хэд дахин хэтэрсэн мал ороод, ингээд отрын бүс нутгуудынх нь сүүлийн үед маш их хэмжээгээр эмзэглээд байгаа юм. Тийм учраас цаашидаа отрын бүс нутагт бол ийм.

Бэлчээр хашихыг хатуу хориглож байгаа. Хашихыг. Малчин хүн өвөлжөө, хаваржаа дээрээ нэг га хүртэл газрыг эзэмшиж болно нэг удаа. Тэр нэг га газар

дээрээ малын тэжээлийн урвал болон хүнсний ногоо тариалах боломжтой. Өөрөөр бэлчээрийнхээ хашихыг хориглож байгаа. Ямар үр дүн хүрэх вэ гэж. Энэ 1990 оноос өмнө бол Монгол Улсад энэ бэлчээрийн менежментийн асуудал энэ байсан. Одоо энэ бид нарын энэ хуулийн төсөлд тусгагдсан асуудлууд бүгд нэгдлийн бэлчээрийн менежмент байсан байхгүй юу. Сэлгэдэг, отрын нөөц бэлчээр лүүгээ ордог бүх юмнууд байсан. Энэ менежментийг бол энэ хуулийн төсөлд оруулж өгсөн.

Ямар үр дүн гарах вэ гэхээр 1 дүгээрт бол бид нар малчид нөгөө бүлгээр байгаа учраас бүлгээрээ бэлчээрийг ашиглаж байгаа учраас даацаа тохируулах асуудлыг тэргүүн ээлжид авч үзнэ. Ер нь бид нар бол энэ малчдын өөрийнх нь бүлгийн малчдын өөрсдийнх нь санаачилгын үндсэн дээр л бэлчээрийнхээ даацад тохируулах асуудал байгаа юм.

2 дахь юм нь юу байна вэ гэхээр бүх шатын Засаг дарга нар, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, газрын албаныхан гээд энэ чиглэлийн хүмүүсийн эрх, үүргийг тодорхой болгож, хариуцаагийг тодорхой болгож өгсөн. Зөрчлийн тухай хуулийг энэ хуультай хамт Зөрчлийн тухай хууль оруулж ирсэн байгаа юм. Зөрчлийн хуулиар тэр бэлчээрийг нөгөө талхалсан, гэрээ зөрчсөн, янз бүрийн зөрчлийн маргаан үүсгэсэн эд нар бүгд Зөрчлийн хуулиараа нөгөө торгуулийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Яах вэ бид нар энд сайхан л ярьж байна л даа, төсөөлөөд ингээд. Яг амьдрал дээр бас нэг хэрэгждэггүй хуулиудын нэг болчих вий л гэж бодож байна. Яагаад гэхээр манай малчид чинь их дураараа улсууд шүү дээ. Тэр хууль яг амьдрал дээр бол хэрэг падлий ч байхгүй гээд л ярьдаг улсууд. Тэгээд та бол энэ отрын бүс нутагт тэгээд л ингээд бэлчээрийнхээ даацад тааруулж,

малчдыг, малыг оруулна л гэж байна. Өвөл зуд болоод ирэхээр энийг шууд л хэн түрүүлж орсон нь л буудаг, иддэг ийм л болчихдог байхгүй юу. Тэр тааруулах тоо квот, уг нь бол Хэрлэн Баян-Улаан гэхэд л квотууд өгдөг л байхгүй юу. Тэгээд тэр сүүлдээ бол бүр байхгүй болдог. Тэгээд л хэн түрүүлж орсон, хэн түрүүлж буусан нь л тэндээ өвөлжиж, хаваржаад л ингээд л явж байдаг ер нь. Тэгээд амьдрал дээр ер нь хэрэгжүүлэхэд зохицуулахад маш хүнд. Тэгээд ингэсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээг нь яаж тодорхой оруулж ирж байгаа юм, хариуцлагын арга хэмжээг нь л тодорхой.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүн санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууж, үг хэлье.

С.Ганбаатар: Эрх баригчдаа үгүй ээ нэг хааяа нэг ийм хууль оруулж ирж байвал магнайгаа хагартал баярлаж байгаагаа илэрхийлье. Энэ бол үнэхээр чухал хууль. Энэ нарийн яривал уралдаж бэлчээрээ идэж ширдэг болгож байгаа энэ хүнд үед гарц гаргалгаа авчирсан сайн хууль байна. Энэ дээр бол эзэмших гэж байгаа юм шүү, бас өмчлүүлээгүй байгаа шүү энэ чинь эзэмших. Энэ бол ашиглах. Энэ хуулийн хэллэг нь бол эзэмших гэж байна лээ шүү, эзэмших гэж орж ирж байна та нар харах юм бол. Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, Бэлчээрийн ашиглагчдын холбоо гэж арваад жил миний мэдэхийн байгаа. Эд нарыг яг ажилд оруулж байна. Энэ яг зөв. Бэлчээрийн ашиглалтын гэрээ байгуулах загвар журам энийг дагаад гарна. Энэ дээрээ судалгаа бэлтгэл ажлыг хэр хийсэн бэ? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт энэ хууль би хуулийн процессыг нь сайн мэдэхгүй байна. Ер нь хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд дараа нь Газрын нэгдсэн хуультайгаа хамтарч нэгдэж орж ирнэ гэж би ойлгож байгаа. Учир нь гэвэл зүгээр төсөөлөөд бодох юм бол 140

мянган малчин өрх байгаа. Тэгээд өвөлжөөгөөр тооцоод өвөлжөө, хаваржаа 1,5 гагаар тооцох юм бол 210 мянган га-гийн тухай ярьж байгаа юм шүү зүгээр төсөөлсөн том тооцоогоор. Тэгэхээр энэ 210 мянган га-гийн тухай ярьж байгаа учраас Газрын хуультайгаа нэгдэж, нягтарч оруулж ирэх ёстой. Би хуулийг дэмжиж байгаа. Засгийн газар энэ судалгааны ажил дээр яагаад дэмжээгүй оруулж ирсэн юм бэ? Дүгнэлт дээрээ дэмжээгүй байна лээ шүү. Энийг би 2 дугаарт нь тодруулъя. Яагаад? Хамгийн дэмжих ёстой чухал хуулийг Засгийн газрын дэмжээгүй тодорхойлолт орж ирсэн байна лээ.

3 дугаарт миний асуулт. Энэ талаар бүсчилсэн байдлаар миний асуулт бол нэг га-аас хэдий хэмжээний төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ хурааж авах вэ, яг өрхийн хэрэгцээг яаж хангах вэ гэсэн тооцоо судалгаа одоо энэ материал дээр бол алга байна. Энэ миний 3 дугаарт энэ асуудал хэрэгжиж байгаа юу? Тэгээд хуулийн хэллэг дээр бол яах вэ нэг ийм үг байгаа юм. Таримал ургамал гэдэг дотор тэр ногоон тэжээл орж байгаа биз дээ гэдгийг би асуучихъя. Таримал ургамал гээд ярьчихсан байна. Ер нь эцсийн эцэст бэлчээрийн мал аж ахуй одоо бол бас хүндэрчихсэн. Бид чинь 20 сая малтай болох гэж зүтгэдэг байсан улсууд, одоо энэ жилийн төлийг оролцуулаад хонин толгойд шилжүүлэх юм бол 120 сая хоньтой болж байгаа ард түмэн шүү дээ. Хүссэн ч, хүсээгүй ч бид эрчимжүүлсэн, хагас эрчимжүүлсэн байдал руу орохоос өөр аргагүй. Ингэхээр малчдад энэ эрх чөлөөг өгч, нэг га-д нь тэжээлийн ногоон тэжээл тарих, 1,5 га өвөлжөө, хаваржаа гэдэг энэ байдлыг бий болгохоос өөр аргагүй.

Хамтраарай, хоршоолоорой гэж 30 жил яриад бид бараагүй. Энэ дээр бол бэлчээр ашиглагчдын нэгдсэн байдлаар гэрээгээ хийгээд, хамтран ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлсэн ухаалаг хууль гарч ирсэн байна. Энийг юун азаар ийм юм санаачлав. Та нарын толгойд бас хааяа

ийм юм орж ирдэгт би баярлаж байна. Ингээд би 4 асуулт асуулаа. Асуултдаа би хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагч Тогтохсүрэн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Би нэг статистик хоёрхон тоо эхлээд хэлчихье гэж бодож байгаа. Ганбаатар гишүүн чухал саналууд хэллээ. 1 дүгээрт Монгол Улс 1,5 сая хавтгай дөрвөлжин километр нутгийн чинь 70 хувь нь буюу 110 сая га-д шилжүүлэх юм бол 110 сая га нь бэлчээр байгаа юм. Нийт нутгийн 70 хувь нь. Тийм 120 орчим сая. Энэ 120 орчим сая бэлчээрийн маань 20 орчим хувь нь бол ний нуугүй ярихад талхлалтад ороод, цөлжчихөөд байгаа юм. 65 хувь нь доройтоод ургамлын бүтцэд нь өөрчлөлт орчихоод байгаа юм. Нэгэн наст голдуу ургадаг болчихоод байгаа юм. Нөгөө олон наст нь болиод.

Мэдээж олон шалтгаан бий. Хур тунадасны энэ дэлхийн дулаарал, хур тунадасны оролт гээд олон зүйл хүчин зүйл бий. Гэхдээ нэг том хүчин зүйл нь яахын аргагүй манай энэ мал аж ахуйн салбарын тооны өсөлт байгаа юм. Монгол Улсын нийт бэлчээр хонин толгойд шилжүүлэхэд 100 бишээ нь 86 сая хонь бэлчээрлэх боломжтой гэж байгаа юм. Одоо бол нэг таны хэлж байгаагаар ойролцоо Хөдөө аж ахуйн яамны гаргасан тоо 126 орчим сая хонин толгойд шилжүүлэхэд мал байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ ямар хэмжээгээр хэтэрсэн байна вэ гэдэг бол харагдаж байгаа юм. Маш сайн. Энэ хуулийг би ингэх ёстой л гэж бодож байгаа. Манай Их Хурлын гишүүд бүгдээрээ л орон нутгаас сонгочихсон гишүүд. Одоо энийг би хэлэлцэх эсэхийг нь ингээд шийдчихвэл манай гишүүд бүгдээрээ энэ хуулийг аваад сумдаа очоод, энэ хуулийг танилцуулаад, багийнхаа иргэдийн нийтийн хурлуудыг хийлгэж энийг яриад, малчдынхаа саналыг сонсоод, манай баг хэрэв энэ

хууль хэрэгжвэл сая Сандаг-Очир гишүүний ярьж байгаа үнэн. Хэрэгжихгүй хууль гарчих вий гэж санаа зовж байгаа дээр бид нар нэг байгаа. Тэгээд ингээд манай сумд энэ хууль хэрэгжихээр манайх ямар, ямар бэлчээртэй болмоор байна, яаж малчдын бүлгээ зохион байгуулах вэ, хил заагаа яаж тогтоох вэ, нийтийн бэлчээр буюу ус хужиртай газраа яаж авч явах вэ, өвөлжөө хаваржааны бэлчээрээ яах вэ, отрын нөөц нутгаа хаана байлгах вэ гээд сум бүр энэ чиглэлээр өөрөө өөрсдөө нэг сайн ярилцах хэрэгтэй байгаад байгаа юм.

Тийм учраас бид нар энэ хуулийг батлах гэж яарахгүй. Бүх гишүүдийг харин хамруулж, орон нутагтаа сайхан хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулж, олон малчдын санал бодлыг л заавал тусгаж, манай сум хэрэгжих юм бол ингэх юм байна гэдэг л нэг ийм л төсөөллийг бий болгож байж энэ хуулийг батлах ёстой гэдэг ийм саналтай байгаа юм.

Тэр бэлчээр ашиглагчдын гэрээний загварыг нөгөө сум, аймгийн иргэдийн хурал батална. Орон нутаг л батална энийг. Энд өөр, өөр. Монгол Улс чинь байгалийнхаа бүс бүслүүлээр өөр, өөр байгаа юм. Сүүлийн үед нөгөө нүүхээ больсон худаг гаргаад. Энэ нь бол талхлалд нь маш хүчтэй нөлөөлж байгаа юм. Манай бид нар судалгаа хийж үзсэн. Увс аймаг гэхэд хамгийн олон нь жилд 10-12 нүүж байгаа юм. Увс аймгийн зарим сумд, тийм. Тийм учраас бол нөгөө сум, аймгийн онцлогт тохируулж л энэний дараа журмууд, гэрээний маягт загварууд, бүлгээр ажиллахтай холбоотой асуудлуудыг бол бид нар энэ хуульд сум гаргана, аймаг гаргана гээд л дандаа ингэж бичээд байгаа. Энэ нөгөө орон нутгийнхаа онцлогт тохируулж л өөрөө өөрсдөөр нь гаргуулах ийм л бодолтой байгаа юм.

Засгийн газар 14 санал өгсөн. Засгийн газар 14 санал өгсөн. 12 саналыг нь бид авсан. Тусгаж авсан. 2 саналыг бол

аваагүй. Тухайлбал энэ бүлгээр ажиллахыг Засгийн газар болохгүй гэсэн байна лээ. Бүлгээр л малчид гэрээгээр ашиглахгүй бол дангаараа ашиглах юм бол ямар ч бололцоо байхгүй байгаад байгаа юм. Таримал ургамал бол малын тэжээлийн ургамал байгаа. Бид нар малын тэжээлийн ургамал бол тариалахыг дэмжинэ. Гэхдээ аль болохоор бэлчээрийг хашаалахыг дэмжихгүй гэдэг л байр суурь байгаа юм. Манай өмнөд хөршийн Өвөр Монголын өөртөө засах орны муу туршлага бол хашаалсанд байгаа юм гээд байгаа юм. Бэлчээр нь эзэндээ очсон сайн, ганц дутагдал нь хашаалсанд байгаа юм шүү гээд байгаа юм. Тийм учраас бол энийг бас авч үзэж, бид нар аль болохоор хашаалахыг хориглож байгаа.

Дээр нь энэ хууль зөвхөн энэ малын талхлалтаас бэлчээрийг хамгаалахаас гадна, авто замын талхлалтаас хамгаалах, уул уурхайн үйлдвэрлэлээс хамгаалахтай холбоотой асуудлыг бас энэ хуульд тусгаж өгсөн байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу Ганбаатар гишүүн? Манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бол Улсын Их Хурлын чуулганы, Байнгын хороогоор хэлэлцэж байгаа асуудлуудад бол сайн бэлтгэлтэй оролцдог, хуулийн төсөл болон холбогдох хууль тогтоомжийн төслүүд дээр тусгайлан санал гаргаж, Байнгын хороо, хууль санаачлагчдад бол дандаа бичгээр өгч байгаа. Түүнээс гадна хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан зарчмын шинжтэй олон асуудлуудыг хөндөж, чухал санал санаачилга гаргаж, оролцож байгаа гэдгийг бас тэмдэглэн хэлье. Ганибал гишүүн үг хэлнэ. Ганибал гишүүн, Тэмүүлэн гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Ганибал гишүүн нарын санаачилсан хуулийн төсөл байгаа тийм ээ. Тэрийгээ бас нэгтгэж хэлэлцэх талаар нь бас саналаа хэлчихвэл бас зүгээр юм байна тийм ээ. Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Байна уу? Үгүй ээ үгүй, энэ бас хуулийн санаачлагчдын нэг л дээ. Тийм хууль санаачлагчдын нэг. Тэгэхдээ яах вэ зүгээр ер нь зүгээр тийм саналаа хэлэх гээд байгаа юм. Тийм. Ер нь энэ хууль бол яг одоо бараг Үндсэн хуулийн дараах хууль юм уу даа л гэж би бараг боддог. Тухайн салбарт ажиллаж байхдаа энэ хуулийг бас оруулж ирэх гэж үзээд бараагүй. Энэ яг бэлчээрийн газрын тухай энэ хуульд бэлчээрийн асуудал орж ирж, 2010, 2005 онд нэг орж ирсэн байх. 2015 онд орж ирсэн. Тэгээд нэг ч өөрчлөгдөөгүй байхгүй юу. Одоо хүртэл тэр олон жилийн өмнө батлагдсан юу нь бэлчээрийн тухай асуудлаараа л өнөөдрийг хүртэл бид нар яваад байгаа юм. Харин өнөөдөр ингээд энэ хууль маань бид нар энэ цаг хугацаанд баталж чадах юм бол үнэхээр бас Монголын өнөөдөр яг тулгамдаж байгаа гол асуудлыг бид нар шийдэх энэ үндэс бий болох юм.

Тэгээд бэлчээр дээр мэдээж маш олон бэрхшээлүүд байгаа. Бэрхшээл болгоны ард бол бүгдийг нь хуулийн зохицуулалтууд бас шаардагдана. Гэхдээ энэ удаагийн хуулийн хамгийн чухал нь энэ зунжин бид нар малчидтайгаа уулзаж, энэ хуулийг хэлэлцүүлбэл хамгийн үр дүнтэй хууль болно. Хамгийн үр дүнтэй хууль болно. Бидэнд өнөөдрийн Газрын тухай хуульд заасан бэлчээрийн тухай заалтууд маань дэндүү бас ингээд мал цөөхөн байх үед, өнөөдрийн дэлхийн дулаарлын асуудлууд, ургамлын гарцын асуудлууд гээд олон асуудлуудыг өмнө нь тааламжтай байх үеийн бас хуулиудыг өнөөдөр бид нар ашиглаад байгаа юм.

Тэгээд энэ дээр бас нэмээд нэг санал байна. Энэ хуулиа дэмжиж байгаа. Дээр нь бас Бат-Эрдэнэ гишүүн, Тэмүүлэн гишүүн, Ундрам гишүүн, Мөнхбаатар гишүүн бид бас нэг Газрын тухай хуульд шууд утгаар нь хэлэх юм бол нөгөө өвөлжөө, хаваржааны 1 га-г 1,5 больё гэсэн хуулийн төсөл өргөн барьсан юм. Тийм, хамтатгаад. Тэгэхээрээ энэ хууль маань бол мэдээж бэлчээрийг зөв

зохистой ашиглах, хамгаалах энэ тал дээрээ түлхүү байгаа.

Одоо бид нарт бас ургуулах гэдэг асуудал байгаа. Бид нар бэлчээрийн нөөцүүдийг бий болгох, тэр ногоон тэжээл, олон наст ургамал тэрийгээ бас тодорхой хэмжээнд өөрсдийнхөө хэрэгцээнд тарьж сурдаг энэ цаг хугацаа бидний өмнө тулгараад байгаа юм, манай малчдын өмнө. Тэгэхээр энэ асуудлууд маань нийлүүлээд хэлэлцүүлээд, илүү чамбайруулаад ингээд гаргавал энэ хууль бодит амьдрал руу илүү түлхүү нийцнэ л дээ. Сандаг-Очир гишүүний хэлээд байгаа асуултууд бүгдээрээ үнэн байхгүй юу. Мааш олон асуудлууд байгаа. Аймаг дундын отрын бүс нутгийн асуудал байна. Сум дундын отрын бүс нутаг, цаашилаад сумын нөөц бэлчээрийн асуудлууд. Энэ дээр ч гэсэн бид нар эрх зүйн хувьд мааш зоригтой шийдлүүд хийж байж энэ асуудлуудын ард гарна. Нэлээн зоригтой шийдлүүд. Тэгэхээр энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад бол энэ асуудлууд маань бүгдээрээ орж ирж бас шийдэгдэнэ байх гэсэн итгэл үнэмшил байгаа. Тэгээд энэ хуулиа дэмжиж байна. Тэгээд саналаа хэлчихье.

Л.Мөнхбаатар: Наянтайн Ганибал гишүүн дэмжиж үг хэллээ. Санал хураалт явагдана, гишүүд танхимдаа орж ирье. Батжаргал гишүүний өрөөнд сууж байгаа 4 гишүүн орж ирье. Туваан гишүүний дараа санал хураалт явагдана. Улсын Их Хурлын 14 дүгээр тойргоос сонгогдсон эрхэм гишүүн Цэвэгдоржийн Туваан үг хэлнэ.

Ц.Туваан: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа мааш чухал асуудал. Энэ дотор хамгийн гол зохицуулах харилцаа бол энэ бэлчээрийн асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол энэ өөрчлөлт бол нэлээн тийм төвлөрсөн чиглэсэн ийм харилцаа болчихоод байгаа юм. Бэлчээр бүр эзэнгүйдэх биш бүр байхгүй боллоо. Одоо бид нар зүгээр эргээд л хар, эргэн тойрон ингээд хар, хөдөө орон нутаг яваад үз. Дандаа нэг

одоо, нэг наст тийм борог байхгүй ийм шалдан ногоотой л боллоо. Тэгэхээр энэ бэлчээрийн асуудал бол үнэхээр Монгол Улсын хэмжээний үндэсний аюулгүй байдлын хэмжээний том асуудал болсон.

Зөвхөн энэ хөдөөгийн малчид хохирох юм шиг бодож болохгүй асуудал. Бэлчээргүй болвол хөдөө орон нутагт мал маллах малчингүй болбол малчид бүгдээрээ хаачих вэ төв суурин газар бараадна. Тэгээд яах вэ нөгөө яндан, нөгөө түгжэрэл, нөгөө олуулаа хот суурин газарт бөөгнөрдөг энэ асуудлууд чинь гарч ирэх юм. Энийг зөвхөн малчдын асуудал гэж ингэж хармааргүй байгаа юм. Бид хэд Монголчууд бол ерөөсөө ярьж ирсэн шүү дээ. Хаяа багтвал буудаг, хамар багтвал иддэг л ийм байсан. Одоо тэр цаг өнгөрсөн. Одоо тэгж иддэг, хаяа нийлж буудаг байдал бол боломжгүй болсон. Мал ч их өссөн.

Сая Ганбаатар гишүүн хэлж байна. 120 гаруй сая толгой мал хонин толгойд шилжүүлбэл ингээд бий болчихоод байна. Тэгэхээр би энэ дээр энэ хууль дээр хууль санаачилсан энэ хүний хувьд бас нэг зүйлийг анхаармаар байна. Нөгөө талаас нь яримаар байгаа юм. Тэр нь юу гэхээр энэ яагаад ийм нөхцөл байдал үүсчхэв гэдгийн нэг тал нь бол энэ төрийн буруу байгаа юм. Улсын Их Хурал энэ дээр анхаарал тавих, хандуулалгүй, Бэлчээрийн хууль гэхээр л нэг гал барих гэж байгаа юм шиг ингэж халгаж, тойрч гүйсээр байгаад ийм байдалд хүрчихсэн юм.

Дээрээс нь энэ малчдын бэлдэж өгч байгаа хүнсний болон хөнгөн үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүний үнэ хани дэндүү унасангай холбоотой. Малчин хүн ноосоо үүрээд, махаа үүрээд, ноолуураа бариад Эрэн, Казахстан, Дундад Ази, Солонгос оруулж чадахгүй, Вьетнам оруулж чадахгүй. Энийг хэн хийх ёстой төр хийх ёстой. Одоо бол тэр мянгат болоод, өөрсдөө ядарч үхтлээ ажиллаад, маллаад, өвчний үүр болоод ингээд олон малтай байх хоббитой малчин гэж байхгүй болсон. Яах аргагүй амьдралын

эрхээр л энэ олон малтай байгаад байна. Тэгэхээр юу хэлж байна вэ гэхээр малын үнэ цэнийг өсгөх ёстой, махыг өсгөх ёстой, арьс шир, түүхий эдийн үнийг өсгөх ёстой л болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг маш хурдан борлуулах ажлыг бол төр хийхгүй байгаатай нэг асуудал байгаа юм. Тэгэхээр одоо бид нар энэ дараа дараагийн хэлэлцүүлгийн явцад энэ малчид малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх тал дээр л бас нэг бодлого гаргаж ирж явахгүй бол болчихоод байгаа юм гэдэг нэг талын өнцгийг хэлмээр байна.

2 дугаарт энэ дээр Тогтохсүрэн дарга нэг юм байгаа нь одоо хөдөө мал маллах хүн олдохоо больж байгаа юм. Малчдын тоо буурч байгаа, залуу малчид малчин бүүр гэр бүлтэй залуу малчин гэдэг бол маш том асуудал болж байгаа шүү. Тэгэхээр юу хэлж байна гэхээр энэ малчид маань ингээд бүлэгт ороод ингээд явахаар нөгөө бүлэг чинь нэг шинэ малчид, одоо шинэ залуу гэр бүл болоод гараад ирлээ гэхэд бас л хүн нэмэгдэж байгаа байхгүй юу. Хүн нэмэгдэхээр мэдээж мал нэмэгдэнэ ингээд бас тэлнэ. Тэгэхээр энэ асуудлыг нэлээн алсыг бодож бас зохицуулалтыг нь оруулж хийж өгөхгүй бол хот газраас хүн магадгүй малчин больё гээд хүрээд ирэхэд, залуу хүн гэр бүл болоод малчин өрх болоод гарахад энэ асуудлыг нэлээн сайн тусгаж өгөхөд нь зүйтэй шүү гэж ингэж бодож байна. Яагаад гэхээр манайд гэр бүлгүй эрчүүд залуу малчид маш олон болсон. Нэг сумд 50, 60-аараа бий болсон. Тэгэхээр энэ асуудлыг бас бодож, энэ хуулийг батлах нь зөв байх гэж ингэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт

орлуулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүдээ. 59 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

19.47 цаг

Өнөөдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудал дууссан тул, үгүй ээ, дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА